

Соёлын өвийг хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Улаанбаатар хот
2024 он

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Удиртгал	4
НЭГДСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	9
Нэг. Соёлын өвийн ангилал, зэрэглэл.....	19
1.Соёлын биет өв.....	19
<i>Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх асуудал.....</i>	<i>21</i>
2.Соёлын биет бус өвийн тухай	22
3.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч.....	25
4.Соёлын өвийн зэрэглэл.....	28
<i>Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх асуудал.....</i>	<i>28</i>
<i>Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх асуудал.....</i>	<i>30</i>
Хоёр.Соёлын өвийг хамгаалах төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, тэдгээрийн уялдаа холбоо	32
<i>Засгийн газар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо, дүрмийг баталсан эсэх</i>	<i>33</i>
<i>Засгийн газар соёлын өвийн үзлэг, тооллого хийх, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг баталсан эсэх</i>	<i>34</i>
<i>Засгийн газар улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталсан эсэх.....</i>	<i>34</i>
<i>Засгийн газар түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг баталсан эсэх.....</i>	<i>35</i>
<i>Засгийн газар дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан эсэх</i>	<i>35</i>
<i>Засгийн газар соёлын биет өвийг хувиан олируулах, гэрэл зураг, дүрс бичлэг хийх журмыг баталсан эсэх</i>	<i>35</i>
<i>Засгийн газар соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг журмыг баталсан эсэх</i>	<i>35</i>
<i>Засгийн газар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалт болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтыг баталсан эсэх</i>	<i>36</i>
<i>Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журмыг баталсан эсэх</i>	<i>36</i>



Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталсан эсэх	36
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг баталсан эсэх.....	37
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага палеонтологийн, археологийн, соёлын биет бус өвийн, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн, соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан эсэх	37
Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх журам баталсан эсэх.....	37
Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харьяалах нутаг дэвсгэр дэх түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалах чиглэлээр санал гаргасан тохиолдол бий эсэх.....	37
Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталсан тохиолдол бий эсэх.....	38
Гурав.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо	38
1.Бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо	40
2.Соёлын өвийг бүртгэх бүртгэлийн харилцаа	40
Соёлын өвийг бүртгүүлэх субъектын тухай	40
Соёлын өвийг хэрхэн бүртгэхтэй холбогдох эрх зүйн хэм хэмжээний тухай	41
Соёлын өвийг бүртгэн баримтжуулалтын хүрээнд төрөөс хэрэгжүүлж буй бодлого	47
Дөрөв.Соёлын өвийн судалгаа	48
1.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа ба Мэргэжлийн зөвлөл	50
2. Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх болон соёлын биет бус өвийн судалгаа хийхэд олгох зөвшөөрөл	50
3.Соёлын биет бус өвийн судалгаа	52
4.Соёлын өвийн судалгаатай холбоотой бусад орны туршлага: Бүгд найрамдах Солонгос Улс	54
Тав.Соёлын өвийн үнэлгээ.....	55
Зургаа.Соёлын өвийг эзэмших, ашиглах, өмчлөх.....	60
1.Соёлын өвийг эзэмших, өмчлөх	61
2.Соёлын биет өвийг худалдах	64
Долоо.Соёлын өвийг хамгаалах болон хяналтын тогтолцоо.....	64
Соёлын хяналтыг хэрэгжүүлдэг улсын байцаагчийн эрх зүйн байдал Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотойгоор хэрхэн өөрчлөгдсөн	



<i>тухай болон хяналтын чиг үүргийн хэрэгжилтийн практик төлөв байдлыг тогтоох нь</i>	66
<i>Соёлын салбарын хяналтын тогтолцоо, бүтэц, орон тоо</i>	67
<i>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотой соёлын хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон баримт бичигт гарсан өөрчлөлт, түүний хэрэгжилтийн үр дагавар</i>	67
<i>Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтоох тухай хэм хэмжээний хэрэгжилт</i>	68
<i>Палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгохыг хориглох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагавар</i>	69
Найм.Соёлын өвийг сэргээн засварлах	69
1.Соёлын биет өвийг сэргээн засварлах өнөөгийн нөхцөл байдал	70
2.Соёлын биет өвийг сэргээн засварлах зарчим.....	73
Ес.Соёлын өвийг сурталчлах харилцаа	75
Арав.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх асуудлаар	76
1.Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль	77
<i>Соёлын биет өвийг завиш, үрэгдүүлэх</i>	79
<i>Соёлын биет өвийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх</i>	80
2.Соёлын биет өвийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага ба бусад улсын туршлага	81
<i>Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах</i>	81
<i>Соёлын биет өвийг завиш, үрэгдүүлэх</i>	82
<i>Хулгайлах</i>	83
3.Соёлын биет өвд учруулсан хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх.....	83
4.СӨХТХ-ийн хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүй, түүнд хүлээлгэх хариуцлага	84
Хавсралт 1: Бүгд найрамдах Солонгос Улсын Археологийн судалгаа, байгалийн болон биет бүс соёлын өвийн судалгаа	86
Хавсралт 2: Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүйн жагсаалт, харьцуулалт	91

Удиртгал

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн “... төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм, цогцдуулан хөгжүүлэх эрхэм зорилго...”-ын хүрээнд¹ “...Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна²”, “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ³” гэж Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, хууль тогтоомжуудыг баталж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар олон талт үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Тухайлбал, Монгол Улсын түүх, соёлын дурсгалт үнэт эд зүйлсийг хамгаалахтай холбоотой нийгмийн харилцааг 1990 оноос өмнө 1970 онд батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулиар зохицуулж байсан бол ардчилал, зах зээлийн эдийн засгийн шинэ харилцаанд шилжсэнээс хойш 1994 онд “Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль” болон 2001 онд “Соёлын өвийг хамгаалах тухай⁴” хуулиар, 2014 онд Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг Монгол Улсын Их Хурлаас баталсан байна.

Мөн соёлын өвийг хамгаалах талаар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Эрдэнэсийн сангийн тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай, Архивын тухай, Гаалийн тухай хуулиуд тодорхой тусгасан.

Түүнчлэн, Монгол Улс 1990 онд Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай (товчоор Дэлхийн өвийн Конвенц хэмээн нэрлэдэг), 1991 онд Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай, 2005 онд Соёлын биет бус өвийг хамгаалах тухай, 2007 онд Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай ЮНЕСКО-гийн Конвенцод тус тус нэгдэн орсноор үндэсний соёлын өв, дурсгалуудаа ЮНЕСКО-д бүртгүүлэн алдаршуулах, хадгалалт хамгаалалтыг нь шинэ түвшинд хүргэх, үндэсний уламжлалт соёлоо хүн төрөлхтний соёлын дэвшилтэт ололттой жишиглэн нийцүүлж хөгжүүлэх, дэлхий нийтэд сурталчлах, соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг тэлэх шинэ боломж нээгджээ.⁵

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.7-д “монгол соёл иргэншлийн аюулгүй байдал”⁶ нь Үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэсэг болохыг хуульчилсан. Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 1.1.6-д Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний

¹ «Монгол Улсын Үндсэн хууль», accessed 20 Гуравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>.

² Монгол Улсын Үндсэн хууль, sec Долдугаар зүйлийн 1 дэх хэсэг.

³ Монгол Улсын Үндсэн хууль, sec Арав дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

⁴ Тус хуульд 2001, 2003, 2004, 2005 онуудад нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

⁵ Өмнө Монгол Улс 1964 онд “Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай” 1954 оны Гаагийн хэлэлцээрт нэгдэн орж түүний үзэл санаа, зорилтыг хүлээн зөвшөөрч, тууштай дэмжиж ирсэн юм. Ийнхүү олон улсын конвенциудад Монгол Улс нэгдэн орсон нь соёлын өвийг хамгаалах үйлс болон түүний эрх зүйн орчинг бэхжүүлэхэд үндсэн эргэлт болсон билээ. Түүнчлэн эдгээр конвенцод нэгдэн орсноор манай улс түүх, соёлын үнэт дурсгалаа “Дэлхийн өвийн жагсаалт”-д бүртгүүлэх, тэдгээрийг хадгалж хамгаалах, сэргээн засварлахад мэргэжилтний болоод хөрөнгийн талаар олон улсын байгууллагын дэмжлэг туслалцааг авах таатай боломж нээгдсэн юм.

⁶ «Үндэсний аюулгүй байдлын тухай хууль», sec 3 дугаар зүйлийн 3.4.7 дахь заалт., accessed 22 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=18>.



оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн⁷ хэмээн зарлаж, үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга замыг тодорхойлон авч үзэхдээ соёл иргэншлийн аюулгүй байдлын хүрээнд монгол үндэстний соёл, түүхийг дэлхий дахинаа сурталчлах, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлэх, түүх соёлын иргэншлийн өвийг сурвалжлан олох, судлах, эх орондоо эгүүлэн залах, сэргээн засах чиглэлээр иргэдийн санал, санаачилгыг дэмжиж, гадаад оронтой идэвхтэй хамтран ажиллах эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээ авах зэрэг үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Монгол Улсыг хөгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-д⁸ үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох зорилт дэвшүүлж, нүүдлийн соёлоо хадгалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, үндэсний үнэт зүйлд суурилсан соёлын дархлааг тогтвортой бэхжүүлэх, соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, бүтээн үргэлжлүүлэх, өвлөн уламжлах үйл ажиллагаанд оролцогч талуудыг дэмжих, боловсролын сургалтын хөтөлбөрт нүүдэлчин ахуй, зан заншил, соёлын өвийн агуулгыг тусгаж, үндэсний өв соёл, уламжлалт наадгайн төрлийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх, соёлын өргөө, төвүүд, соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгох, бүс нутгийн хэмжээний музей, төвийг байгуулах, хилийн чанад дахь монгол соёлын өвийг сурвалжлан олох, судлах, эх орондоо эргүүлэн залах зэрэг зохицуулалт тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газраас соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах үндэсний хөтөлбөр, “Морин хуур, уртын дуу”, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”, “Монголын уламжлалт бий, биелгээ”, “Монгол тууль”, “Монгол цуур”, “Монгол хөөмэй”, “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”, “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Чулуун соёлын өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр” зэрэг үндэсний хөтөлбөрүүдийг 2005-2021 оны хооронд хэрэгжүүлсэн байна.

2012, 2020 онд Засгийн газрын бүтцэд Соёлын асуудал эрхэлсэн яам дангаараа байгуулагдан ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурал (цаашид “УИХ” гэх) 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Соёлын өвийг хамгаалах тухай хууль (цаашид “СӨХтХ” гэх)-ийн⁹ шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд хуулийг 2014 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлснээс хойш даруй 11 дэх жилдээ хэрэгжүүлж байна. Ийнхүү хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 2015 онд 1, 2016 онд 1, 2020 онд 1, 2021 онд 3, 2022 онд 2, 2023 онд 2, 2024 онд 1 нийтдээ¹⁰ 11 удаа тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь:

- 2015 онд баталсан Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/;

⁷ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол, «Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай», accessed 22 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208070&showType=1>.

⁸ Монгол Улсын Их Хурлын тогтоол, «“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай», 52 §, sec Монгол Улсын Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 1.2 тусгасан, accessed 16 Аравдугаар сар 2023, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15406>.

⁹ *Төрийн мэдээлэл эмхэтгэл (2014)*, n.d., chap №23 дугаарт.

¹⁰ «2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар», n.d.



- 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Музейн тухай хууль;
- 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан хуулийн төслүүдийн хамт;
- 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулж;
- 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг дагаж;
- 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/;
- 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудыг дагаж нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Дээрх СӨХтХ-д оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь бүгдээрээ бусад хууль тогтоомжийг дагаж нэмэлт, өөрчлөгдсөн байгаа нь уг хуулийн анхны үзэл баримтлал, үндсэн бодлогод хэрхэн нөлөөлсөн талаарх дүн шинжилгээг хийх суурь нөхцөл үүссэн гэж үзлээ.

Анх батлагдахдаа	Нэмэлт, өөрчлөлт оруулсан
13 бүлэг 61 зүйл, 428 хэсэг, заалт	162 хэсэг, заалт

СӨХтХ нь анх батлагдахдаа 13 бүлэг 61 зүйл, 428 хэсэг, заалттай батлагдсан бол түүнээс хойш 162 хэсэг, заалтад ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт орсон байна. Ялангуяа 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хуулиудыг дагаж оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь томоохон өөрчлөлт хийгдсэн байна.



СӨХТХ-д ийнхүү олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа уг хуулийн бүтэц, уялдааг алдагдахад хүргэсэн, хууль дахь нэр томьёо, заалтын найруулга зэрэг нь ойлгомжгүй, Засгийн газар, Засгийн газрын гишүүнд дүрэм, журам, аргачлал батлах 30 гаруй эрхийг олгосны улмаас хуулийг практикт нэг мөр хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч байгаа нь ажиглагдлаа.

Энэхүү судалгааны хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуулийн¹¹ 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж зааснаар СӨХТХ-ийн зохицуулалтын хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийлээ. Үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан гүйцэтгэсэн болно.

Ингэхдээ СӨХТХ-ийн шинэчилсэн найруулгад үзэл баримтлал, агуулгын хувьд 2001 оны СӨХТХ-аас шинэлэг байдлаар хуульчилсан зохицуулалтыг сонгон авч, практик хэрэгжилтийг үнэлэхийг эрмэлзэв. Тодруулбал, 2014 оноос хойш СӨХТХ-д шинээр зохицуулсан дараах асуудлыг судалгааны объектоор сонголоо:

(1).Соёлын өвийн ангилал, зэрэглэл; (2).Соёлын өвийг хамгаалах төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, тэдгээрийн уялдаа холбоо /давхардал, хийдэл, зөрчил/; (3).Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо; (4).Соёлын өвийн судалгаа; (5).Соёлын өвийн үнэлгээ; (6).Соёлын өвийг эзэмших, ашиглах, өмчлөх; (7).Соёлын өвийг хамгаалах болон хяналтын тогтолцоо; (8).Соёлын өвийг сэргээн засварлах; (9).Соёлын өвийг сурталчлах харилцаа; (10).Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх асуудал зэрэг сонгож авлаа.

Судалгааны зорилго:

- Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зарим тодорхой зүйл, заалтын зохицуулалт анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаа, тэдгээрийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох, урьдчилан тооцоолоогүй бусад үр дагавар гарсан эсэхийг тодорхойлох;
- Хуулийн цаашдын үр дагавар, нөлөөллийг илрүүлэн гаргаж цаашид хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхэд дүгнэлт өгөх.

Судалгаа хийсэн байдал:

Судалгаа явуулах хүрээг тогтоох зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний Комисс, Нийслэлийн соёл урлагийн газар, Чойжин ламын сүм музей зэрэг байгууллагын удирдлага, албан хаагчидтай уулзалт-ярилцлага зохион байгуулсан, мөн холбогдох эх сурвалжид дүн шинжилгээ хийж, шүүхийн шийдвэрүүд судалсан бөгөөд энэхүү ажиллагаагаар цуглуулсан мэдээлэлдээ дүн шинжилгээ хийж Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээнд хамрагдах зүйл, заалтуудыг тодорхойлж, харгалзах шалгуур үзүүлэлтийг сонгон томъёолсон болно.

¹¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015) №25.



Судалгааг гүйцэтгэхдээ эрх зүйн харьцуулалтын арга, тайлан, статистикийн тоо баримтад дүн шинжилгээ хийх, хуулийг хэрэгжүүлэн ажиллаж буй төрийн албан хаагч ажилтнуудтай ярилцлага хийх зэрэг аргыг ашигласан.

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

Зөвлөх судлаач Т.Алтангэрэл	“Оюуны-Инноваци” ТББ-ын УЗ-ийн дарга, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Үндсэн судлаач Б.Төрболд	“Оюуны-Инноваци” ТББ-ын Гүйцэтгэх захирал, Хууль зүйн магистр (LL.M)
Үндсэн судлаач Б.Эрхэмбаяр	“Оюуны-Инноваци” ТББ-ын судлаач, хуульч
Үндсэн судлаач Б.Батбаяр	Хуульч, Хууль зүйн магистр (LL.M)
Үндсэн судлаач М.Пүрэвсүрэн	Хуульч, Хууль зүйн магистр (LL.M)
Үндсэн судлаач Ш.Ичинхорлоо	“Оюуны-Инноваци” ТББ-ын судлаач



НЭГДСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Нэг.Соёлын өвийн ангилал, зэрэглэлтэй холбоотой асуудлын хүрээнд

1.Байгалийн өвийг хамгаалах зорилгоор Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа 2010 оноос, Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс, Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс тус тус үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна.

Хамгаалалтын захиргаа бүрд гадаад харилцаа менежмент хариуцсан мэргэжилтэн нь хүний нөөцийн мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэдэг нь хүний нөөцийн мэргэжилтний орон тоо шинээр бүтэц бүрэлдэхүүнд оруулах шаардлагатай талаар тайланд тусгагдсан байна.

Батлагдсан бүтцийн дагуу хамгаалалтын захиргааны 4 хүн харуул хамгаалалтын ажилтан гэсэн орон тоон дээр ажиллаж байгаа боловч тухайн өвийн газар нь маш том газар нутгийг эзэлдэг нь төрөл бүрийн хууль бус зөрчлүүдтэй нүүр тулгардаг. Уг асуудлыг шууд шийдвэрлэх зохицуулалт хамгаалалтын захиргаанд байдаггүй бөгөөд харуул хамгаалалтын ажилтнуудыг тухайн зөрчил гаргасан иргэд үл тоох асуудлууд гарч байна. Иймд тухайн хамгаалалтын захиргааны хамгаалалтын ажилтнуудыг байцаагчийн статустай болгон өөрчлөх шаардлагатай байна.

2.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 291 дугаар тогтоолоор Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмыг баталсан байна.

Соёлын өвийн үндэсний төв уг журамд заасан баримт бичиг болон санал, танилцуулгыг нэгтгэн тухай бүр соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэр дэвшүүлсэн дурсгалыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46.2-т заасан Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, санал, дүгнэлт гаргуулна. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 3.4-т заасан санал, дүгнэлтийг үндэслэн тухайн дурсгалд улсын хамгаалалтын зэрэглэл тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр зохицуулсан байна.

Гэвч Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46.2-т заасан Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан энэхүү хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилго бүхий боловсруулсан хууль тогтоомжийг боловсронгуй хүрээнд Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хүчингүй болгосон байна.

Уг нэмэлт, өөрчлөлтөөр тус агуулгыг СӨХТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.12-т “...соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах” гэж оруулсан бөгөөд Соёлын сайдын 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/61 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журам батлах тухай” журмын дагуу хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломжтой байна. Харин Соёлын сайдын баталсан уг журмын үндэслэх хэсэгт оруулсан СӨХТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг уг журмаас хасах шаардлагатай байна. Түүнчлэн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг уг журмаар нарийвчлан зохицуулах шаардлагатай.



3.СӨХТХ-ийн 7 дугаар зүйлд эх хэл бичиг түүний хүрээний соёлын биет бус өвд хамруулна. Мөн энэ зүйлд 7.1.11 угийн бичиг хөтлөх уламжлал, 7.1.14 газар усны уламжлалт нэр, багтсан байна. Хуулийн энэ хэсэгт томоохон зөрчил агуулагдаж байна. *Тухайлбал*, бичиг үсэг, бичгийн дурсгалт зүйлийг соёлын биет бус өвд хамруулсан атлаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хэсэгт “*бичгийн дурсгалт зүйл*” хуульчилсан байна. Нэгэнт хөдлөх дурсгалт зүйл юм бол тэр нь энэ хуулиар биет бус өв байж таарахгүй.

Соёлын биет өвийг түүх соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилан хуульчилсан. Хуулийн нэр томьёо гэдэг бол зөвхөн үг төдий зүйл биш, цаанаа нийгмийн болон эрх зүйн олон үр дагавар, хариуцлагыг хадгалдаг хэлний онцгой нэгж билээ. Тиймээс тус хуульд заасан соёлын биет өв, биет бус өвийн шинж онцлог, төрөл, хадгалж хамгаалах үйл ажиллагаа нь хоорондоо тодорхой ялгаатай тул жижигхэн мэт санагдах нэр томьёоны энэхүү асуудлыг заавал бодолцож үзэж, зааг ялгааг нь тодруулж, эмх цэгцтэйгээр хэрэглэж хэвших шаардлагатай.

4.Соёлын өвийн үндэсний төв бүрдүүлсэн холбогдох баримт бичиг, санал, дүгнэлтийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Соёлын өвийн үндэсний төвөөс ирүүлсэн хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн талаарх асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл”-өөр хэлэлцүүлж, санал, дүгнэлт гаргуулна. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн, холбогдох шаардлагыг хангасан дурсгалт зүйлд хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр журамд заасан .

Гэвч “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл”-ийн ажиллах журам өдийг хүртэл батлагдаагүй бөгөөд түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх асуудал эрх зүйн хувьд зогсонги байдалд орсон байна. Иймд “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл”-ийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах шаардлагатай.

5.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 269 дугаар тогтоолоор Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмыг баталсан байна.

Уг журамд Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн, холбогдох шаардлагыг хангасан дурсгалт зүйлд хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр заасан.

Гэвч “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл”-ийн ажиллах журам батлагдаагүй өдийг хүрсэн байна. Эндээс үзвэл түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх асуудал эрх зүйн хувьд зогсонги байдалд орсон байна.

Иймд “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл”-ийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг яаралтай батлах шаардлагатай байна.

6.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 392 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журмыг баталсан байна.



Тус журамд үнэлгээ хийх аргачлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар уг журамд заасан байна. Гэвч үнэлгээ хийх аргачлал өдийг хүртэл батлагдаагүй байна. Засгийн газрын тогтоолоор баталсан Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам батлагдсан хэдий ч журам дотор дахин аргачлал батлахаар оруулж өгсөн нь СӨХТХ-ийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Цаашид хуулиар Засгийн газарт өгсөн чиг үүргийг Засгийн газар нь Засгийн газрын гишүүндээ дахин эрх олгох байдлаар журамд аргачлал боловсруулах зэргээр тусгах нь хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх уялдаа холбоог алдагдуулж байгааг анхаарах шаардлагатай байна.

Хоёр.Соёлын өвийг хамгаалах төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, тэдгээрийн уялдаа холбооны хүрээнд

1.Соёлын өвийг хамгаалах төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, тэдгээрийн уялдаа холбооны асуудлын эрх зүйн үндсийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын гуравдугаар бүлэгт хуульчлан тогтоосон. Эдгээр субъект нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Аймаг, нийслэлийн Засаг дарга, Сум, дүүргийн Засаг дарга, Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, Баг хорооны Засаг дарга нар болно. Эдгээр субьектийн эдлэх бүрэн эрхийн хувьд нутаг дэвсгэр, чиг үүрэг, шатлан захирах ёсны давхардал үүсээгүй.

2.Соёлын өвийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээний хүрээнд баталбал зохих баримт бичгүүдээс хуульд заасан зарим хэсэг нь батлагдаагүй хэвээр байна. *Тухайлбал*, Засгийн газар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалт болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтыг батлахаар СӨХТХ-д тусгасан боловч Засгийн газраас уг жагсаалтыг батлахад шалгуур болгох журмыг баталсан. Иймээс цаашид тус хуулийн хэрэгжилтийг хангахын тулд хуулиар тухайлан заасан тус үндэсний жагсаалтыг батлах шаардлагатай байна

3.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх багц журмыг батлахаар хуульчилсан боловч эдгээр журмууд нь батлагдаагүй бөгөөд Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний 2021-2023 оны тайланд эдгээр журмуудын талаар тусгагдаагүй буюу хяналт шинжилгээ, үнэлгээний объект болоогүй байна. Харин Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 4 дугаар сарын 23-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/235 дугаартай тушаалаар “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

4.“Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам”-ыг 2019 онд багтаан батлахаар тусгасан байна. Дээрх журмын төслийг Соёлын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулж, санал авах тухай мэдээлэл 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан боловч уг журам болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журам батлагдаагүй хэвээр байна.



5.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлахаар хуульчлагдсан боловч өдгөө Соёлын сайдын 2022 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн А/348 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам” батлагдсан. Ийнхүү суурь шинжтэй журам нь батлагдсан тул уг зэрэглэлд нэр дэвшиж, хянан шийдвэрлэгдсэн үл хөдлөх дурсгалыг жагсаан батлах боломжтой болсон байна.

6.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлахаар хуульчлагдсан боловч уг журам батлагдаагүй. Учир нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8 дугаар зүйлд “Соёлын өвийн зэрэглэл”-ийн талаар зохицуулсан бөгөөд мөн зүйлийн 8.2 дахь хэсэгт “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан үнэт хосгүй үнэт зэрэглэл тогтооно” гэж заасан бөгөөд тус зүйлийн 8.3 дахь хэсэгт заасан түүх, соёлын үнэт, хосгүй үнэт зэрэглэлийг тогтоох шалгуурыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу хүчингүй болгосон. Иймээс өдгөө “түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ыг батлах тодорхой шалгуургүй болсон байна.

7.Засгийн газраас батлахаар хуульчилсан баримт бичгээс нэг, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах ёстой баримт бичгээс дөрөв нь батлагдаагүй. Үүний шалтгаан нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарч байна. *Тухайлбал*, тухайн баримт бичгийг батлахад урьдчилсан нөхцөл болсон суурь шинжтэй журам, шалгуур гэх мэт баримт бичиг хүчингүй болсон эсхүл батлагдаагүй байгаа нөхцөл байдал шууд нөлөөлж байна. Үүний зэрэгцээ батлах субъектийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт, хүний нөөцийн дутагдалтай байдал, хамтран батлах субьекттэй зөвшилцөж, хамтарсан ажлын хэсэг байгуулах болон төсөл боловсруулах, боловсруулсан төслийг олон нийтэд танилцуулж, санал авах зэрэг эдгээр баримт бичгийн батлагдахад чиглэсэн үйл ажиллагаа янз бүрийн үе шатанд харилцан адилгүй хурдтай явагдаж байгаатай холбоотой байна.

Гурав.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцооны хүрээнд

1.СӨХТХ-д соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг нийт 4 тогтолцоотойгоор байгууллага, соёлын төв, орон нутгийн музей, нийслэлийн засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгж, соёлын өвийн үндэсний төвүүдэд хуваагдан үзэж буй нь энэ төрлийн эрх зүйн харилцаанд маш олон оролцогч талууд оролцож буйг илтгэж байна.

Гэвч СӨХТХ-д төрийн музейн болон нийслэлийн засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжийн хувьд нийслэл дэх бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлэгч байгууллага байна хэмээн заасан нь нэг төрлийн харилцаанд 2 байгууллагад эрх, үүрэг олгосон улмаар тухайн байгууллагуудын хувьд улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай хэрхэн харилцах нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Иймд улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд төрийн музей болон нийслэлийн засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгж хоёрын аль субьектээс нийслэлийн бүртгэл, мэдээлэл очихыг зөв тогтоох шаардлагатай.

2.СӨХТХ-д иргэн, хуулийн этгээдийн өмчилж, эзэмшиж буй соёлын биет өвийг бүртгүүлэх эрх зүйн зохицуулалтыг “**бүртгүүлж болно, бүртгүүлэх үүрэгтэй**” хэмээн 2 өөр эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулсан нь соёлын биет өвийг өмчилж, эзэмшиж буй иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн зөрчил үүсгэж буй тул үүнийг нэг хэм хэмжээгээр зохицуулах шаардлагатай.



СӨХТХ шинэчлэгдэн батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх журам шинэчлэгдэн батлагдалгүй Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн №78 тоот “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх **журам**”-аар соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх харилцааг зохицуулж байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо, бүрдэл, бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж буй субъектийн хувьд зөрчилдөж байгаа тул соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж буй байгууллага болон тухайн харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчилсан зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд болон Соёлын өвийн үндэсний төвөөс гаргасан заавар, аргачлалын дагуу бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэгч субъектүүд тухайн өвөө бүртгэн баримтжуулж буй нь өвийн бүртгэл шат, шатандаа хийгдэж буй мэт харагдав ч тус харилцаанд оролцогч талуудын эрх зүйн харилцааг нарийвчлан зохицуулах журам Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс батлагдаагүй байна. Соёлын өвийг бүрдүүлж буй байгууллагуудын хувьд өвийн бүртгэл, мэдээллийг хэн хөтлөх, хууль тогтоомжид заасны дагуу тайлан мэдээг шат шатандаа ямар субъект нэгтгэн гаргах, улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тайланг хэрхэн хүргүүлэх зэрэг тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Иймд соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж буй байгууллага болон бүртгэл, мэдээллийн сангийн харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчилсан зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. харилцааны баримт бичгийг бий болгох нь зүйтэй байна.

Дөрөв. Соёлын өвийн судалгааны хүрээнд

1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн Тавдугаар бүлэгт заасан Соёлын өвийн судалгааны хэрэгжилт нь холбогдох журмууд батлагдсан гарснаар хэрэгжилт хангагдсан гэж үзэхээр боловч хуульд Соёлын өвийн судалгааг хэт ерөнхий байдлаар зохицуулсан байна. Улмаар холбогдох журмууд нь ерөнхий хүрээнд баригдаж гарсан байх бөгөөд мөн адил маш ерөнхий байдлаар зохицуулсан гэж дүгнэж байна. Тухайлбал, Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам нь зөвшөөрөл олгох, мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага, судалгааг тайлагнах хугацаа зэргийг зохицуулсан ч бусад нарийн холбогдох заалтуудыг оруулж өгөөгүйгээс хэт ерөнхий улмаар мэргэжилтнүүдийн хэлж буйгаар бодит байдалд нийцээгүй, хөрсөнд буугаагүй, ашиглахад хүндрэлтэй, зарим нь хэрэгждэггүй, тодорхой бус асуудлууд үүссэн байна.

2. БНСУ-ын туршлагыг харвал Монгол улсаас ялгаатай нь нэг байгууллагад бүх судалгааг уялдаа холбоотойгоор салбар бүрээр нь системтэйгээр зохицуулсан байх төдийгүй судалгаа хийх тогтолцоог маш сайн бүрдүүлж өгссөн нь харагдаж байна. Үүнээс улбаалж Соёлын өвийн судалгааны хоорондын уялдаа холбоо хангагдаж хууль тогтоомжууд хэрэгжих таатай орчин бүрдсэн байна. Тодруулбал, Соёлын өвийг бүртгэх, судлах, хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, сэргээн засварлах үйл ажиллагааг цогцоор нь явуулж байна.



Тав.Соёлын өвийн үнэлгээний асуудлын хүрээнд

1.СӨХТХ-д 2014 онд соёлын биет өвд үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар заасан боловч 2021 оны нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн **нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох** журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална гэж нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээний асуудлыг зохицуулж өгсөн бөгөөд өнөөдрийг хүртэл журам батлагдан гараагүй байна.

Түүнчлэн СӨХТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдаад 10 жил, СӨХТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулаад 3 жил гаруй болж байх энэ хугацаанд нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ хийх харилцааг зохицуулаагүй нь нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээний асуудлын хэрэгжилт хангагдаагүй байна.

2.Өнөөдрийн байдлаар соёлын биет өвд үнэлгээ тогтоох асуудлыг Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/140 тушаалаар батлагдсан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”-аар зохицуулж байна. Гэвч энэхүү журмын хувьд Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн дансны үнэ шинэчлэн тогтоох комиссыг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилж, комисст нягтлан бодогч, сан хөмрөгч, өмч хамгаалах байнгын зөвлөл, техникийн комиссын төлөөллийг оролцуулахаар зохицуулсан нь соёлын биет өвийг үнэн зөв, бодитой үнэлж чадаж байгаа эсэхэд эргэлзээ үүсгэж байна.

Мөн “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн дансны үнэ”-ийг анх тогтоохдоо мэргэжлийн зөвлөл тодорхойлохоор СӨХТХ-д заасан байсан ч энэхүү зохицуулалтыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн СӨХТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хүчингүй болгосон нь өнөөдрийн хувьд соёлын өвийн үнэлгээг ямар субъект тогтоож буй нь тодорхойгүй байна.

Бусад улс орны хувьд соёлын өвийн үнэлгээг өвийн үнэ цэн, эдийн засгийн ач холбогдол зэргээр тодорхойлж тогтсон нэг стандарт аргачлалыг барьж хэвшиж байгаа бол манай улсын хувьд үнэлгээний арга, аргачлал, соёлын өвийг хэрхэн үнэлэх эрх зүйн зохицуулалт одоогоор байхгүй байгаа нь энэ төрлийн харилцаа цаашид зохицуулалтгүй үлдэх, соёлын өвийн үнэлгээ бодит хийгдэх боломжгүй болох эрсдэлийг бий болгож буй тул энэхүү харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичгийг бий болгох нь шаардлагатай байна.

Зургаа.Соёлын өвийг эзэмших, ашиглах, өмчлөх асуудлын хүрээнд

1.СӨХТХ-д төрийн болон хувь хүн, хуулийн этгээдийн өмчлөх, эзэмших соёлын өвийг ялгаж, төрийн өмчийн соёлын өвийг эзэмшиж байгаа төрийн байгууллага болон хувь хүн, хуулийн этгээд эзэмшилдээ байгаа соёлын өвийг захиран зарцуулах хэм хэмжээг шинээр тогтоосон байна.

Монгол Улсын Засгийн газраас түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамгаалалтын бүс тогтоож, тухайн бүсэд барилга байшин барих болон бусад хэлбэрээр хохирол учруулахгүй байх талаар тухайн шатны Засаг даргад үүрэг болгодог боловч Нийслэл Улаанбаатар хотын хувьд энэ тогтоол хэрэгжихгүй олон жишээ байна. Тухайлбал, Чойжин ламын сүм музей, Богд хааны ордон музей, Гандантэгчинлэн хийдийн хамгаалалтын бүсэд хууль зөрчин хуулийн этгээд, иргэнд газар олгосноос тухайн дурсгалын эргэн тойронд олон тооны барилга, байшин баригдаж, түүний хадгалалт, хамгаалалтын байдалд аюул учруулах, харагдах сүр барааг дарсаар байна. Энэ



тохиолдолд ямар хариуцлага хүлээх хууль эрх зүйн орчин дутмаг байгааг мөн анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн, Соёлын үл хөдлөх өвийг кадастрын болон өмчлөх, эзэмших эрхийн бүртгэлтэй болгох шаардлага ихээр тавигдаж байна. Хэд хэдэн үл хөдлөх соёлын өв кадастрын зурагт орж, газрын бүртгэлд ороогүйгээс болж бусад газар эзэмшигч нартай газрын маргаанд орж, зарим нь шүүхийн шатанд явж байна.

2.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 35.1 дэх хэсэгт зааснаар “Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журам”-ыг Соёлын өвийн газраас шинэчлэн боловсруулж байгаа тул энэ харилцааг сонирхогч, оролцогч зохих этгээд, иргэдээс журамд тусгах саналыг нээлттэй авч байна гэж 2021 оны 02 дугаар сар, 2024 оны 8 дугаар сард мэдээлэл гарсан боловч СӨХТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн журам өнөөг хүртэл батлагдаагүй байна.

Энэхүү журам батлагдаагүйгээс улбаалж Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох асуудлыг хэрхэх нь тодорхойгүй нөхцөл байдалтай байна.

Долоо.Соёлын өвийг хамгаалах болон хяналтын тогтолцооны хүрээнд

1.Соёлын өвийг хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын Долоодугаар бүлэгт хуульчилсан. Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, тус хуулиар үүрэг хүлээсэн байгууллага эрх бүхий этгээд хариуцахаар зохицуулжээ. Харин соёлын өвийг хамгаалах асуудалд тавих хяналтын тогтолцооны хувьд соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавихаар хуульчилсан байна.

Мөн соёлын өвийг хамгаалах, түүнд хяналт тавих асуудлын хүрээнд соёлын өвд хохирол учруулж болзошгүй тодорхой үйл ажиллагааг хориглох, зогсоох талаар болон тус шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлэхэд аливаа хэлбэрээр дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын байцаагч, гэрээт харуулыг урамшуулах, соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамгаалах арга хэмжээ авах тухай тодорхой заажээ.

Энэ хүрээнд Соёлын өвийг хамгаалах, хяналт тавих чиг үүрэг бүхий субъектүүдээс практикт голлох үүргийг гүйцэтгэдэг соёлын хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон баримт бичгийн бүрдэлд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотойгоор үүссэн нөхцөл байдлыг дагаж өөрчлөлт орсон бөгөөд энэ нь хяналт тавих хэлбэр, төрөл хэв маягт нь мэдэгдэхүйцээр нөлөөлсөн. Тодруулбал, улсын байцаагч тандан судалгаа болон түүнд суурилсан иргэн, аж ахуйн нэгжид үзүүлэх зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх боломжгүй болж үйл ажиллагаа нь энэ хэмжээгээр хумигдсан.

2.СӨХТХ-ийн шинэчилсэн найруулгын 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэгт заасан энэхүү зохицуулалтад дурдсан Засаг даргын суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтоох эрхийн хэрэгжилт нь хангагдах хууль зүйн боломжгүй юм. Учир нь өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын



гишүүд хамтран батлахаар хуульчилсан бөгөөд уг шалгуур үзүүлэлт өдгөө батлагдаагүй байна.

Тус шалгуур үзүүлэлтийг батлахын тулд хоёр яамны хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, эхний байдлаар түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын эргэн тойронд өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан байна. Уг төслийг боловсруулахдаа архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах олон улсын туршлага, үндэсний хууль тогтоомж, норм нормативын нөхцөлийг харгалзан 20 шалгуур үзүүлэлтийн дагуу өндрийн хязгаар тогтоох нөхцөлийг тусгасан байгаа бөгөөд боломжит богино хугацаанд төсөл эцэслэн батлагдана гэсэн хүлээлттэй байна.

Найм.Соёлын өвийг сэргээн засварлах ажлын хүрээнд

1.Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах үйл ажиллагааг гэр, орон сууц, ажлын байраа засварлаж байгаагийн нэгэн адилаар дуртай цагтаа өөрийн үзэмж, сонголтоор хийж болохгүй мэргэжлийн нарийн мэдлэгийг үндэслэл болгохын зэрэгцээ төрийн зөвшөөрлийг үндэслэл болгодог. Соёлын өвийг сэргээн засварлахтай холбогдон үүсэх харилцааг СӨХтХ-д нийт 13 зүйлд 31 удаа зохицуулсан байх бөгөөд үүнээс дурсгалт барилгыг сэргээн засварлахад шууд хамааралтай нь “захиргааны байгууллагын бүрэн эрх”, “соёлын өвийн бүртгэл”, “соёлын биет өвийг эзэмшигч, өмчлөгчийн эрх, үүрэг”, “соёлын өвийг сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах”, соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага, түүний үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан зүйлүүд байна.

2.Сэргээн засварлах ажилд эзэмшигч байгууллагын үүрэг, оролцоог хязгаарласан эрх зүйн зохицуулалт үйлчилж байгаа тул үүнийг эргэн харж, тухайн байгууллагын үр дүнтэй оролцоог бий болгосон зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн, соёлын биет өвийн сэргээн засварлах ажлын гүйцэтгэгийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д заасан журмын дагуу бага үнийн аргаар шалгаруулж байгаа нь гүйцэтгэсэн ажлын үр дүнд нөлөөлж болзошгүй тул сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.“Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан боловч өдийг хүртэл батлагдаагүй байна. Харин Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 183/111 тоот хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам” хүчин төгөлдөр үйлчилж байна. Иймд журмыг шинэчлэн батлах шаардлагатай байна.

4.Дурсгалт барилгын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтыг шинжлэх ухааны ерөнхий судалгаанд тулгуурлан гүйцэтгэх. *Тухайлбал*, соёлын өвийн хадгалалт хамгаалалтын үйл ажиллагааны гүйцэтгэл, сэргээн засварлах технологи, материалын талаарх судалгаа; соёлын өвийг бүтээсэн материалын чанар, бүтцийн талаарх шинжлэх ухааны судалгаа; шинжлэх ухааны судалгаанд үндэслэн технологийн түүхийг тодорхойлох; соёлын өвийн хадгалалт хамгаалалтын орчин нөхцөлийг судлах.

5.Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах ажлын норм, үнэлгээг шинэчлэн боловсруулах. Дурсгалт барилгын сэргээн засварлах ажлын тендерийг барилгын ажил эхлэх улирлаас өмнө буюу 5 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө шалгаруулж, сэргээн засварлах ажлыг дулааны улиралд чанартай гүйцэтгүүлж байх.



Дурсгалт барилгыг сэргээн засварлах эрх бүхий байгууллагуудыг чанаржуулах, шинээр бий болгох, хүний нөөцийг чадавхжуулах.

6.Сэргээн засварлалтын ажилд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх талаар холбогдох яамд, боловсролын байгууллага, олон нийтийн болон хувийн байгууллагууд хамтран ажиллаж, нэгдсэн цогц бодлогын хүрээнд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Ес.Соёлын өвийг сурталчлах харилцааны хүрээнд

Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйл буюу Төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх соёлын үйл ажиллагааны чиглэлд “байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн нүүдлийн соёл иргэнийн онцлогийг хадгалсан орон зай, газар нутгийг тогтоох, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нүүдлийн соёл иргэнийн дурсгалт газар уламжлалт ахуйг хамгаалах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх”-ээр гэж заасан. Өөрөөр хэлбэл, нүүдлийн соёлыг хадгалж хамгаалахад соёлын салбараас дэмжлэг үзүүлнэ гэсэн байна. Дурсгалт газрын хадгалалт хамгаалалт, судалгаа шинжилгээ, сурталчилгааны үйл ажиллагаа ЮНЕСКО-ийн зүгээс тавьдаг, шаардлагын түвшинд гүйцэтгэж чадахгүй байна.

Соёлын өвийг сурталчлах ажлын хүрээнд Соёлын яамнаас Соёлын бүтээлч сар, Хүрээ цам Даншиг наадам, Нүүдэлчин наадам, ардын урлагийн наадам, “Монгол цам” тусгай үзэсгэлэн, “Цам” контент, “Цам” боловсролын хөтөлбөр, “Язгуурын таван шүтээн” тусгай үзэсгэлэн, “Дэлхийн өв - Монгол Алтайн хадны зураг” үзэсгэлэн, Нүүдэл буюу On the move” олон улсын үзэсгэлэн, “Урлахуй, шүтэхүй, гэгээрэхүй” шүтээн зургийн тусгай үзэсгэлэн, “Welcome home” тусгай үзэсгэлэн, “Ноёд, тайж нар, хутагт хувилгаадын гэрийн үеийн бичмэл” архивын баримтын үзэсгэлэн, “Монгол Улсын баримтат өвийн дурсгал” гэр үзэсгэлэн, ЮНЕСКО-д бүртгэгдсэн соёлын биет бус өвийг сурталчлах үзэсгэлэн, арга хэмжээнүүд жил бүр зохион байгуулагдаж буй арга хэмжээ нь олон нийтэд хүрч, соёл, уламжлалын томоохон арга хэмжээнүүд болж чадсан байна.

Арав.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх асуудлын хүрээнд

Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн үйлдлийг гэмт хэрэг, зөрчилд тооцох, хариуцлага оногдуулах асуудлыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулиар тусгайлан зохицуулсан нь ач холбогдолтой боловч соёлын өвд халдсан тодорхой гэмт хэргийн шинжтэй үйлдэл зөрчлөөс ялгагдахгүй, энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах хариуцлагын хэмжээ харьцангуй хөнгөн байгаа зэрэг нөхцөл байдлыг бодлого тодорхойлогч зайлшгүй анхаарах шаардлагатай байна. Иймд:

1.Эрүүгийн хуулийн 25.1 дүгээр зүйлийн 1-т заасан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх гэмтээх, устгах” гэмт хэргийн объектив талын шинжийг ижил агуулгаар Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 5, 11, 12 дахь хэсэгт томъёолсныг зааглах, хасах;

2.Эрүүгийн хуулийн 25.1 дүгээр зүйлийн 1-т заасан “Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх” гэмт хэргийн гэмт хэргийн объектив талын шинжийг “үрэгдүүлсэн” хэмээн Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 3-т томъёолсныг хасах;

3.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах хариуцлагын хэмжээ бусад ижил төрлийн гэмт хэрэгтэй болон олон улсын жишгээс хөнгөн байгааг анхаарч, хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх саналыг хууль тогтоогчид уламжлах;



4.Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд соёлын биет өвийн бүртгэл, үнэлгээ чухал ач холбогдолтой уг харилцааг журмаар бус хуулиар зохицуулах;

5.СӨХтХ-ийн зөрчсөн зарим үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон СӨХтХ-д тусгаагүй орхигдуулсан эдгээр үйлдэлд хариуцлага оногдуулах шаардлагатай эсэх талаар саналыг хууль боловсруулагчид уламжлах шаардлагатай байна.



Нэг. Соёлын өвийн ангилал, зэрэглэл

Үнэлэх хэсэг	4.1.Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна. 4.2.Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

Соёлын өвийг судлах асуудал нь түүхийн шинжлэх ухаан, угсаатан судлал, хэл шинжлэл, археологийн судлалын хүрээнд судлагдаж ирсэн. Харин соёлын өвийн судлал, орчин үеийн өвийн судлал, орчин үеийн соёл судлалын онол, арга зүйгээр судлагдах нийгэм соёлын, хүн судлалын үүднээс судлах шинэ чиг хандлага нь сүүлийн жилүүдэд өрнөж байна.¹² Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад соёл иргэншлийн нэг шатнаас нөгөө шатанд шилжиж ирэхдээ үе үеийн хүмүүст өв уламжлал, танин мэдэхүйн асар их баяслыг төрүүлж, үзэл хүмүүжлийн багагүй үүрэг гүйцэтгэсний зэрэгцээ хойч үеийнхэндээ өвлүүлэх, тэдгээрийг зүй зохистой хадгалах, хамгаалах үүрэг ногдож байна.

ЮНЕСКО-гийн тодорхойлсноор “Өнгөрсөн үеэс бидэнд өвлөгдөж ирсэн, одоо бидэнд байгаа, ирэх хойч үе маань өвлөн авч хүндэтгэн биширч, суралцан сэтгэл оюуны бахархал болгон уламжилж байгаа аливаа үнэт зүйл, илэрхийллийг өв гэнэ¹³” гэжээ.

Энэ хүрээнд СӨХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна” гэж заасан бөгөөд үнэлгээний энэ хэсэгт соёлын өвийн ангиллыг хуулиар тогтоосон шалгуур хангагдсан эсэхэд үнэлгээ өгөхөд оршино.

1.Соёлын биет өв

Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр (1).эртний ургамал, амьтны олдворт газар; (2).эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга; (3).чулуун зэвсгийн олдворт газар; (4).хадны зураг, бичээс; (5).булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж; (6).эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгал; (7).хөшөө дурсгал; (8).эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал; (9).тахилгат газар; (10).түүхэн үйл явдал болсон дурсгалт газар.¹⁴

Харин соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд (1).ховор эрдэс; (2).эрдэнийн чулууны ховор олдвор; (3).солир; (4).ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл; (5).эртний ургамал, амьтны олдвор; (6).археологийн олдвор; (7).угсаатны хувцас, чимэглэл; (8).уламжлалт аж

¹² Ц.Наранцэцэг, «Эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт: Соёлын өвийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн жишээн дээр Магистрын зэрэг горилсон судалгааны ажил» (МУИС-ийн номын сан, УБ, МУИС-ийн Хууль зүйн сургууль, 2016), <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=127940>.

¹³ Дэлхийн өв-залуу үеийнхний гарт ЮНЕСКО-гийн гарын авлага. (2010)

¹⁴ «Соёлын өвийг хамгаалах тухай хууль», sec 5 дугаар зүйл., accessed 11 Есдүгээр сар 2024, <https://legalinfo.mn/>.



ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг; (9).угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл; (10).уламжлалт тоглоом, наадгай; (11).уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл; (12).бичгийн дурсгалт зүйл; (13).дүрс, дуу авианы баримт; (14).дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл, холбогдох эд өлгийн зүйл; (15).уламжлалт монгол эмнэлгийн оношилгоо, эмчилгээний хэрэглэгдэхүүн, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл; (16).гэр, сууц, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл¹⁵ гэж ангилсан.

Харин СӨХтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2-т эртний ургамал, амьтны олдворт ургамал; ховор эрдэс; эрдэнийн чулууны ховор олдвор; солир зэргээс бусад байгалийн өвийг хамгаалах асуудлыг холбогдох бусад хуулиар зохицуулна гэж ерөнхий тусгасан байна.

Байгалийн өвийн төрөл зүйлд 34 түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл байгаа нь нийт дурсгалын 4.3% болж байна. Үүнд:

- Палеонтологийн олдвор 26 хосгүй үнэт дурсгалт зүйл (76.4%),
- Солир 7 хосгүй үнэт дурсгалт зүйл (20.5%),
- Геологийн баялаг, ашигт малтмалын дээжис 1 хосгүй үнэт дурсгалт зүйл (3.1%) тус тус байна гэж тоон мэдээллийг гаргасан байна.

Байгалийн өвийг хамгаалах зорилгоор Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа 2010 оноос, Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс, Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс тус тус үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна.

Хамгаалалтын захиргаа бүрд гадаад харилцаа менежмент хариуцсан мэргэжилтэн нь хүний нөөцийн мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэдэг нь хүний нөөцийн мэргэжилтний орон тоо шинээр бүтэц бүрэлдэхүүнд оруулах шаардлагатай талаар тайланд тусгагдсан байна.

Батлагдсан бүтцийн дагуу хамгаалалтын захиргааны 4 хүн харуул хамгаалалтын ажилтан гэсэн орон тоон дээр ажиллаж байгаа боловч тухайн өвийн газар нь маш том газар нутгийг эзэлдэг нь төрөл бүрийн хууль бус зөрчлүүдтэй нүүр тулгардаг. Уг асуудлыг шууд шийдвэрлэх зохицуулалт хамгаалалтын захиргаанд байдаггүй бөгөөд харуул хамгаалалтын ажилтнуудыг тухайн зөрчил гаргасан иргэд үл тоох асуудлууд гарч байна. Иймд тухайн хамгаалалтын захиргааны хамгаалалтын ажилтнуудыг байцаагчийн статустай болгон өөрчлөх шаардлага гарч байна.

Хамгаалалтын захиргааны дүрмийн 2.1.11-т дурсгалт газрын байгаль, соёлын өвийг судлах ажлыг бие даан болон мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлэх гэж заасан байдаг боловч үйл ажиллагааны чиглэлээс хамааран захиргааны соёлын өвийн бүртгэл мэдээллийн санч, байгалийн өвийн бүртгэл мэдээллийн санч гэсэн орон тоог чиг үүргийн дагуу соёлын өвийн мэргэжилтэн, байгалийн өвийн мэргэжилтэн эсхүл эрдэм шинжилгээний ажилтан гэсэн статусаар өөрчлөх нь одоогийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжит гарц байж болох юм.

¹⁵ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 6 дугаар зүйл.



Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 291 дугаар тогтоолоор Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмыг¹⁶ баталсан байна.

Дурсгалыг оршин байгаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга өмчийн хэлбэр харгалзахгүй улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлнэ. Дурсгал хоёр ба түүнээс дээш аймгийн нутаг дэвсгэрийг дамнан оршиж байгаа бол дурсгалын ихэнх хэсэг байрлаж байгаа аймаг, нийслэлийн Засаг дарга бусад аймгийн Засаг дарга нартай зөвшилцөн нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулна.¹⁷

Улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх дурсгал нь дараах шаардлагад нийцсэн байна:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байх;
2. түүхэн үйл явдлыг гэрчлэх, эсхүл өнгөрсөн үеийн нийгмийн хөгжлийн хувьсал, өөрчлөлтийг илэрхийлж чадах онцгой содон шинж, төрхийг хадгалсан байх;
3. ижил төрлийн дурсгалын нийтлэг хэв шинжийг хадгалсан сонгодог төлөөлөл байх;
4. эх төрх, бүрэн бүтэн байдал болон хүрээлэн буй орчны төлөв байдлаа хадгалсан байх;
5. газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөхөөр ороогүй байх;
6. эрдэм шинжилгээний бүтээл, ном, сэтгүүлд хэвлэгдэх зэргээр олон нийтэд танигдсан байх;
7. аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлтэй байх;
8. Тодорхой газар нутаг, орон зайн ой санамжийг хамгаалах зорилгоор архивын баримтад үндэслэн боловсруулсан зураг төслийн дагуу анхны төрх байдлаар нь сэргээн босгосон дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлж болно.

Харин унаган газраас нь зөөж, аюулгүй орчинд шилжүүлэн байрлуулсан дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэхгүй байхаар зохицуулсан байна.

Хувийн өмчийн дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх бол хууль ёсны өмчлөгчтэй нь Аймаг, нийслэлийн Засаг дарга урьдчилан зөвшилцөхөөр зохицуулжээ.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэхдээ энэхүү¹⁸ баримт бичгийг бүрдүүлэн Соёлын өвийн үндэсний төвд

¹⁶ «Журам батлах тухай (Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх)», Засгийн газрын 2022 оны 269 дугаар тогтоол §, accessed 16 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/>.

¹⁷ Журам батлах тухай (Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх), sc. 2.1 дэх хэсэг.

¹⁸ 1. нэр дэвшүүлэх үндэслэлийг тодорхой дурдсан санал бүхий албан бичиг;

2. энэ журмын 2.2-т заасан шаардлагад нийцсэн болохыг нотлох баримт;

3. дурсгалын түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлсон судлаач (доктор ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй)-ийн тодорхойлолт;



хүргүүлэх бөгөөд Соёлын өвийн үндэсний төв нь шаардлагад нийцсэн эсэх, баримт бичгийн бүрдэл бүрэн эсэхэд хяналт тавьж шаардлага хангаагүй дурсгалыг нэр дэвшүүлсэн Засаг даргад тайлбарын хамт буцаан хүргүүлэх, шаардлагад нийцсэн дурсгалын талаар танилцуулга бэлтгэж, доорх байгууллагаас санал авч шийдвэрлэхээр тусгажээ. Үүнд:

- 1.соёл, урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;
- 2.Шинжлэх ухааны академи;
- 3.ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс;
- 4.дурсгалыг судлах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3-аас доошгүй эрдэм шинжилгээний байгууллага;
- 5.дурсгалыг судлах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3-аас доошгүй төрийн бус байгууллага.

Соёлын өвийн үндэсний төв журамд заасан баримт бичиг болон санал, танилцуулгыг нэгтгэн тухай бүр соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэр дэвшүүлсэн дурсгалыг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46.2-т заасан Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, санал, дүгнэлт гаргуулна. Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ журмын 3.4-т заасан санал, дүгнэлтийг үндэслэн тухайн дурсгалд улсын хамгаалалтын зэрэглэл тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр зохицуулсан байна.

Гэвч Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 46.2-т заасан Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан энэхүү хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нийцүүлэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилго бүхий боловсруулсан хууль тогтоомжийг боловсронгуй хүрээнд Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хүчингүй болгосон байна.

Уг нэмэлт, өөрчлөлтөөр тус агуулгыг СӨХТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.12-т “...соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах” гэж оруулсан бөгөөд Соёлын сайдын 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/61 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журам батлах тухай” журмын дагуу хэвийн үйл ажиллагаагаа явуулах боломжтой байна. Харин Соёлын сайдын баталсан уг журмын үндэслэх хэсэгт оруулсан СӨХТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг уг журмаас хасах шаардлагатай байна. Түүнчлэн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг уг журмаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

2.Соёлын биет бус өвийн тухай

Соёлын биет бус өв нь түүхэн урт хугацаанд хувьсан өөрчлөгдөх хэдий ч бие хүн, хүмүүсийн бүлгийн хүрээнд үеэс үед уламжлагдан өнөөг хүрсэн “амьд” өв уламжлал

-
- 4.дурсгалд хамгаалалтын бүс тогтоох урьдчилсан зураглал;
 - 5.дурсгалыг хамгаалах, ашиглах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний урьдчилсан төлөвлөгөө;
 - 6.энэ журмын 2.5-д заасан дурсгалын хувьд өмчлөгчийн санал;
 - 7.дурсгалын гэрэл зураг, дүрс бичлэг, шаардлагатай бусад баримт.



учир түүнийг тээж, уламжилж буй субъект болох “өвлөн уламжлагч”-ийг тусгайлан судалж, хөхиүлэн тэтгэж хөгжүүлэх асуудал тэргүүн зэрэгт тавигдах болсон.

Соёлын биет бус өвийг хамгаалах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас 1999 оны 68 дугаар тогтоолоор “Ардын уламжлалт урлагийг дэмжих үндэсний хөтөлбөр” (1999-2006), 2005 оны 43 дугаар тогтоолоор “Морин хуур, уртын дуу” (2005-2014), 2007 оны 159 дүгээр тогтоолоор “Монгол хөөмэй” (2008-2014), 2009 оны 10 дугаар тогтоолоор “Монголын уламжлалт бий, биелгээ” (2009-2014), 2011 оны 357 дугаар тогтоолоор “Монгол тууль” (2012-2014), 2014 оны 72 дугаар тогтоолоор “Монгол цуур” (2014-2016 он), 2014 оны 252 дугаар тогтоолоор “Монгол уран бүтээл” үндэсний хөтөлбөр (2015-2025)-ийг тус тус батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын үе үеийн Ерөнхийлөгч нар 1991 онд Төрийн хан хуурыг залах тухай, 1995 онд Богд хан Хайрхан уул, Хан Хэнтий уул, Отгонтэнгэр уулыг тайх уламжлалыг сэргээх санаачилгыг дэмжих тухай, 2002 онд Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай, 2004 онд Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай, 2006 онд Монгол хөөмийн урлагийг хөгжүүлэх тухай, 2011 онд Монголын уламжлалт сэтгэлгээ, арга билгийн ухааны үндэс хичээлийн тухай, 2016 онд Монгол дарханы урлалыг дэмжих тухай зэрэг соёлын биет бус өвийг хамгаалах зарлигуудыг тус тус гаргажээ.¹⁹

Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг 2003 онд ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын 32 дугаар чуулганаар баталж, Монгол улс 2005 оны 6 дугаар сарын 29-нд нэгдэн орсон.²⁰ 2020 оны 7 дугаар сарын байдлаар тус конвенцод 179 орон нэгдэж орсон байна.

Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг 2003 онд баталсан нь даяарчлалын орчин үеийн үйл явцаас үүдэн соёлын биет бус өвд тулгараад буй аюул эрсдэлийг даван туулах, нэгдэн шийдвэрлэх алхам болсон байна.²¹

ЮНЕСКО-гийн тодорхойлсноор Соёлын биет бус өв нь:

- *нэгдүгээрт*, эх хэл, аман зохиолын уламжлал;
- *хоёрдугаарт*, язгуур урлаг түүний тоглож үзүүлэх, илэрхийлэх хэлбэрүүд;
- *гуравдугаарт*, зан үйл, ёс заншил, ёслол, баяр наадам;
- *дөрөвдүгээрт*, байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг ухаан;
- *тавдугаарт*, уламжлалт урлал гэсэн үндсэн таван ай савд хамаарсан, тоолж баршгүй төрөл зүйл, элемент, асар баялаг өв юм.

Уг конвенцын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлохдоо “Соёлын биет бус өв гэж хамт олон, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, мэдлэг болон дадал, эдгээртэй холбоо бүхий багаж зэмсэг, эд зүйл, урлагийн бүтээл, соёлын орон зайг хэлнэ.”²² Үеэс үед уламжлагдах соёлын биет бус өвийг хамт олон, бүлэг хүмүүс нь тэдгээрийг хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан шүтэлцээнээс

¹⁹ Г.Энхбат, *Соёлын биет бус өвийн их наадам – 2018 (мэдээ, мэдээлэл, гэрэл зургийн цомог)* (УБ, 2018), 8, <https://ncch.gov.mn/Files/Publication/Soyoliin-bie-bus-uviin-ikh-naadam-2018.pdf>.

²⁰ «Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцыг соёрхон батлах тухай», accessed 7 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/mn/detail/10263>.

²¹ «Соёлын Биет Бус Өв», accessed 7 Аравдугаар сар 2024, <https://www.unesco.mn/29/sitem>.

²² Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 3 дугаар зүйлийн 3.1.5. "соёлын биет бус өв" гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг" хэлнэ гэж конвенцийн агуулгатай ижил байдлаар хуульчилжээ.



шалтгаалан байнга шинэчилдэг бөгөөд тухайн өв нь тэдгээрт оршин тогтнох болон залгамж чанарын мэдрэмж төрүүлж, соёлын төрөл зүйл, хүний туурвилыг хүндэтгэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэхүү конвенцын зорилгод олон улсын хүний эрхийн зөвхөн одоо мөрдөж буй баримт бичиг болон хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцан хүндэтгэл, мөн тогтвортой хөгжлийн шаардлагуудад нийцсэн соёлын биет бус өвийг авч үзнэ” гэжээ.

Соёлын биет бус өвийн нэг өвөрмөц онцлог бол түүний байнга хувьсан өөрчлөгдөж, үргэлжилж байдаг чанар юм. Тухайн өв нь газарзүйн өргөн уудам нутагт оршин байж болох бөгөөд тухайн бүлэг хүмүүст тохиолдож болох олон янзын нөхцөл байдалд дасан зохицож амьдрах чадвартай байдаг аж. Энэ утгаар конвенцын дагуу бий болгосон:

- Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт;
- Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалт;
- Хадгалалт хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл гэсэн гурван жагсаалтад хамтран нэр дэвшүүлэхийг оролцогч улсуудад ЮНЕСКО уриалан дэмжиж байдаг.²³

2023 оны байдлаар ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны конвенцын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалт болон Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад нийт 549 өвийг бүртгээд байна.

1.Соёлын биет бус өвийг тээгч хэлийг оролцуулан аман уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэрүүд;

2.Урлагийн тоглолт үзүүлбэрүүд;

3.Заншил, зан үйл, баяр ёслол;

4.Байгаль болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншлууд;

5.Уламжлалт гар урлал орно.

Биет бус өвд Монголын ард түмний оюун санаагаар бүтсэн эх хэл, ардын зан заншил, мэдлэг ухаан, дуу хөгжим, наадам, ардын арга ухаан, уламжлалт технологи зэрэг соёлын өвийн олон төрөл багтдаг.²⁴

СӨХТХ-д “соёлын биет бус өв” гэж хамт олон, бүлэг, хувь хүн соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг”²⁵ хэлнэ гэж тодорхойлсон.

Мөн соёлын биет бус өвд (1).эх хэл, бичиг, түүний хүрээний соёл; (2).аман зохиолын уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэр; (3).урлагийн тоглох үзүүлбэр; (4).үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил; (5).уламжлалт гар урлалын дэг сургууль, арга барил; (6).ардын ёс заншил, зан үйл; (7).ардын уламжлалт мэдлэг, арга ухаан; (8).ардын бэлгэдэх ёсны уламжлал; (9).үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйл; (10).ардын уламжлалт технологи; (11).угийн бичиг хөтлөх уламжлал; (12).гэрийн дэг сургуулийн шилдэг өв уламжлал;

²³ «Соёлын Биет Бус Өв».

²⁴ Соёлын өвийн үндэсний төв, «Соёлын Биет Бус Өвийн Тухай», accessed 7 Аравдугаар сар 2024, <https://ncch.gov.mn/ich>.

²⁵ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sc. 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт.



(13).уламжлалт шашин, шүтлэгийн зан үйл, ёс заншил; (14).газар, усны уламжлалт нэр; (15).бусад соёлын биет бус өв байхаар хуульчилж өгсөн байна.²⁶

Харин СӨХТХ-ийн 7 дугаар зүйлд эх хэл бичиг түүний хүрээний соёлын биет бус өвд хамруулна. Мөн энэ зүйлд 7.1.11 угийн бичиг хөтлөх уламжлал, 7.1.14 газар усны уламжлалт нэр, багтсан байна. Хуулийн энэ хэсэгт томоохон зөрчил агуулагдаж байна. *Тухайлбал*, бичиг үсэг, бичгийн дурсгалт зүйлийг соёлын биет бус өвд хамруулсан атлаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хэсэгт “*бичгийн дурсгалт зүйл*”²⁷ хуульчилсан байна.²⁸ Нэгэнт хөдлөх дурсгалт зүйл юм бол тэр нь энэ хуулиар биет бус өв байж таарахгүй. Соёлын биет өвийг түүх соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилан хуульчилсан. Хуулийн нэр томьёо гэдэг бол зөвхөн үг төдий зүйл биш, цаанаа нийгмийн болон эрх зүйн олон үр дагавар, хариуцлагыг хадгалдаг хэлний онцгой нэгж билээ. Тиймээс тус хуульд заасан соёлын биет өв, биет бус өвийн шинж онцлог, төрөл, хадгалж хамгаалах үйл ажиллагаа нь хоорондоо тодорхой ялгаатай тул жижигхэн мэт санагдах нэр томьёоны энэхүү асуудлыг заавал бодолцож үзэж, зааг ялгааг нь тодруулж, эмх цэгцтэйгээр хэрэглэж хэвших шаардлагатай юм.²⁹

Монгол Улс нь Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Конвенцод 2005 онд нэгдэн орсноос хойш ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалтад 7, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад 8, нийт 15 өвийн төрөл зүйлийг бүртгүүлээд байна. Үүнд:

(1).Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг 2008; (2).Монгол ардын уртын дуу 2008; (3).Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг 2009; (4).Монгол тууль 2009; (5).Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг 2009; (6).Монголын уламжлалт Хөөмэйн урлаг 2010; (7).Шувуучлахуй буюу Бүргэдээр ан хийх зан үйл (Ази, Европ, Арабын 18 улстай хамтран) 2010; (8).Монгол баяр наадам 2010; (9).Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил – битүү амьсгаа 2011; (10).Монгол уран бичлэг 2013; (11).Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл 2013; (12).Монгол шагайн харваа 2014; (13).Ботго авхуулах зан үйл 2015; (14).Уул овоо тахих Монгол зан үйл 2017; (15).Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл (2019) гэх өвүүдийг бүртгүүлээд байна.³⁰

Үндэснийхээ соёлын биет бус өвийг ЮНЕСКО-д бүртгүүлж баталгаажуулна гэдэг нь тухайн улс үндэстний нэр төрийн хэрэг бөгөөд дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн хүндтэй үүрэг хариуцлага юм. Тухайн өвийг орон нутаг, улс үндэстэн, олон улсын түвшинд танин мэдүүлж, хадгалж хамгаалах, сэргээн амилуулах, түгээн дэлгэрүүлэх явдал хамгийн чухал юм.

3.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч

2023 оны 9 дүгээр сарын байдлаар “Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”-д соёлын биет бус өвийн 7 ай савын 279 өв, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д 7 ай савын 83 өв, нийт 362 өв бүртгэлтэй

²⁶ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг.

²⁷ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтыг үзнэ үү.

²⁸ Ж.Сэржээ, «Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зарим нэр томьёо», n.d.

²⁹ Х.Энхзул, «Соёлын Өвийг Хамгаалах Тухай Хуулийн Зохицуулалт, Зарим Асуудал», accessed 7 Аравдугаар сар 2024, <https://legaldata.mn/index.php/b/1789>.

³⁰ «ЮНЕСКО-д Бүртгэгдсэн Монголын Өв», accessed 7 Аравдугаар сар 2024, <https://ncch.gov.mn/ich?ItemID=4>.



байна. Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 10,924 хүн бүртгэлтэй байна.³¹

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын Ерөнхий бага хурлын 32 дугаар чуулганаар 2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” конвенцын 12, 17 дугаар зүйлд соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч тодруулах, бүртгэх харилцааг зохицуулсан.³²

Энэ агуулгын хүрээнд СӨХТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д “соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч” гэж соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн, түүнийгээ олны хүртээл болгож, дараагийн үедээ өвлүүлэн уламжлуулж байгаа хамт олон, бүлэг, хувь хүнийг хэлнэ.

Соёлын биет бус өв өвлөн уламжлагч нь соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс олгосон “Соёлын биет бус өв өвлөн уламжлагч” батламж бүхий этгээдийг; Соёлын биет бус өвийг өвлөн суралцагч гэдэгт Соёлын өвийн төвийн бүртгэлд орсон, өвлөн суралцаж байгаа “Соёлын биет бус өв өвлөн уламжлагч”-ийн батламж аваагүй этгээдийг ойлгоно³³ гэсэн.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дугаар тушаалаар “Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл”-ийг баталсан байна. Уг үндэсний бүртгэлд (I)Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд – 49; (II)Ардын язгуур урлаг – 54; (III)Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага – 44; (IV)Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл – 10; (V)Уламжлалт арга ухаан – 39; (VI)Мал маллах арга ухаан – 7; (VII)Уламжлалт гар урлал – 77 гэж бүртгэгдсэн байна.

Уг бүртгэл хийх тушаалын дараа Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор³⁴ Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-ыг баталсан бөгөөд Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд – 11 иргэн; Ардын язгуур урлаг – 69 иргэн; Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага – 5 иргэн; Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл – 2 иргэн; Уламжлалт гар урлал – 15 иргэн үндэсний жагсаалтад бүртгэгдсэн байна.³⁵ Харин Уламжлалт арга ухаан, мал маллах арга ухаан дээр иргэн бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолоор “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-ыг баталсан³⁶ бөгөөд соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах,

³¹ Соёлын яам. Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх бодлого. (2024)

³² Б.Дуламсүрэн, «Монгол улс дахь соёлын биет бус өвийг хамгаалах эрх зүйн орчин: Магистрын зэрэг горилсон судалгааны ажил» (МУИС-ийн номын сан, УБ, МУИС-ийн Олон улсын харилцааны нийтийн удирдлагын сургууль, 2015), 14, <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=129446>.

³³ «Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч гэж хэн вэ?», accessed 22 Аравдугаар сар 2024, <https://ncch.gov.mn/ich?ItemID=1>.

³⁴ Монгол Улсын Засгийн газрын тогтоол, «Үндэсний жагсаалт батлах тухай (соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч)», accessed 22 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14937>.

³⁵ п. Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолын хавсралт.

³⁶ Монгол Улсын Засгийн газар, «Журам шинэчлэн батлах тухай (Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам)», accessed 22 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/>.



түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан нэг өвлөн уламжлагчийг жил бүр тодруулж, мөнгөн шагнал олгохоор зохицуулсан байна.

Өвлөн уламжлагчийг дараах шалгуур үндэслэлээр шагналд нэр дэвшүүлэхээр заасан:

1.үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан, тэмцээнд амжилт гаргасан;

2.соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад зохион байгуулагдсан арга хэмжээнд идэвхтэй оролцсон;

3.өөрийн санаачилгаар соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад арга хэмжээ зохион байгуулсан;

4.соёлын биет бус өвийг хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх, санаачилгатай оролцсон нэг өвлөн уламжлагчийг Аймаг, нийслэлийн Засаг дарга нэр дэвшүүлэх саналыг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлэхээр зохицуулсан байна.

Соёлын өвийн үндэсний төв нь шаардлага хангасан баримт бичгийг бүрдүүлэн соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлнэ. Мэргэжлийн зөвлөл шагналд нэр дэвшүүлсэн өвлөн уламжлагч тус бүрийн талаар нэг бүрчлэн хэлэлцэж, нэг өвлөн уламжлагчийг нууц санал хураалтаар тодруулан санал, дүгнэлтийн хамт соёлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд уламжлахаар заасан.

Уг шагнал гардуулах ёслолын арга хэмжээг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж, шагналыг билгийн тооллын өвлийн сүүл сарын шинийн 25-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд гардуулна. Шалгарсан өвлөн уламжлагчид Хүндэт өргөмжлөл, гучин сая төгрөгийн мөнгөн шагнал олгохоор зохицуулжээ.³⁷

Дээрх журамд заасны дагуу мөнгөн шагнал авсан өвлөн уламжлагчдын хувьд Өвөрхангай аймгийн Өлзийт сумын иргэн, олноо “Дөмөн” хэмээн алдаршсан уртын дууч Д.Дулмаа (2018), Нийслэлийн Баянзүрх дүүргийн иргэн, туульч А.Балдандорж (2019), Увс аймгийн Малчин сумын иргэн, баяд бийч, ихэлч Ж.Хумбаа (2020), Өвөрхангай аймгийн Баян-Өндөр иргэн, хөхүүр урлаач, “Түүний айраг исгэх уламжлалт арга технологи” өвийг өвлөн уламжлагч Д.Гүндэгмаа (2021), Ховд аймгийн Чандмань сумын харьяат иргэн “Монгол хөөмэйн уламжлалт урлаг” өвийг өвлөн уламжлагч Д.Цэрэндаваа (2022)³⁸, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын уугуул, Алтанбулаг сумын харьяат иргэн

³⁷ Тус журамд зааснаар Өвлөн уламжлагч шагнал гардуулах ёслолын арга хэмжээнд биеэр ирэх боломжгүй бол Монгол Улсын Ерөнхий сайдын бие төлөөлөгч оршин суугаа газарт нь очиж гардуулж өгнө. Өвлөн уламжлагч нас барсан бол шагналыг түүний гэр бүлийн гишүүнд гардуулж өгнө. Шагнал олгосон өвлөн уламжлагчийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг соёл, урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

³⁸ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, «Соёлын биет бус өвийн 2022 оны шилдэг өвлөн уламжлагч шалгарлаа», accessed 22 Аравдугаар сар 2024, <https://moc.gov.mn/news/EvuA1FDHNdolX9EoMeWKvkdglAQ5Q5U>.



“Эсгий ширмэл урлал” өвийг өвлөн уламжлагч Д.Цэндсүрэн (2023)³⁹ нар шалгарсан байна.

Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчтай холбоотой харилцааг СӨХТХ-д заасан шаардлагын хүрээнд зохицуулагдаж чадсан байна.

4.Соёлын өвийн зэрэглэл

Түүх соёлын үл хөдлөх дурсгалын эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ, цэнэ, ач холбогдлыг харгалзан улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалтын зэрэглэл тогтооно. Түүх соёлын хөдлөх дурсгалтай зүйлийн эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан үнэт, хосгүй үнэт зэрэглэл тогтооно гэж СӨХТХ-д заасан.⁴⁰ Мөн соёлын биет бус өвийг түүх, соёл, урлаг, гоо зүй болон шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний жагсаалт болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад бүртгэнэ.⁴¹

Түүнчлэн СӨХТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар:

- “8.6.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журмыг Засгийн газар батална.
- 8.7.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 8.8.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан зэрэглэлийг шатлан дэвшүүлэх зарчмаар тогтоох бөгөөд давхардуулж тогтоохгүй.” гэсэн нэмэлтийг Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт баталсан байна.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 269 дугаар тогтоолоор Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журмыг⁴² баталсан байна.

Энэхүү журмаар зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд нь дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх. Эх төрх, бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны хувьд хосгүй гайхамшигт үнэ цэнэ, ач холбогдолтой, ур

³⁹ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, «Монгол Улсын соёлын биет бус өвийн 2023 оны шилдэг өвлөн уламжлагчийг тодруулав», accessed 22 Аравдугаар сар 2024, <https://mnc.gov.mn/news/0201>.

⁴⁰ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэг.

⁴¹ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг.

⁴² «Журам батлах тухай (Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх)», Засгийн газрын 2022 оны 291 дугаар тогтоол §, accessed 16 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/>.



хийцийн хувьд дахин давтагдашгүй байх нөхцөл нь хосгүй үнэт дурсгалт зүйлийн үндсэн шалгуур болохоор зохицуулжээ.

Хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх дурсгалт зүйл нь дараах шаардлагад нийцсэн байхаар журамд тусгажээ. Үүнд:

- 1.эх хувь байх;
- 2.тухайн төрлийн дурсгалт зүйлийн сонгодог төлөөлөл байх;
- 3.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний язгуур эрх ашигт харшлахгүй байх;
- 4.өмчлөлийн маргаангүй байх;
- 5.судалгаа шинжилгээний эргэлтэд орсон, олон нийтэд танигдсан байх;
- 6.түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлтэй байх;
- 7.Монгол Улсын түүхэнд гарамгай гавьяа байгуулсан төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, урлаг, соёлын алдартан зэрэг гавьяат үйлстэнд зориулан төрөөс тусгайлан захиалж, үйлдвэрийн аргаар бүтээлгэсэн дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлж болно.⁴³

Дээрх шаардлага хангасан эсэхийг Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд байгаа мэдээлэлд үндэслэн тодорхойлох бөгөөд шаардлага хангасан дурсгалт зүйлийн өмчлөгч, эзэмшигч нь хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх саналаа энэхүү⁴⁴ баримт бичгийн хамт Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ.⁴⁵ Соёлын өвийн үндэсний төв нь баримт бичгийн бүрдлийг хянаж, хүлээн авна.

Соёлын өвийн үндэсний төвийн захирлын шийдвэрээр томилогдсон шинжээчийн комисс хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийг холбогдох шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргана.⁴⁶ Мөн Соёлын өвийн үндэсний төв хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн бүрэн бүрдэл бүхий баримт бичгийг байгууллагын цахим хуудаст ажлын 10-аас доошгүй өдөр байршуулж,⁴⁷ олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулна.

Соёлын өвийн үндэсний төв нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн талаар дор дурдсан байгууллагаас санал авах ажлыг зохион байгуулна. Үүнд:

⁴³ Харин бусад үйлдвэрийн аргаар ижил хэлбэр, хэмжээтэй бүтээсэн дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэхгүй.

⁴⁴ 1.дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх саналаа илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, эсхүл албан бичиг;
2. журамд заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
3.түүх, соёл, урлаг судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээний байгууллагын тодорхойлолт;

4.дурсгалт зүйлийн гэрэл зураг, дүрс бичлэг, холбогдох бусад зүйл.

⁴⁵ Баримт бичгийн бүрдэл дутуу бол дурсгалт зүйлийн өмчлөгч, эзэмшигчид буцаана.

⁴⁶ Шинжээчийн комиссын бүрэлдэхүүнд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн өмчлөгч, эзэмшигчтэй хамаарал бүхий этгээдийг оруулахыг хориглоно.

⁴⁷ «Өв нэр дэвшүүлэх 2024», н. Одоогийн Соёлын өвийн үндэсний төвийн веб сайтад байршуулсан байгаа өвийн мэдээлэл, accessed 16 Аравдугаар сар 2024, <https://ncch.gov.mn/%D3%A8%D0%92%20%D0%9D%D0%AD%D0%A0%20%D0%94%D0%AD%D0%92%D0%A8%D2%AE%D2%AE%D0%9B%D0%AD%D0%A5%202024>.



- 1.соёл, урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;
- 2.Шинжлэх ухааны академи;
- 3.түүх, соёл, урлагийн судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3-аас доошгүй эрдэм шинжилгээний байгууллага.

Соёлын өвийн үндэсний төв бүрдүүлсэн холбогдох баримт бичиг, санал, дүгнэлтийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Соёлын өвийн үндэсний төвөөс ирүүлсэн хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлсэн дурсгалт зүйлийн талаарх асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл”-өөр хэлэлцүүлж, санал, дүгнэлт гаргуулна.

Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн, холбогдох шаардлагыг хангасан дурсгалт зүйлд хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр⁴⁸ журамд заасан байна.

Гэвч “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл”-ийн ажиллах журам батлагдаагүй өдийг хүрсэн байна. Эндээс үзвэл түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх асуудал эрх зүйн хувьд зогсонги байдалд орсон байгаа харагдаж байна.

Иймд “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэргэжлийн зөвлөл”-ийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг яаралтай батлах шаардлагатай байна.

Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 392 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журмыг⁴⁹ баталсан байна.

Энэхүү журмаар Монголын ард түмний уламжлалт мэдлэг, арга ухаан, сэтгэлгээний илэрхийлэл болсон түүх, соёл, урлаг, гоо зүйн болон шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдолтой соёлын биет бус өвийг төлөөллийн үндэсний жагсаалтад бүртгэнэ. Оролцогч талуудын хүчин чармайлтаас үл хамааран өвийн оршин тогтнох чадвар нь устах, мартагдах аюулд орж, яаралтай хамгаалах хэрэгцээ, шаардлага үүссэн бол яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэнэ.

Монгол Улсын иргэн, бүлэг хүн, хамт олон, хуулийн этгээд соёлын биет бус өвийг үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх саналыг Соёлын өвийн үндэсний төвд гаргана. Үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх соёлын биет бус өв нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.1.4-т заасан улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй байна. Үүнд:

⁴⁸ Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг зэрэглэлд хамруулах ажлыг 1995 оноос эхлэн зохион байгуулж ирсэн. 2021 оны байдлаар Засгийн газрын 18 удаагийн тогтоол шийдвэрээр улс, орон нутгийн музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль, сүм хийд, Үндэсний номын сан, Эрдэнэсийн сан зэрэг нэр бүхий 27 байгууллагад хадгалагдаж буй 778 хөдлөх дурсгалт зүйл Монгол Улсын “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-д бүртгэгдсэн байна. <https://ncch.gov.mn/movable>

⁴⁹ «Журам батлах тухай (Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам)», Засгийн газрын 2022 оны 392 дугаар тогтоол §, accessed 18 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/>.



1. саналын үндэслэлийг тодорхой дурдсан өргөдөл, албан бичиг;
2. тухайн өвийг өвлөн уламжилсан 3-аас доошгүй өвлөн уламжлагчийн санал (бичиг, дуу-дүрсний болон дууны бичлэг байж болох);
3. өвийг илэрхийлэх гэрэл зураг, эсхүл дүрс бичлэг, холбогдох баримт бичиг.⁵⁰

Соёлын өвийн үндэсний төв нь бүрдэл хангасан саналын дагуу соёлын биет бус өвийн төлөв байдалд хөндлөнгийн шинжээчээр үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулна. Энэхүү дүгнэлтэд дараах зүйлсийг тодруулахаар заасан байна:

(1). үүсэл хөгжил, хувирал өөрчлөлт, уламжлал шинэчлэлийг илэрхийлэх эх сурвалжийн баялаг байдал; (2). бусад өвийн төрөл зүйлээс ялгарах онцлог шинж, тархалт; (3). оршин тогтнох чадвар болон оролцогч талуудын өвийг хамгаалах чиглэлээр гаргаж байгаа хүчин чармайлт байхаар заажээ. Энэхүү хөндлөнгийн шинжээч нь соёлын биет бус өвийн чиглэлээр мэргэшсэн, эрдмийн зэрэг, цолтой, Монгол Улсын иргэн, эсхүл мэргэжлийн төрийн бус байгууллага байна.

Тус үнэлгээ хийх аргачлалыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар уг журамд заасан байна.⁵¹ Гэвч үнэлгээ хийх аргачлал өдийг хүртэл батлагдаагүй байна. Засгийн газрын тогтоолоор баталсан Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам батлагдсан хэдий ч журам дотор дахин аргачлал батлахаар оруулж өгсөн нь СӨХтХ-ийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Цаашид хуулиар Засгийн газарт өгсөн чиг үүргийг Засгийн газар нь Засгийн газрын гишүүндээ дахин эрх олгох байдлаар журамд аргачлал боловсруулах зэргээр тусгах нь хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх уялдаа холбоог алдагдуулж байгааг анхаарах шаардлагатай байна.

⁵⁰ Соёлын өвийн үндэсний төв саналын бүрдлийг ажлын 7 хоногт багтаан хянана. Бүрдэл дутуу саналыг зөвлөмжийн хамт иргэн, хуулийн этгээдэд буцаана.

⁵¹ Журам батлах тухай (Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам), сес уг журмын 2.7 дахь хэсэгт заасан.



Хоёр.Соёлын өвийг хамгаалах төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, тэдгээрийн уялдаа холбоо

Үнэлэх хэсэг	13.1.3.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо, дүрмийг батлах 13.1.6.соёлын өвийн үзлэг, тооллого хийх, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг тус тус батлах 13.1.7.улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах 13.1.8.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах 13.1.9.Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах 13.1.10.соёлын биет өвийг хувиан олшруулах, гэрэл зураг, дүрс бичлэг хийх журам батлах 13.1.11.соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам батлах 13.1.14.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалт болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтыг тус тус батлах 14.1.4.соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журмыг тус тус батлах 14.1.5.аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батлах 14.1.6.түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах 14.1.12.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах палеонтологийн, археологийн, соёлын биет бус өвийн, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн, соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах; 14.1.13.соёлын өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх журам батлах 15.1.4.харьяалах нутаг дэвсгэр дэх түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалах чиглэлээр санал гаргах 15.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг батална
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

Соёлын өвийг хамгаалах төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, тэдгээрийн уялдаа холбооны асуудлын эрх зүйн үндсийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын гуравдугаар бүлэгт хуульчлан тогтоосон. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Соёлын асуудал эрхэлсэн



төрийн захиргааны байгууллага, Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Аймаг, нийслэлийн Засаг дарга, Сум, дүүргийн Засаг дарга, Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, Баг хорооны Засаг дарга зэрэг субъектүүдийн соёлын өвийг хамгаалах асуудлын хүрээнд эдлэх бүрэн эрхийг тус тус хуульчилжээ.

Үүнээс нэн тэргүүнд нутаг дэвсгэр, чиг үүрэг, шатлан захирах ёсны давхардал эдгээр субъектүүдийн эдлэх бүрэн эрхийн хүрээнд үүссэн эсэхийг нягталсан бөгөөд хууль зүйн техникийн хувьд ийм алдаа ажиглагдаагүй тул “үнэлэх хэсэг”-ийн объектыг тодорхойлохдоо соёлын өвийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээний хүрээнд баталбал зохих баримт бичгүүд батлагдсан эсэх тухай асуудлыг авч үзлээ. Учир нь эдгээр баримт бичгүүдийг батлах буюу үйлдсэнээр соёлын өвийг хамгаалах арга хэмжээ бодитоор хэрэгжих эрх зүйн үндэс бүрдэх ач холбогдолтой юм.

Засгийн газар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн дэлхийн болон үндэсний соёлын өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо, дүрмийг баталсан эсэх

“Дэлхийн өвийн дурсгалт газрын хамгаалалтын захиргаа байгуулах” тухай 299 дүгээр тогтоолыг 2018 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Засгийн газраас баталсан байна. Уг тогтоолоор дэлхийн өвд бүртгэгдсэн газар нутгийг хадгалж хамгаалах, судлах, сурталчлах үүрэг бүхий “Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа”, “Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа”-г тус тус байгуулжээ. Тус тогтоолын нэгдүгээр хавсралтаар Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоог дарга, бүртгэл судалгаа мэдээллийн хэсгийн 3 ажилтан⁵², хамгаалалтын хэсэгт 4 ажилтан⁵³, захиргаа аж ахуйн хэсэг 4 ажилтан⁵⁴ нийт 12 орон тоотой байхаар баталсан. Мөн тогтоолын хоёрдугаар хавсралтаар Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоог дарга, бүртгэл судалгаа мэдээллийн хэсэгт 3 ажилтан⁵⁵, хамгаалалтын хэсэгт 4 ажилтан⁵⁶, захиргаа аж ахуйн хэсэгт 4 ажилтан⁵⁷ нийт 12 орон тоотой байхаар баталжээ.

Дээр дурдсан хамгаалалтын захиргааны дүрмийг Дүрэм батлах тухай 12 дугаар тогтоолоор 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Засгийн газраас баталсан. Тус тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргааны дүрэм”-ийг, хоёрдугаар хавсралтаар “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны дүрэм”-ийг тус тус баталжээ. Уг дүрэм нь бүтцийн хувьд нийтлэг үндэслэл, хамгаалалтын захиргааны чиг үүрэг, хамгаалалтын захиргааны бүтэц, удирдлага гэх гурван зүйлээс бүрдэхээр тогтоосон.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн бөгөөд дээрх хамгаалалтын захиргааны бүтэц, орон тоо, дүрмийг баталсан тогтоолууд 4-6 жилийн дараа батлагджээ.

⁵² Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санч, байгалийн өвийн бүртгэл мэдээллийн санч, дурсгалт газрын судалгаа, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн.

⁵³ Харуул хамгаалалтын ажилтан.

⁵⁴ Архив, бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч, Гадаад харилцаа менежмент хариуцсан мэргэжилтэн, жолооч.

⁵⁵ Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санч, байгалийн өвийн бүртгэл мэдээллийн санч, дурсгалт газрын судалгаа, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн.

⁵⁶ Харуул хамгаалалтын ажилтан.

⁵⁷ Архив, бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч, Гадаад харилцаа менежмент хариуцсан мэргэжилтэн, жолооч.



Засгийн газар соёлын өвийн үзлэг, тооллого хийх, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журмыг баталсан эсэх

Засгийн газраас 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн “Журам батлах тухай” 184 дүгээр тогтоолоор "Соёлын биет бус өвийн үзлэг хийх журам", "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам", "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам"-ыг тус тус баталжээ. Мөн “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам”-ыг Засгийн газраас 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн “Журам батлах тухай” 121 дүгээр тогтоолоор баталсан. Үүнээс үзвэл Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. дэх хэсгийн 13.1.6 дахь заалтад заасан бүх журам батлагджээ. Гэвч Соёлын өвийг хамгаалах тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 4 жил орчим хугацаа өнгөрсний дараа эдгээр журмууд батлагдсан байна.

Засгийн газар улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталсан эсэх

"Улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ыг Засгийн газраас 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 13 дугаар тогтоолоор баталжээ. Уг тогтоол гарсантай холбогдуулан "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 175 дугаар тогтоолыг хүчингүй болгосон. Тус жагсаалтаар 20 аймаг, 127 сум, нийслэл хотын 6 дүүрэгт байрлах “улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг баталсан. Тус жагсаалтын дугаарлалтад Засгийн газрын 2021 оны 179 дүгээр тогтоол, 2024 оны 65 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт орсон бөгөөд энэ нь зарим “үл хөдлөх дурсгал”-ыг жагсаалтад нэмэх буюу хассантай холбоотой юм.

Засгийн газрын 2021 оны 179 дүгээр тогтоолоор Архангай аймгийн Батцэнгэл сумын “Шивэртийн амны цогцолбор дурсгал”, Өгийнуур сумын “Чилэн балгас”, Тамирын Улаан хошууны Хүннүгийн оршуулгын газар, Өлзийт сумын Харганын дөрвөлжин, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын “Цагаан асгын цогцолбор дурсгал”, Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын “Чихэн-Агуй”, Баян-Овоо сумын “Уран хайрханы чулуун зэвсгийн бууц”, Говь-Алтай аймгийн Бигэр сумын “Бигэр Номун ханы хийдийн туурь”, Дарви сумын “Турван эрээний нурууны палеонтологийн дурсгалт газар”, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын “Дагвансүндэл бурхан”, Дорноговь аймгийн Сайншанд сумын “Хамрын хийдийн туурь”, Сайхандулаан сумын “Хар хөтлийн палеонтологийн дурсгалт газар”, Сэлэнгэ аймгийн Мандал сумын “Бороогийн дөрвөлжин”, Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн “Их тэнгэрийн амны хадны зураг”, Сүхбаатар дүүргийн “Маршал харш (Х.Чойбалсангийн өвлийн ордон)”, “Богд хааны ногоон ордны өмнөх 2 ширхэг чулуун арслан” зэрэг үл хөдлөх дурсгалыг тус тус нэмжээ.

Харин тус тогтоолоор Баянхонгор аймгийн Өлзийт сумын “Уран хайрхны чулуун зэвсгийн бууц”, Завхан аймгийн Яруу сумын “Хөшөөтийн амны хүн чулуун хөшөө”, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн “Их тэнгэрийн амны хадны зураг” зэрэг үл хөдлөх дурсгалыг хасжээ.

Засгийн газрын 2024 оны 65 дугаар тогтоолоор дээрх жагсаалтаас ямар нэгэн үл хөдлөх дурсгалыг хасаагүй бөгөөд нийт 12 “түүх, соёлын үл хөдлөх дурсгал”-ыг нэмсэн. Өдгөө “улсын хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д нийт 96 “түүх, соёлын үл хөдлөх дурсгал” бүртгэлтэй байна.



Засгийн газар түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг баталсан эсэх

Хамгийн анх 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг батлах тухай” Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор уг жагсаалт батлагдаж байсан бөгөөд энэхүү тогтоол одоо ч хүчинтэй хэвээр байгаа юм. Харин тус тогтоолын 1 дүгээр хавсралтад Засгийн газрын 2010-04-28-ны өдрийн 103 дугаар тогтоолоор 290-593 дахь заалт нэмж, “зохиогч” гэснийг “бүтээлч” гэж өөрчилсөн, Засгийн газрын 2011-12-28-ны өдрийн 373 дугаар тогтоолоор 610-670, Засгийн газрын 2012-02-29-ний өдрийн 58 дугаар тогтоолоор 671, Засгийн газрын 2012-04-04-ний өдрийн 105 дугаар тогтоолоор 672-748, Засгийн газрын 2013-6-26-ны өдрийн 227 дугаар тогтоолоор 749-776, Засгийн газрын 2015-9-28-ний өдрийн 390 дугаар тогтоолоор 777, Засгийн газрын 2019 оны 360 дугаар тогтоолоор 778 дахь заалтыг тус тус нэмсэн агуулга бүхий өөрчлөлтүүд оржээ.

Засгийн газар дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан эсэх

Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн “Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай” 251 дүгээр тогтоолоор баталсан боловч уг тогтоолыг нэгдүгээр хавсралт буюу “Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн”-ийг баталсан хэсэг нь Засгийн газрын 2022 оны 250 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Харин 2018 оны 251 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Дэлхийн өвийн үндэсний хорооны ажиллах журам” нь хүчин төгөлдөр хэвээр байна.

Ийнхүү 2022 оны 250 дугаар тогтоол гарснаас хойш “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 2024 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтаар “Дэлхийн өвийн үндэсний хорооны бүрэлдэхүүн”-ийг баталснаар хуульд заасан журмын бүрдэл хангагджээ. Үүнээс үзвэл Соёлын өвийг хамгаалах тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 4 жил орчим хугацаа өнгөрсний дараа эдгээр журам батлагдаж, мөн 4 жилийн дараа зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэгдсэн байна.

Засгийн газар соёлын биет өвийг хувиран олшруулах, гэрэл зураг, дүрс бичлэг хийх журмыг баталсан эсэх

Соёлын өвийг хамгаалах тухай 2001 оны хуулийн хүрээнд батлагдсан Засгийн газрын “Журам батлах тухай” 2003 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан өмнөх журам нь Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралт “Нийтийн өмчийн соёлын биет өвийг хувиран олшруулах, гэрэл зураг, дүрс бичлэг хийх журам” батлагдсанаар бүхэлдээ хүчингүй болж уг шинэ журам үйлчлэх болжээ. Ийнхүү Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш даруй 10 жилийн дараа тус журмыг шинэчлэн баталсан байна.

Засгийн газар соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг журмыг баталсан эсэх

“Соёлын өвийг хамгаалахад идэвх, санаачилгатай оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ыг Засгийн газрын “Журам шинэчлэн батлах тухай” 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 343 дугаар тогтоолоор баталжээ. Уг тогтоол батлагдсантай холбогдуулан Соёлын өвийг хамгаалах тухай 2001 оны хуулийн хүрээнд батлагдан хэрэгжиж байсан “Журам батлах тухай” Засгийн газрын 2003 оны 1 дүгээр



сарын 30-ны өдрийн 23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт бүхий өмнөх журмыг хүчингүй болгосон юм. Ийнхүү Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 3 жил орчим хугацааны дараа тус журмыг шинэчлэн баталжээ.

Засгийн газар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалт болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалтыг баталсан эсэх

2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үндэсний жагсаалт батлах тухай” Засгийн газрын 475 дугаар тогтоолоор Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-ыг баталсан. Мөн 2022 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн “Журам батлах тухай” 392 дугаар тогтоолоор "Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам"-ыг баталжээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд "Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалт"-ыг батлахаар заасан болов ч Засгийн газраас уг жагсаалтыг батлахад шалгуур болгох журмыг баталсан байна. Иймээс цаашид тус хуулийн хэрэгжилтийг хангахын тулд хуулиар тухайлан заасан тус үндэсний жагсаалтыг батлах шаардлагатай байна.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журмыг баталсан эсэх

Эдгээр журмууд нь өдгөө хараахан батлагдаагүй бөгөөд Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний 2021-2023 оны тайланд⁵⁸ эдгээр журмуудын талаар тусгагдаагүй буюу хяналт шинжилгээ, үнэлгээний объект болоогүй байна. Харин Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 4 дугаар сарын 23-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/235 дугаартай тушаалаар “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

Дээрх төлөвлөгөө ёсоор “Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам”-ыг 2019 онд багтаан батлахаар тусгасан байна. Дээрх журмын төслийг Соёлын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулж, санал авах тухай мэдээлэл⁵⁹ 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан боловч уг журам болон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журам батлагдаагүй хэвээр байна.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталсан эсэх

Соёлын өвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг жагсаалтыг батлахаар хуульчлагдсан байна.

⁵⁸ <https://moc.gov.mn/news/monitoring>

⁵⁹ <https://www.unuudur.mn/a/169645>



Соёлын сайдын 2022 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн А/348 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтын зэрэглэлд нэр дэвшүүлэх, хянан шийдвэрлэх журам”-ыг баталжээ. Уг журам батлагдсан цагаасаа хэрэгжиж буй бөгөөд уг зэрэглэлд нэр дэвшиж, хянан шийдвэрлэгдсэн үл хөдлөх дурсгалыг жагсаан батлах боломжтой болсон байна.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалтыг баталсан эсэх

Соёлын өвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8 дугаар зүйлд “Соёлын өвийн зэрэглэл”-ийн талаар зохицуулсан бөгөөд мөн зүйлийн 8.2 дахь хэсэгт “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн эх төрх бүрэн бүтэн байдал, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдлыг харгалзан үнэт хосгүй үнэт зэрэглэл тогтооно” гэж заасан. Гэвч тус зүйлийн 8.3 дахь хэсэгт заасан түүх, соёлын үнэт, хосгүй үнэт зэрэглэлийг тогтоох шалгуурыг 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу хүчингүй болгосноор өдгөө “түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн жагсаалт”-ыг батлах тодорхой шалгуургүй болсон байна.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага палеонтологийн, археологийн, соёлын биет бус өвийн, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн, соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан эсэх

Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам, 2004 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 183/111 дүгээр “Журам батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд болон Дэд бүтцийн сайд нарын хамтарсан тушаалаар батлагдаж байжээ. Мөн Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам Соёлын сайд болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/509, А/562 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” хамтарсан тушаалаар батлагдсан байна. Энэ мэт суурь шинжтэй журмуудыг шинэчлэн батлахаас өмнө мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг батлах бодит боломж хомс бөгөөд уг журмыг боловсруулж, санал авч, батлуулах үйл ажиллагаа шат дараатай явагдаж буй талаар Соёлын яамны холбогдох албан тушаалтнууд ярилцлагын явцад дурдаж байв.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх журам баталсан эсэх

“Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” нь 2009 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн “Журам шинэчлэх батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 78 дугаар тушаалаар батлагдсан байна. Уг тушаалаар батлагдсан тус журам нь хэдийгээр Соёлын өвийг хамгаалах тухай 2001 оны хуулийн хүрээнд батлагдсан боловч өдгөө шинэчлэгдээгүй, хүчин төгөлдөр хэвээр байгаа юм.

Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал харьяалах нутаг дэвсгэр дэх түүх, соёлын дурсгалт газрыг хамгаалах чиглэлээр санал гаргасан тохиолдол бий эсэх

Баянхонгор аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн “Зарим газар нутгийг сумын тусгай хамгаалалтад авах тухай” 13/16 дугаартай тогтоолоор “Түүх-Археологийн дурсгалыг хамгаалах зорилгоор Хөндлөн булаг 3 дугаар багийн Бэлийн бууцад байрлах булш, хиргисүүрийг орон нутгийн тусгай хамгаалалтад хугацаагүйгээр авах” талаар шийдвэрлэхдээ Соёлын өвийг



хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтыг үндэслэл болгожээ.

Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сум, дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг баталсан тохиолдол бий эсэх

Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 08/07 дугаартай тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Өвөрхангай аймгийн сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг баталсан байна.

Гурав.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо

Үнэлэх хэсэг	20.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь дараах тогтолцоотой байна: 20.1.1.байгууллагын бүртгэл, мэдээллийн сан; 20.1.2.сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан; 20.1.3.аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан; 20.1.4.улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

СӨХТХ /шинэчилсэн найруулга/-ийн зорилтод⁶⁰ соёлын өвийг бүртгэх эрх зүйн харилцааг тусгаж өгсөн ба соёлын өвийг биет /түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгал/ болон биет бус хэмээн ангилж⁶¹, бүртгэл, мэдээллийн санг⁶²:

- Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан;
- Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан;
- Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан;
- Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоотой байхаар зохицуулсан.

Сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санг соёлын төвд, аймгийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн музейд, нийслэлийн бүртгэл мэдээллийн санг нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид, улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгалахаар⁶³ зохицуулж дараах дараах аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлэх үүргийг хүлээжээ⁶⁴.

- Монголбанк;
- Дурсгалт газрын хамгаалалтын захиргаа;
- Музей, галерей, номын сан, сүм хийд;
- Эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лаборатори;
- Үндэсний төв архив бүрдүүлэх үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хүлээжээ.

⁶⁰ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг.

⁶¹ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэг.

⁶² Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг.

⁶³ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг.

⁶⁴ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг.



Дээрхээс үзвэл соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан нь нийт 4 тогтолцоогоор, дараах субъектуудад харъяалагдан бүртгэл мэдээллийн санг бүрдүүлдэг болох нь харагдаж байна /Хүснэгт №1-с харах/⁶⁵.

Хүснэгт №1

Бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо	Тогтолцооны дагуу бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэгч субъект	Тухайн бүртгэл, мэдээллийн санд бүрдүүлэх соёлын өвийн бүртгэл мэдээлэл
Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан	-Улс, аймаг, орон нутгий музей, галерей; -Үндэсний номын сан; -Эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны лаборатори; -Монголбанкны Эрдэнэсийн сан; -Үндэсний төв архив.	Тухайн байгууллагын өмчлөл, эзэмшил дэх түүх соёлын хөдлөх дурсгалт зүйл
	-Дурсгалт газрын хамгаалалтын захиргаа	Тухайн хамгаалалтын бүс дэх соёлын өвийн бүртгэл мэдээлэл
Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан	Соёлын төвд	Харъяалах баг, хорооны нутаг дэвсгэр дэх -Түүх, соёлын үл хөдлөх дурсгал -Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл -Соёлын биет бус өв
Аймаг Нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан	-Орон нутгийн музей; -Нийслэлийн засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгж буюу соёл урлагын газар.	Харъяалах сум, дүүргийн нутаг дэвсгэр дэх -Түүх, соёлын үл хөдлөх дурсгал -Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл -Соёлын биет бус өв
Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан	Соёлын өвийн үндэсний төв	21 аймаг, нийслэл дэх -Түүх, соёлын үл хөдлөх дурсгал -Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл -Соёлын биет бус өв

⁶⁵ <http://ncch.gov.mn/>, ил тод байдал, үйл ажиллагааны ил тод байдал, соёлын өвийн УНБМСангийн танилцуулга, 5 дугаар хуудас, сүүлд 2024 оны 10 сарын 16-ны өдөр хандсан.



1.Бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо

Хүснэгт №1-т заасанчлан байгууллагын бүртгэл, мэдээллийн санг *тухайн байгууллага*, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санг *соёлын төвд*, аймгийн бүртгэл мэдээллийн санг *орон нутгийн музейд*, нийслэлийн бүртгэл мэдээллийн санг *нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид*, улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг *Соёлын өвийн үндэсний төвд* тус тус бүрдүүлж хадгалах зохицуулалтыг СӨХТХ-д тусгасан.

Түүнчлэн тухайн байгууллагын бүртгэл, мэдээллийн сан нь жилд 4 удаа *сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд*, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд 2 удаа *аймаг, нийслэлийн бүртгэл мэдээллийн санд*, аймаг, нийслэлийн бүртгэл мэдээллийн сан нь жилд 1 удаа улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тайлангаа хүргүүлэхээр⁶⁶ заасан.

Гэвч СӨХТХ-д *төрийн болон орон нутгийн музей нь* тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага⁶⁷ байна хэмээн заасан нь *төрийн музейн болон нийслэлийн засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжийн* хувьд нийслэл дэх бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлэгч байгууллага давхардсан болохыг харуулж байна. Иймд энэхүү байгууллагын эрх, үүргийг тодорхой тусгах нь зүйтэй байна.

№	Ярицлага
1.	*Соёл, урлагийн газар болон музейн хувьд бүртгэлийг хэн хийх үү? гэдэг асуудал одоо гараад ирчихсэн явж байгаа. Энэ талаар нарийн зохицуулсан журам байхгүй. Энэ асуудал соёл урлагийн газар гарч ирсэнээс хойш яригдсан. *Байгууллагуудын хувьд сүүлийн 2 жилээс тайлангаа хүргүүлж байна. Соёл урлагийн судалгаа хийдэг байгууллагуудын хувьд тайланг өнөөдрийн хувьд ирүүлээгүй байна. Энэ нь байгууллагууд хэрхэн тайлан хүргүүлэх талаар тодорхой зохицуулалтгүй байгааг илэрхийлж байна.

2.Соёлын өвийг бүртгэх бүртгэлийн харилцаа

Соёлын өвийг бүртгүүлэх субъектын тухай

СӨХТХ-д нийтийн өмчийн соёлын биет өвийн талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэж⁶⁸ нийтийн өмчөөс бусад соёлын биет өвийг өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зохих шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлж болох⁶⁹-оор зохицуулсан. Өөрөөр хэлбэл нийтийн өмчийн биет өв соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгэгдэх, хувийн өмчийн соёлын биет өв тухайн өмчлөгч, эзэмшигчийн хүсэлтээр бүртгэгдэж болох эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

Гэвч тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.1, 32.2.2-т “*Соёлын биет өвийг эзэмшигч соёлын өвийн бүртгэл хөтөлж, бүртгэл, мэдээллийн сан үүсгэх, дээд шатны бүртгэл,*

⁶⁶ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, сес 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг.

⁶⁷ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, сес 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг.

⁶⁸ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, сес 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг.

⁶⁹ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, сес 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг.



мэдээллийн санд бүртгүүлэх”, 33 дугаар зүйлийн 33.2.2-т “Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд харъяалах аймаг, нийслэлийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх” үүргийг тус тус хүлээсэн нь хуульд нэг төрлийн харилцаанд хоёр өөр эрх зүйн хэм хэмжээг тусгасан болохыг илэрхийлж байна.

Өөрөөр хэлбэл соёлын өвийг өмчилж, эзэмшиж байгаа иргэн хуулийн этгээд тухайн соёлын өвөө бүртгүүлэх үүрэгтэй юу? өөрийн хүсэл, сонирхлын үндсэн дээр бүртгүүлж болох уу? гэдэг хэм хэмжээний зохицуулалт яригдаж байна.

Иймд иргэн, хуулийн этгээдийн соёлын биет өвийг бүртгүүлэх эрх зүйн зохицуулалтыг нэг хэм хэмжээнд оруулах нь зүйтэй. Учир нь нэг харилцаанд хоёр өөр төрлийн эрх зүйн хэм хэмжээг хуульд тусгаснаар тухайн соёлын биет өвийг өмчилж, эзэмшиж буй иргэн, хуулийн этгээдийн хувьд эрх ашиг зөрчигдөх эрсдэлтэй болно.

Харин соёлын биет бус өвийн тухайд соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн тухай мэдээллийг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэх⁷⁰ ба соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нь биет бус өвийн бүртгэл хийх, мэдээлэл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх⁷¹ үүргийг хуульд тусгасан нь энэ төрлийн харилцаанд эрх зүйн хэм хэмжээ зөрчилдөөгүй байна.

Дээрхээс дүгнэн үзвэл нийтийн өмчийн соёлын биет өв болон биет бус өв, өвлөн уламжлагчийг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэх үүргийг хуульд тусгасан бол нийтийн өмчөөс бусад соёлын биет өвийг өмчлөгч, эзэмшигч нь тухайн соёлын биет өвөө бүртгүүлэх үүрэгтэй юу? эсхүл өөрийн хүсэл, сонирхлын үндсэн дээр бүртгүүлэх үү? гэдэг асуудал үүсч байна.

Соёлын өвийг хэрхэн бүртгэхтэй холбогдох эрх зүйн хэм хэмжээний тухай

СӨХТХ-д соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам, биет бус өвийг өвлөн уламжлагчийг тогтоох, бүртгэх журам⁷² болон соёлын өвийг бүртгэл мэдээллийн санд бүртгэх журмыг Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага⁷³, соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх, мэдээллийг ашиглах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх журмыг Монголбанкны Ерөнхийлөгч, соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална⁷⁴ хэмээн заажээ.

Түүнчлэн соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж буй байгууллагуудын хувьд соёлын өвийг бүртгэх эрх зүйн харилцааг хэрхэн тусгасан талаар судлан үзвэл музей нь СӨХТХ-д заасны дагуу бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх⁷⁵, үндэсний номын сан нь түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах ном, судрыг СӨХТХ-ийн дагуу бүртгүүлж, хамгаална⁷⁶ хэмээн заасан нь соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэгч байгууллагуудын хувьд ч соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс баталсан журмаар бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж ажиллахыг илэрхийлж байна.

Дээрхээс үзвэл соёлын өв болон өвлөн уламжлагчийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, гагцхүү

⁷⁰ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг.

⁷¹ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь хэсэг.

⁷² Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 14 дүгээр зүйлийн 14.1.4 дахь хэсэг.

⁷³ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 14 дүгээр зүйлийн 14.1.13 дахь хэсэг.

⁷⁴ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг.

⁷⁵ Музейн тухай хууль, sec 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь хэсэг.

⁷⁶ Номын сангийн тухай хууль, sec 9 дүгээр зүйлийн 9.4.1 дэх хэсэг.



эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх журмыг Монголбанкны ерөнхийлөгч, соёлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй хамтран батлахаар тусгасан байна. Энэ нь соёлын өвийг бүртгэл, мэдээллийн санд бүртгэх үндсэн суурь харилцааг гагцхүү соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, түүнийг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд харьяалагддаг байгууллагууд дагаж мөрдөх, улмаар тухайн байгууллагуудын уялдаа холбоо алдагдахгүй байх, шат шатандаа бүртгэл, мэдээлэл нэг зарчмын дагуу хийгдэх зорилготой юм.

Гэвч СӨХтХууль шинэчлэгдсэн батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Монголбанкны ерөнхийлөгчөөс дээрх журмууд батлагдаагүй дор дурдсан эрх зүйн актуудаар бүртгэл, мэдээллийн сангийн харилцааг зохицуулж байна. Үүнд:

Бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх харилцааны хувьд:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн №78 тоот “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”⁷⁷;
2. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/41-р тушаалын хавсралтаар батлагдсан “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд бүртгэл хөтлөх, ашиглах аргачлал”⁷⁸;

Үл хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх бүртгэлийн тухайд 1-2-т дурдсан журам, аргачлалаас гадна:

3. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан “Монгол Улсын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг хөтлөх заавар⁷⁹;
4. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/15-р тушаалын хавсралтаар батлагдсан “Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэрэг хөтлөх заавар”⁸⁰;

Хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх бүртгэлийн тухайд 1-2-т дурдсан журам, аргачлалаас гадна:

5. Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн №А/355 “Музейн сан хөмрөгийг бүртгэх, баримтжуулах заавар”⁸¹;
6. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан “Монгол Улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл”-ийг хөтлөх заавар⁸²;

Биет бус өв түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх бүртгэлийн тухайд 1-2-т дурдсан журам, аргачлалаас гадна:

⁷⁷ [UNBMSan-juram-2009.pdf](#), <http://ncch.gov.mn/>, хууль эрх, зүй цонхны дүрэм журмын хэсгээс 2024 оны 10 сарын 4-нд үзсэн.

⁷⁸ Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд бүртгэл хөтлөх, ашиглах аргачлал, <http://ncch.gov.mn/>, мэдээлэл цонхны албан тоот хэсгээс 2024 оны 10 сарын 22-нд үзсэн.

⁷⁹ [Microsoft Word - UHD-iig burtgeliin mayagtagd hotloh zaavar-2011.01.31](#), мэргэжил арга зүйн зөвлөгөө цонхны үл хөдлөх дурсгал хэсгээс 2024 оны 10 сарын 22-нд үзсэн.

⁸⁰ [Architectural-Heritage-Registration-Form-Guide.pdf](#), <http://ncch.gov.mn/>, мэргэжил арга зүйн зөвлөгөө цонхны үл хөдлөх дурсгал хэсгээс 2024 оны 10 сарын 22-нд үзсэн.

⁸¹ [заавар.pdf](#), <http://ncch.gov.mn/>, 2024 оны 10 сарын 16-нд үзсэн.

⁸² [Microsoft Word - hudluh burtgeliin zaavar-2011.01.31](#), мэргэжил арга зүйн зөвлөгөө цонхны хөдлөх дурсгал хэсгээс 2024 оны 10 сарын 22-нд үзсэн.



7. Засгийн газрын 2022 оны 392 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам”;
8. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан “Монгол Улсын соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл”-ийг хөтлөх заавар⁸³;

Баримтат өвийг бүртгэх бүртгэлийн тухайд 1-2-т дурдсан журам, аргачлалаас гадна:

9. Соёлын яам, соёлын өвийн үндэсний төвөөс хамтран гаргасан “Монгол Улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал⁸⁴.

Дээр дурдсан эрх зүйн актуудыг нарийвчлан авч үзвэл:

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар батлагдсан 2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн №78 тоот “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам” нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй СӨХтХуулийн соёлын өвийн бүртгэлийн харилцаатай харьцуулахад харьяалагдах байгууллага болон бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо, бүрдэл зэрэг дараах зүйлсээр /Хүснэгт №2-с харах/ зөрчилдөж байна.

Хүснэгт №2

	“Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
Бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо	1.Байгууллага дахь бүртгэл, мэдээллийн сан -Музей -Галерей -Номын сан -Палеонтологийн төв -Археологийн хүрээлэн -Хийд 2.Сум, аймаг, нийслэлийн бүртгэл мэдээллийн сан 3.Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан⁸⁵	1.Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан -Монгол банк -Дурсгалт газрын хамгаалалтын захиргаа -Музей -Галерей -Номын сан -Сүм хийд -Эрдэм шинжилгээний байгууллага -Судалгааны лаборатори -Үндэсний төв архив 2.Сум, дүүргийн бүртгэл мэдээллийн сан

⁸³ [Microsoft Word - Maygt3_Khutlukh_Zaabar](#), мэргэжил арга зүйн зөвлөгөө цонхны соёлын биет бус өв хэсгээс 2024 оны 10 сарын 22-нд үзсэн.

⁸⁴ [“Монгол улсын баримтат өвийн бүртгэл”-д нэр дэвшүүлэх дурсгалыг бүртгэх аргачлал](#), мэргэжил арга зүйн зөвлөгөө цонхны баримтат өв хэсгээс 2024 оны 10 сарын 22-нд үзсэн.

⁸⁵ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн №78 тоот “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ын 2 дугаар зүйлийн, 2.1 дэх хэсэг, <http://ncch.gov.mn/>, сүүлд 2024 оны 10 сарын 16-нд үзсэн.



		3.Аймаг, Нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан 4.Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан ⁸⁶
Бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж хадгалах байгууллага	1.Соёлын өвийг хадгалж байгаа музей, эрдэм шинжилгээний байгууллага, номын сан, сүм хийд нь өөрийн өмчлөл, эзэмшил дэх соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулж, байгууллагынхаа бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлнэ. ⁸⁷ 2.Соёлын өвийг бүртгэл-мэдээллийн санд бүртгэх ажлыг сум, аймаг, нийслэлийн Засаг дарга нар зохион байгуулна. ⁸⁸ 3.Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан нь соёлын өвийн бүртгэлийн програмыг нэвтрүүлэн, соёлын өвийн улсын нэгдсэн сүлжээ, мэдээллийн санг бий болгоно. ⁸⁹	1.Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан соёлын төвд 2.Аймгийн бүртгэл, мэдээллийн сан орон нутгийн музейд 3.Нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан нийслэлийн Засаг даргын дэргэх соёлын асуудал хариуцсан нэгжид 4.Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд ⁹⁰
Бүртгэл, мэдээллийг хүргүүлэх байгууллага	1.Байгууллагын бүртгэл-мэдээллийн сан нь сум, аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн санд, 2.Сумын бүртгэл-мэдээллийн сан нь аймгийн бүртгэл-мэдээллийн санд, 3.Аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн сан нь улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд тус тус бүртгэл, мэдээлэл, тайланг тогтмол хүргүүлнэ ⁹¹	1.Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан нь жилд дөрвөн удаа сум, дүүргийн, 2.Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд хоёр удаа аймаг, нийслэлийн, 3.Аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд нэг удаа улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус тус тайлангаа хүргүүлнэ ⁹²
Бүртгэлийн бүрдэл	1.Соёлын өвийн тодорхойлолт 2.Судалгаа шинжилгээний ажлын товч тайлан 3.Гэрэл зураг, слайд, дуу болон дүрс бичлэгтэй хальс ба цахим зээрэнцэг	1.Соёлын өвийн тодорхойлолт 2.Судалгаа, шинжилгээний ажлын тайлан 3.Сэргээн засварласан ажлын тайлан 4.Үзлэг, тооллого хийхэд хөтөлсөн баримт

⁸⁶ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг.

⁸⁷ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн №78 тоот “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ын 4 дүгээр зүйлийн, 4.8.1 дэх хэсэг, <http://ncch.gov.mn/>, сүүлд 2024 оны 10 сарын 16-нд үзсэн

⁸⁸ Дээрх журмын 4 дүгээр зүйлийн, 4.9.1 дэх хэсэг.

⁸⁹ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн №78 тоот “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ын 4 дүгээр зүйлийн, 4.10.1 дэх хэсэг, <http://ncch.gov.mn/>, сүүлд 2024 оны 10 сарын 16-нд үзсэн.

⁹⁰ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг.

⁹¹ Дээрх журмын 2 дугаар зүйлийн, 2.2 дахь хэсэг.

⁹² Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 23 дугаар зүйлийн 23.2 дэх хэсэг.



	4.Сэргээн засварлах ажлын товч тайлан ⁹³	5.Дотоод, гадаадад гаргасан үзэсгэлэнтэй холбоотой баримт 6.Гэрэл зураг, түүнийг агуулсан хальс, зээрэнцэг 7.Дуу, дүрс агуулсан бүх төрлийн бичлэг 8.Хэв, хуулбар, дардас 9.Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн талаарх мэдээлэл 10.Сэргээн засварлах ажлын хэмжилт, судалгаа, зураг төсөл 11.Бүртгэлд холбогдох бусад хэрэглэгдэхүүн ⁹⁴
Соёлын өвийн бүртгэл	Хөдлөх дурсгал, Үл хөдлөх дурсгал, Утга соёлын өв ⁹⁵	Түүх, соёлын үл хөдлөх дурсгал Түүх, соёлын хөдлөх дурсгал Соёлын биет бус өв

Харин соёлын өвийн үндэсний төвийн захирлын 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/41-р тушаалын хавсралтаар батлагдсан “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд бүртгэл хөтлөх, ашиглах аргачлал” нь Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн систем ашиглахтай холбогдуулан гаргасан буюу тухайн бүртгэл, мэдээллийн системд соёлын өвийг хэрхэн бүртгэх аргачлалыг тусгасан, соёлын өвийг бүртгэх заавруудын тухайд тухайн өвийг хэрхэн бүртгэх, бүрдлийг хэрхэн хийх зэрэг бүртгэл, арга зүйн зааврыг тодорхойлсон байна.

Өөрөөр хэлбэл, дээрх журам, аргачлал, зааварт соёлын өвийг бүртгэх байгууллагуудын ямар эрх бүхий албан тушаалтан бүртгэл, мэдээллийн санг хөтлөх, байгууллагууд хоорондоо хэрхэн харилцах зэрэг байгууллага бүрийг холбосон нарийвчилсан процессын харилцаа зохицуулагдаагүй байна.

Энэ нь соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлж буй байгууллагуудын хооронд тодорхойгүй байдал үүсгэх, бүртгэл мэдээлэл шат шатандаа бүрэн хийгдэж улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Соёлын өвийн үндэсний төвийн бүртгэл мэдээллийн сангийн 2020 оны тайланд Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн 2020 оны тайлан ирүүлэх тухай албан бичгийг нийт 48 байгууллагад хүргүүлснээс 3 байгууллага хариу ирүүлээгүй, тайлан ирүүлсэн 45 байгууллагаас 27 байгууллага тайлангаа хугацаандаа ирүүлсэн бол 18 байгууллага хугацаандаа ирүүлээгүй⁹⁶ хэмээн тусгасан нь соёлын өвийн бүртгэл,

⁹³ Дээрх журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг.

⁹⁴ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг.

⁹⁵ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2009 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн №78 тоот “Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, уг санд бүртгэх журам”-ын 3 дугаар зүйлийн, 3.4 дэх хэсэг, <http://ncch.gov.mn/>, 2024 оны 10 сарын 16-нд үзсэн.

⁹⁶ <http://ncch.gov.mn/>, ил тод байдал, үйл ажиллагааны ил тод байдал, соёлын өвийн УНБМСангийн 2020 оны тайлан, 3 дугаар хуудас, 2024 оны 10 сарын 16-нд үзсэн.



мэдээллийн санг бүрдүүлж буй байгууллагууд бүртгэл, мэдээллийн санг бүрэн хөтөлж, бүртгэл, мэдээлэл шат шатандаа бүрэн хийгдэж буй нь хангалтгүйг илэрхийлж байна.

Түүнчлэн соёлын биет бус өвийг бүртгэж буй Засгийн газрын 2022 оны 392 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан “Соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай үндэсний жагсаалтад бүртгэх журам”-ын тухайд соёлын биет бус өвд бүртгэгдсэн өвүүдийг төлөөллийн болон яаралтай хамгаалах үндэсний жагсаалтад бүртгэх эрх зүйн харилцааг зохицуулсан буюу биет бус өвд бүртгэгдсэнээс хойших өвүүдийн бүртгэлийг зохицуулсан нь энэхүү журмаар биет бус өвийг бүртгэх боломжгүйг илэрхийлж байна.

№	Ярилцлага
1.	*Соёлын биет бус өвийн тухайд бүртгэл бүрдүүлэлтийн хувьд дандаа дутуу ирдэг. Баримтжуулалт, гэрэл зураг зэрэг бүрдүүлэлт дутуу байдаг. Энэ нь орон нутгийн хувьд бүртгэлийг анкетын дагуу хийж буйтай холбоотойгоор хэрэгжилт муу байдаг. *Сум, дүүргийн бүртгэлийн нэгтгэлийг ямар субъект, аймаг, нийслэлийн бүртгэлийг ямар субъект хийж соёлын өвийн үндэсний төв бүртгэлээ хүргүүлэх тодорхойгүй. *Соёлын өвлөн уламжлагчдын асуудлын тухайд зүгээр тоог л бүртгэдэг. Өвийн тодорхойлолт, зэрэглэл, ур чадварын түвшин гээд олон зүйл бүртгэдэггүй. Өвлөн уламжлагчаас гадна өвийн бүртгэл байх ёстой ч өвийн бүртгэл байдаггүй. *Соёлын биет бус өвийн тухайд соёлын биет бус өвийг төлөөллийн болон яаралтай бүртгүүлэх журам байдаг ч энэхүү журам бодит байдал дээр хэрэгждэггүй. Бид энэхүү журмаар бүртгэл хийх ч боломжгүй. Өмнө нь бид мэргэжлийн зөвлөлөөр үнэлүүлдэг байсан бол одоо үнэлгээчнээр үнэлүүлдэг. Гэтэл энэхүү үнэлгээчид болон судлаачид байхгүйгээс бид бүртгэлээ хийж чаддаггүй.
2.	*Соёлын өвийг олсон тохиолдолд 15 хоногийнх дотор бүртгүүлнэ гэсэн заалт практикт хэрэгждэггүй. *Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний оршин байгаа газрыг өмчлөгч, эзэмшигч нь газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлнэ гэдэг ч энэхүү заалтын хэрэгжилт муу. Кадастрын компани түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг кадастрт оруулдаггүй.
3.	*Улсын бүртгэл, мэдээллийн сан гэдэг ч үүний хэрэглээ дутмаг. Учир нь өвийн тооллого хийхэд түүнийг гар аргаар хийдэг. Гар аргаар нэг бүрчлэн тоолохдоо тухайн өвийг эвдэж, гэмтээж байдаг. Энэ утгаараа үзлэг, тооллогын асуудал дутмаг. *Үзмэрийн бүртгэлийн маягт байдаг. Энэ нь нягтлан бодох бүртгэлтэй зөрдөг. Учир нь нягтлан бодох бүртгэлээр элэгдэл, хорогдлыг тооцдог. Гэвч соёлын өвийн тухайд үндсэн хөрөнгийн бүртгэлд ордог ч энэ маань цаг хугацаа явах тусам үнэ нэмэгдэх ёстой тул бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дагуу явах нь буруу. Нягтлан бодох бүртгэлийн хувьд цаг хугацаа явах тусам түүнийг бүртгэлээс хасах асуудал яригддаг. Иймд энэ асуудал дээр зохицуулалт шаардаж байна.. *Бүртгэлийг хэрэгжүүлж буй байдал асуудалтай. Музейн бүртгэн баримтжуулах заавар дээр бүртгэлийг гараар бичнэ гэж заасан. Энэ өнөөдрийн хувьд маш хүндрэлтэй. Хэдэн мянган өвийг гараар бичих нь өөрөө асуудалтай. *Бүртгэн баримтжуулахад эрэл хайгуул хийх зүйл байхгүй. *Бүртгэл хийхдээ дугаар олгодоггүй. Бүртгэл нэгдмэл биш. Бүртгэл нэгдмэл байж дата үүснэ. Энэ дутмаг. *Музей болгон бие даасан дугаар өгдгөөс дугаар замбараагүй явдаг. *Бүртгэлийн бүрдэл, мэдээллийн сан дутуу.



Дээрхээс ярилцлагаас үзвэл соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо нь нийт 4 тогтолцоотойгоор байгууллага, соёлын төв, орон нутгийн музей, нийслэлийн засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгж, соёлын өвийн үндэсний төвүүдэд хуваагдаж буй ч энэхүү байгууллагуудын хоорондох уялдаа холбоо харилцааг нарийвчлан зохицуулсан журам одоогоор байхгүй байна. Энэ нь соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэгч субъектууд шат шатандаа бүртгэл, мэдээллийг бүрэн хийхгүй байх, улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэл, мэдээлэл бүрэн очихгүй байх эрсдэлийг бий болгож байна.

Түүнчлэн соёлын өвийг өв тус бүрээр нь хэрхэн бүртгэх заавар, аргачлалыг Соёлын өвийн үндэсний төвөөс гаргасан ч тухайн соёлын өвийг бүрдүүлж буй субъектуудын хувьд өвийн бүртгэл, мэдээллийг хэрхэн бүрдүүлэх, тухайн бүртгэлийг хэн хөтлөх, хууль тогтоомжид заасны дагуу тайлан мэдээг шат шатандаа хэрхэн бүрдүүлэх зэрэг оролцогч талуудын оролцоог хангасан зохицуулалт байхгүйгээс энэхүү харилцаанд орж буй байгууллагуудын хооронд хэрхэн харилцах нь тодорхойгүй байна.

Иймд соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж буй байгууллага болон оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчилсан зохицуулсан эрх зүйн харилцааны баримт бичгийг бий болгох нь зүйтэй байна.

Соёлын өвийг бүртгэн баримтжуулалтын хүрээнд төрөөс хэрэгжүүлж буй бодлого

Соёлын яамны Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хилийн чанадад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулах⁹⁷-аар тусгаж, Соёлын сайдын 2024 оны 4 дүгээр сарын 23-ний өдрийн А/212 тушаалаар “Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсан ба тухайн чиглэлийг нийт 6 үйл ажиллагааны хүрээнд төлөвлөж, хэрэгжүүлэхээр зохицуулсны нэг нь бүртгэн баримтжуулах үйл ажиллагаа болж байна⁹⁸.

Түүнчлэн дээрх бүртгэн баримтжуулах үйл ажиллагааны хүрээнд⁹⁹:

- **Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шат шатанд бэхжүүлж**, өгөгдөл боловсруулах, дамжуулах, хадгалах, ашиглах үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгон, мэдээллийн систем, сүлжээ, сангийн аюулгүй байдлыг хангана.
- Соёлын өвийг эрэн сурвалжлах, олж тогтоох, бүртгэн баримтжуулах ажлыг эрчимжүүлж, эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох төлөв байдалд төрөлжсөн /эрсдэлийн, хохирлын, нөлөөллийн, төлөв байдлын гэх мэт/ үнэлгээ хийх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.
- Соёлын өвийн шилжилт хөдөлгөөн, улсын хилээр гаргах, оруулах болон өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааг бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулна.
- Илэрхийлэх байдалд язгуур хэв шинжээ харьцангуй хадгалж үлдсэн, агуулга, хэлбэрийн хувьд харилцан шүтэлцээтэй нэгдмэл утгыг илэрхийлдэг

⁹⁷ [MU-iig hugjuuleh chiglel.cdr](#), 2024 оны 10 сарын 16-нд үзэв

⁹⁸ «"Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай», Монгол Улсын Соёлын сайдын 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/212 тушаал, 1 дүгээр зүйлийн 1.3 дах хэсэг.

⁹⁹ «"Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай», Монгол Улсын Соёлын сайдын 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/212 тушаал, 2 дугаар зүйлийн 2.3.1-2.3.10 дахь хэсэг.



уламжлалт заншил, мэдлэг, арга ухааныг соёлын биет бус өвд хамруулж бүртгэнэ.

- Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн мэдлэг, ур чадвар ба өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх оролцооны шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг харгалзан эрэмбэлж, зэрэглэлд хамруулан дэмжлэг үзүүлнэ.
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг оршин буй газрынх нь хамт нэгж талбар үүсгэн кадастрын мэдээллийн санд бүртгэж, харагдах сүр бараа, аюулгүй байдалд тогтмол үнэлгээ хийнэ.
- Хилийн чанадад хадгалагдаж байгаа Монголчуудын бүтээсэн ба Монголчуудын түүх, соёлд холбогдох соёлын биет өвийг бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, өмчлөгч эзэмшигчийн хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн олон талт хэлбэрээр ашиглана.
- Соёлын өвийн шилжилт хөдөлгөөн, улсын хилээр гаргах, оруулах болон өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааг бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулна.
- Соёлын өвийг ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалт, Соёлын биет бус өвийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай өвийн жагсаалт, “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Ази Номхон далайн болон Олон улсын жагсаалтад шинээр нэмж бүртгүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэгдсэн өвийг хамгаалах хөгжүүлэх чиглэлээр тогтвортой механизм төрийн бус байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Усан доорх соёлын өвийг эрэн сурвалжлах, олж тогтоох, бүртгэн баримтжуулах чиглэлээр туршлагажсан гадаад орны эрдэмтэн судлаачид, судалгааны байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, үндэсний чадавхыг бэхжүүлэхээр тус тус тусгасан нь соёлын өвийн бүртгэн, баримтжуулах үйл ажиллагааг илүү боловсруулах болгох нэг алхам болж байна.

Дээрхээс үзвэл соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн чиглэлд соёлын өвийн бүртгэл, мэдээллийг шат шатанд бэхжүүлэх үндсэн чиглэлийг бий болгосон нь соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн хувьд нэг чухал алхам болох ч энэхүү харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлж буй байгууллагуудын хувьд нэгтгэн, уялдаа холбоог бий болгох нь зүйтэй байна.

Дөрөв.Соёлын өвийн судалгаа

Үнэлэх хэсэг	27.1.Соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ. 27.2.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа болон соёлын биет бус өвийн судалгаа нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байна.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Соёлын өвийн судалгааны талаарх зохицуулалтын хамрах хүрээ? 2. Хуулиар зохицуулсан соёлын өвийн судалгааны хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

СӨХТХ-ийн Тавдугаар бүлэгт “Соёлын өвийн судалгаа”-тай холбогдох харилцааг зохицуулсан. Тус хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Соёлын биет өвийн судалгаа, шинжилгээг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хийнэ.”, 27.2 дахь хэсэгт “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа болон соёлын биет бус



өвийн судалгаа нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байна.” гэж заасан байдаг. Эдгээр нэр томъёонуудыг нарийвчлан авч үзвэл:

- **Палеонтологи** -Эртний амьтан судлал: Улирч одсон геологийн эрин, галавын амьтан болон ургамлын ертөнц, шим мандлын хувьсал хөгжил, түүхэн өөрчлөлтийг эрэмбэлэн судалдаг ухаан; эртний амьтан, ургамлын ул мөр, олдвор, хадгалалтыг ангилан судалж, давхраалаг хурдас чулуулгийн үүсэж хуримтлагдсан цаг үеийг мөчлөн тодорхойлдог арга ухаан¹⁰⁰.
- **Археологи**- Эртний судлал: Эд өлгийн дурсгалаар нийгмийн түүхийг судалдаг ухаан, эртний судлал, хуучны судлал: **археологийн дурсгал** (газрын хөрсөн доор болон дээр үлдэн хоцорсон эртний хүний орон байрын үлдэгдэл, эдлэл хэрэглэл, хот суурин, янз бүрийн эд өлгийн зүйл), **археологийн малтлага** (эртний судлалын малтлага), **археологийн он цаг** (хуучны он цаг), **археологийн судлал** (эртний судлал)¹⁰¹
- **“Хайгуул судалгаа”** гэж шинжлэх ухааны арга зүйн дагуу соёлын биет өвийг нээж илрүүлэх, бүртгэн баримтжуулах, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, зорилгоор хийх палеонтологи, археологийн судалгааны ажлын хэлбэрийг;
- **“Малтлага судалгаа”** гэж шинжлэх ухааны арга зүйн дагуу газрын гадарга ба газрын хэвлийд хадгалагдан үлдсэн соёлын үнэт зүйлсийг илрүүлэн судлах зорилгоор хийх палеонтологи, археологийн судалгааны ажлын хэлбэрийг;
- **“Эрдэм шинжилгээний судалгаа”** гэж палеонтологи, археологийн шинжлэх ухааны тодорхой сэдвийн хүрээнд шинэ ба нэмэлт мэдлэг бий болгох зорилготой хайгуул, малтлага судалгааны ажлыг чиглэлийг;
- **“Авран хамгаалах судалгаа”** гэж соёлын биет өвийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох, газрын гадарга ба газрын хэвлийг хөндөхөөс өмнө палеонтологи, археологийн хайгуул, малтлага хийж, соёлын биет өвийг аюулгүй болгох зорилготой судалгааны ажлын чиглэлийг хэлнэ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт *“Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журмыг соёлын болон шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”* гэж заасан. Энэ хүрээнд Соёлын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/509/А/562 дугаар хамтарсан тушаалаар *“Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам”*-ыг шинэчлэн баталснаар өмнө нь үйлчилж байсан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2015 оны “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчилж, журам батлах тухай” А/141 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан *“Соёлын өвийн судалгаа хийх журам”* хүчингүй болсон байна.

Дээрх хүчин төгөлдөр үйлчилж буй *“Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам”*-аар эрдэм шинжилгээний байгууллагад тавигдах шаардлага, судалгааны ангид тавигдах шаардлага, Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрөл, судалгааны ажлыг тайлагнах зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

¹⁰⁰ Монгол хэлний их тайлбар толь

¹⁰¹ Монгол хэлний их тайлбар толь



1.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа ба Мэргэжлийн зөвлөл

Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх зөвшөөрлийг СӨХТХ-ийн 27 дугаар зүйлээр зохицуулж байгаа бөгөөд жил бүр мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагуудаас ирүүлсэн эрдэм шинжилгээний болон авран хамгаалах судалгаа хийх хүсэлтийг Соёлын яамны дэргэдэх палеонтологи болон археологийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэж, санал, дүгнэлтийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн үндэслэн олгодог.¹⁰²

Тус мэргэжлийн зөвлөл нь Соёлын сайдын 2022 оны 3 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” А/68 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт болох “*Палеонтологи, археологийн мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам*”-аар нарийвчлан зохицуулагдаж байна.

Дээрх журмын дагуу Мэргэжлийн зөвлөл нь соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээр ажиллаж байгаа бөгөөд орон тооны бус нэгж юм.

2. Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх болон соёлын биет бус өвийн судалгаа хийхэд олгох зөвшөөрөл

СӨХТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.12 дахь хэсэгт заасны дагуу Соёлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д заасан зөвшөөрөл (энгийн) болох Монгол Улсын нутаг дэвсгэрт (1).Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх, (2).Соёлын биет бус өвийн судалгаа хийх зөвшөөрлийг олгодог. Нөгөө талаас зөвшөөрөл авах хүсэлтийг эрдэм шинжилгээний байгууллага Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж байна.

Зөвшөөрөл авах хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- судалгаа хийх үндэслэл, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон албан бичиг;
- судалгааны ажлын баталгаажсан удирдамж;
- дотоод, гадаадын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх бол хамтын ажиллагааны гэрээ;
- судалгааны ажлыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнийг томилсон тушаалын хуулбар болно.

Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага нь:

- Палеонтологи, археологийн (1).эрдэм шинжилгээний чиглэлийн хайгуул малтлага судалгааны ажлын зөвшөөрлийг **судалгааны анги тус бүрд**, (2).авран хамгаалах чиглэлийн хайгуул малтлага судалгаа хийх зөвшөөрлийг **эрдэм шинжилгээний байгууллагад** олгоно гэж “*Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам*”-аар нарийвчлан заасан.
- Эрдэм шинжилгээний болон авран хамгаалах хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад олгоно.¹⁰³ Тус мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан байгууллага байх бөгөөд мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй, олдвор, судалгааны дээж хадгалах, зориулалтын

¹⁰² Соёлын яам., Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх бодлого зорилт (УБ., 2024) 53

¹⁰³ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэг



байр танхимтай, хэмжилт, материал бүтэц болон бусад чиглэлээр судалгаа боловсруулалт хийх техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий лабораторитой байх¹⁰⁴ шаардлага тавигдсан байна. Үүнээс гадна тус байгууллага нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг дотоодын болон гадаадын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндэс болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй Монгол улсын нутаг дэвсгэрт холбогдох судалгаа хийхээр гэрээ байгуулах, судалгаа хийхийг хориглосон байна.

Монгол улсад судалгаа хийх зөвшөөрөл авсан эрдэм шинжилгээний байгууллагуудад дараах байгууллагууд хамрагдаж байна. Үүнд:

- 1.Монголын үндэсний музей;
- 2.МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль;
- 3.МУИС-ийн Археологийн судалгааны төв;
- 4.МУИС-ийн Шинжлэх ухаан, технологийн Улаанбаатар парк;
- 5.МУИС-ийн ШУ-ны сургууль;
- 6.Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн;
- 7.Улаанбаатарын Их сургууль;
- 8.Ховд их сургууль;
- 9.Чингис хаан музей;
- 10.ШУА-ийн Археологийн хүрээлэн;
- 11.ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн;
- 12.ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн;
- 13.ШУА-ийн Палеонтологи, геологийн хүрээлэн;
- 14.ШУА-ийн Палеонтологийн хүрээлэн;
- 15.ШУТИС-ийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль;
- 16.ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль зэрэг болно.

Эдгээр зөвшөөрөл бүхий байгууллагууд нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр палеонтологи болон археологийн чиглэлээр жил бүр гадаадын орны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран судалгааны ажлыг хэрэгжүүлж байна.

Гэвч хуулийн хэрэгжилтийг холбогдох мэргэжилтнээс тодруулахад:

№	Ярилцлага
1.	*Одоогийн байдлаар манайд яг энэ хуулиар зохицуулалт олддоггүй. Гэхдээ Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад судалгаа хийх зөвшөөрөл олгоно гэхчхэн байгаа. Жишээлбэл Дамдинсүрэн гуайн шавь Отгонбаатар Шинжлэх ухааны академид эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж байгаад гарсан. Магистр цол байхгүй, магистр ч биш доктор ч биш. Гэхдээ энэ хүний өөрийнх нь мэдлэг бол юун

¹⁰⁴ Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам 3.1, 3.2 дахь заалт



	магистр, доктор. Тэгэхээр энэ хүнээр жишээ нь судалгаа хийлгэхгүй гэхээр сонин болчихоод байдаг.
2.	*Хүрээлэнгүүд бүгд л судалгааны байгууллага гэж л яваад байгаа юм. Их, дээд сургуулиуд бас. Тэгэхээр тэр байгууллагадаа хамрагдаад тэр байгууллагынхаа өмнөөс судалгаа гаргах юм уу?. Жишээлбэл АНУ-ын Берклийн их сургуульд багшилж байгаа Уранчимэг доктор байгаа. Одоо урлаг судлалаар бол дэлхийн хэмжээнд маш том арга хэмжээ бүр Монголын нэртэйгээр өгүүлэл зэргийг нийтлүүлж байгаа хүн. Монголд ирээд Музейгээс юм судалмаар байна гээд өргөдөл өгөхөөр та мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага биш гэдэг хариу өгдөг. Монголд ирээд судалгааны байгууллагатай гэрээ байгуулаад тэр байгууллагынхаа өмнөөс хүсэлт өгнө гэхээр олон дамжлагатай болчихож байгаа юм. Тэгэхээр энэ дээр мэдрэмж л хэрэгтэй юм байна лээ. Аливаа амьдралын олон юмс үзэгдэл ийм олон юмыг хэтэрхий хумиад, бид нар яах ёстой вэ гэвэл сайн хянах л ёстой. Тэр хяналтыг л эрх зүйгээр бид нар гаргаж ирнэ шүү дээ хуулийн үндсэн зарчим чинь тэр. Тэгэхгүй бол нэг ёсондоо хүний юмыг зохицуулалт хийж байна гээд хумиад боломжийг нь хаачхаж байгаа юм.
3.	*Судалгаа бол үнэхээр хангалттай биш. Эрдэм шинжилгээний ажилтнууд бол Шинжлэх ухааны тухай хуулиар магадгүй явах ёстой байх. Эрдэм шинжилгээний ажилтнууд нь хийж байгаа ажлаа бол ойлгохгүй байгаа. Эрдэм шинжилгээний ажилтнууд яг цэвэр судалгааны гэхээр магадгүй Шинжлэх ухааны академи юм уу эсвэл судалгааны байгууллагуудаас мэргэжил арга зүйн Шинжлэх ухааны тухай хуулиа дагаад шаардлагаа дагаж ажиллахын хувьд бол ажилладаг. Гэхдээ эрдэм шинжилгээний ажилтан ажиллаад ч Музейд бол хангалттай биш. Яагаад гэвэл Музейд судалгаа хийх юм чинь юу вэ гэхээр тухайн соёлын өвийн үнэ цэнийг гаргаж ирж байгаа гол зүйл нь энэ юм. Нэг ёсондоо нэг шинжилгээний ажил юм..

Дээрх ярилцлагын тэмдэглэлээс харвал бодит практик дээр судалгаа хийх байгууллагын зөвшөөрлийн асуудал хууль болон холбогдох журамд заасны дагуу хэрэгжиж байгаа боловч бодит байдалд нийцсэн бус, зарим талаар мэргэжилтнүүдийн нөөц болон чадварын асуудал хөндөгдөж байна. Судалгааны ажлыг чанаржуулж, сайжруулах болон судалгааны өргөн хүрээг хамрахын тулд зөвшөөрлийг зөвхөн Мэргэжлийн байгууллагад олгох бус, мөн эрдмийн зэрэг, цолоор ажилтанд тавигдах шаардлагын хүрээг шууд хумихаас илүү практик туршлага зэргийг үнэлж судалгаа хийх зөвшөөрлийг хэнд олгох талаар дахин зохицуулалт хийх шаардлагатай нь харагдаж байна.

3.Соёлын биет бус өвийн судалгаа

СӨХТХ-ийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх хэсэгт заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/151 тоот тушаалаар “Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх” журам шинэчлэн батлагдсан. Тус журмын дагуу Монгол Улсад соёлын биет бус өвийн судалгааг Шинжлэх ухааны академийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв, ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл, иргэншлийн олон улсын хүрээлэн, СУИС-ийн Соёл, урлаг судлалын хүрээлэн, Монголын үндэсний музей зэрэг байгууллагууд хийж байна.¹⁰⁵

Соёлын биет бус өвийн чиглэлээр судалгааны хүрээлэнгүүд тусдаа судалгаа хийж, судалгааны архив үүсгэдэгтэй холбоотойгоор судалгааны нэгдсэн сан одоо хүртэл бий болоогүй байна. ШУА-ийн хүрээлэнгүүд соёлын биет бус өвийн чиглэлээр судалгаа

¹⁰⁵ Соёлын яам., Соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх бодлого зорилт (УБ.,2024) 54



хийдэг боловч тухайн судалгааны хүрээнд цуглагдсан баримт, мэдээ судалгааны материал олон нийтэд нээлттэй байдаггүй.

Судалгааны үр дүнгийн нээлттэй бус байдал нь хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаа явуулах буюу судалгаанд суурилсан хадгалалт, хамгаалалтын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж байна. Соёлын биет бус өвийн талаарх судлаачдын нэгдсэн ойлголт сул байгаатай холбоотойгоор өвийн нэршил, судалгаа олон янз байсаар байна. Авран хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй, судалгаа дутмаг байна. Бүс нутгийн, хил дамнасан, ижил төстэй өвүүдэд харьцуулсан судалгаа дутмаг байгаа нь тухайн өвийн онцлог, ялгааг эрдэм шинжилгээ, судалгааны дүгнэлттэйгээр олон нийтэд тайлбарлан таниулахад хүндрэл учруулж байна.

Мөн Монгол туургатан, нүүдэлчдийн бүс нутаг, хил дамнасан, ижил төстэй соёлын өвийг хамтран судалсан олон улсын болон улс хоорондын судалгааны ажил дутагдалтай байна. Соёлын биет бус өвийн чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгох, судалгааны тэтгэлэг олгох үйл ажиллагаа дутагдалтай. Түүнчлэн соёлын биет бус өвийг хамгаалахад чиглэсэн суурь болон харьцуулсан судалгаа хийх, тэдгээрийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, үнэлэх ажил дутмаг байсаар байна.

Холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс дурдвал:

№	Ярилцлага
1.	*Одоо бол бүх судалгааг базах сонирхолтой болчихсон. <i>Жишээлбэл</i> зөвшөөрөлгүйгээр судалгаа хийх ямар ч боломж байхгүй. Угсаатны зүйн судалгаа хийе гэхээр Соёлын яамнаас заавал зөвшөөрөл ав гэдэг. Малчдын мал маллах арга ухааныг судлахын тулд Соёлын яамнаас Хөвсгөл аймгийн Бүрэн хаан суманд очиж мал маллах аргад судалгаа хийе гээд зөвшөөрөл авна гэхээр бас жоохон тийм л байгаад байгаа юм. Малаа яаж маллахаа Марксизмаар заалгахгүй гээд Мягмарсүрэнгийн шүлэг байдаг. Тэр нь шиг л юм болоод байгаа юм.
2.	*Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/151 тоот тушаалаар батлагдсан “Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам” хэрэгжиж байгаа боловч бодит байдалд нийцээгүй, хөрсөндөө буугаагүй, ашиглахад уялдаа холбоо байхгүй. Тус журмыг шинээр батлах гээд ажил явж байсан боловч бид нар баталж чадахгүй байгаа. Тиймээс уг журмыг бол одоохондоо мөрдөөд явж байгаа.
3.	*Манайд судалгааны тухай ойлголт нь шууд ШУА хаана харьяалагдаж байна тэр яамны асуудал болоод явчихдаг. Тэгэнгүүт төсвийн асуудал дээр судалгаа гээд Соёлын яамаар орохоор дэмжигддэггүй. Яагаад гэвэл судалгаа хийх нь ШУА-ийн асуудал. ШУА одоо Эдийн засаг хөгжлийн яамны харьяанд байгаа учраас Эдийн засаг, хөгжлийн яамнаас багц зардал мөнгө нь гарах хэрэгтэй. Шинжлэх ухаан, технологийн сангийн судалгааны төсөл зөндөө зарлаж байна тэр судалгааны төсөлд ороод ав гэдэг. Гэтэл Соёлын өвийн судалгаа бол өөрөө дангаараа шал өөр зүйл. Баримтжуулалт, дата анализ, материаллаг шинжилгээ дээр үндэслэж хийдэг судалгаа байдаг. Тэгэхээр энэ судалгаа бол тусдаа нэлээн том салбар. Монгол улсад бол ШУА, Музей, Соёлын өвийн үндэсний төвийг судалгааны байгууллага гээд хууль дээр статусыг нь тодорхойлчихмоор байгаа юм. Соёлын өвийн Үндэсний төв дээр материалын шинжилгээ, дата анализ үүсгэж байгаа асуудал чинь бас нэг төрлийн судалгаа. Музей бол олон шинжлэх ухааны уулзвар дээр байдаг гэдэг шиг физик, химийн шинжлэх ухаануудтай ч аягүй их холбогдоно.
4.	*Судалгаагаар холбогдоод нэр томъёоны асуудал гарч ирнэ, жишээлбэл хуулбарын асуудал. Хуулбар хийнэ гэхээр Музей, бусад байгууллагуудад орлогын том үүсвэр болж байдаг. 1:1 гэж байгаа шүү дээ. Энэ зүйлийг цэг болгоныг нь адилхан хийнэ гэсэн үг. Үүнийг хийхийн



	тулд урьдчилж маш сайн судлаад яг адилхан хийх ёстой. Энэ хуулбар нь маш үнэтэй. Гадаадын орнууд хуулбарын бүртгэлд заавал дугаар өгдөг. Монголд хэд хэдэн том хүмүүсийн үзэсгэлэн гарч байсан. Рерихын үзэсгэлэн гарч байсан. Салвидор Далигийн үзэсгэлэн гарч байлуу. Пабло Пикассогийн үзэсгэлэн гарч байсан. Тэгсэн Пикассогийн зургууд дугаартай байгаа юм. 134, 200 хэд гэсэн дугаартай. Хэдэн удаа хуулбарлаж байна тэрийгээ дугаарлаад явдаг. Тэр нь өөрөө хуулбараас хуулбар хийхийг хориглоно гэдэг. Гэтэл манайд хуулбар гэж юу байх талаарх тайлбар байхгүй.
5.	*Судалгааны асуудал бол дутагдалтай. Олон байгууллагууд хийдэг. Судалгаа нь өөрөө архив болж үлдэж байх ёстой жишээлбэл, дараа нь сэргээн засварласан уу гэх мэтээр.

Дээрхээс харвал Соёлын биет бус өвийн судалгаа шинжилгээний асуудал хууль, журмынхаа дагуу хэрэгжээд явж байгаа боловч мөн л бодит байдалд нийцээгүй, нэгдсэн сан байхгүй, судалгааг нээлттэй үзэх боломжгүй зэрэг маш олон асуудлууд байгаа нь мөн л бодит байдалд нийцсэн, уялдаа холбоог хангасан журмыг нарийвчлан тодорхой зохицуулах хуулийн шаардлага байгааг харуулж байна.

4.Соёлын өвийн судалгаатай холбоотой бусад орны туршлага: Бүгд найрамдах Солонгос Улс

БНСУ-ын Соёлын өвийн газрын харьяа Соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэн нь соёлын өвийг хадгалах, удирдах, судлах гол байгууллага юм. Энэхүү судалгааны байгууллага нь соёлын үнэт зүйлсийн түүх, шинжлэх ухааны үнэ цэнийг олон талт арга барилаар судалж, хамгаалах, нөхөн сэргээх арга техникийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулдаг. Судалгааг дараах 6 үндсэн чиглэлээр явуулдаг.

1.Соёлын өвийн хадгалалт, сэргээн засварлалтын судалгаа

Эртний барилга байгууламж, уран зураг, гар урлал, чулуун байгууламж зэрэг янз бүрийн төрлийн соёлын үнэт зүйлсийг хадгалах, сэргээх технологийг хөгжүүлэх;

Шинжлэх ухааны шинжилгээгээр эвдрэл гэмтлийн шалтгааныг олж тогтоох, ямар аргаар нөхөн сэргээж засварлахыг санал болгодог. Жишээ нь: Буддын шашны анхны уран зураг, модон барилгуудыг сэргээх төсөл хэрэгжүүлэх.

2.Археологийн судалгаа, малтлага

Түүхийн өмнөх дурсгалт газрууд болон эртний олдворуудад малтлага хийх;

Малтлагаас гарсан олдворуудыг тухайн цаг үеэр нь шинжилж, Солонгосын соёлын түүхийн судалгааны үндэслэлийг тодорхойлох. Жишээ нь: Шилла, Баскжэ нарын эртний булшны малтлага, судалгаа.

3.Байгалийн өв, соёлын биет бус өвийн судалгаа

Байгалийн өвийг (геологи, амьтан, ургамал гэх мэт) хамгаалах стратеги боловсруулах;

Биет бус соёлын өвийг дамжуулах, баримтжуулах (бүжиг, хөгжим, уламжлалт ур чадвар); Жишээ нь: Пансори, багт бүжиг зэрэг соёлын биет бус өвийг хамгаалах судалгаа.



4.Шинжлэх ухааны шинжилгээ, байгаль орчны хяналт

Бүрэлдэхүүн хэсгүүдийн дүн шинжилгээ хийх, хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж ашиглан дурсгалын эвдрэлийн байдлыг тодорхойлох;

Эд өлгийн зүйл, дурсгалыг хадгалах орчныг хянах(температур, чийгшил), хянах технологийн судалгаа. Жишээ нь: Рентген болон хэт улаан туяаны шинжилгээгээр олдворын дотоод бүтцийг судлах.

5.Олон улсын хамтын ажиллагаа, бодлого боловсруулах

ЮНЕСКО зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран Дэлхийн өвийн бүртгэл, менежментийг хийх;

Соёлын үнэт зүйлийг хамгаалах үндэсний бодлогын судалгаа, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох; Жишээ нь: Дэлхийн өвд бүртгүүлэхээр нэр дэвшүүлсэн газруудын судалгаа, менежментийн төлөвлөгөөг гаргах.

6.Боловсрол, олон нийтийн оролцоо

Соёлын өвийн мэргэжилтнүүдийг дэмжих боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх; Олон нийтэд зориулсан үзэсгэлэн, эрдэм шинжилгээний семинар, туршлагын хөтөлбөр зохион байгуулах; Жишээ нь: Хүүхдэд зориулсан соёлын өвийг сэргээн засварлах туршлага хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэн нь уламжлалт соёл, байгалийн өвийг системтэй судлах, хамгаалахад анхаарч ажилладаг. Түүнчлэн судалгааны үр дүнг олон нийтэд түгээж, Солонгосын соёлын өвийг хойч үедээ аюулгүйгээр өвлүүлэх зорилготой.

Энэ мэтчилэн Соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэнгийн үйл ажиллагаа дотоод болон олон улсын хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийн дагуу системтэй явагддаг. Эдгээр хууль нь Солонгосын түүх, соёл, экологийг хамгаалах, хөгжүүлэх үндэс суурь болж, хууль эрх зүйн үндэс нь судалгаа, байгаль хамгаалах үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангадаг байна. Мөн холбогдох харилцаануудыг нарийвчлан журмаар зохицуулдаг ба дээрх тогтолцооноос харахад салбар хоорондын уялдаа холбоог нарийн гаргасан байна.

Тав.Соёлын өвийн үнэлгээ

Үнэлэх хэсэг	9 дүгээр зүйл. Соёлын биет өвийн үнэлгээ 9.1.Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

Соёлын биет өвийг зөв тогтоож үнэлж чадвал хадгалалт, хамгаалалт, даатгал, судалгаа шинжилгээ, бүтээгдэхүүн болгох үйл явц олон улсын стандартад нийцэх тул



түүнийг бодитоор үнэлж байх шаардлага орчин үед нэн чухлаар тавигдаж байна.¹⁰⁶ Соёлын биет өвийг үнэлнэ гэдэг түүнийг “өмч” гэж ойлгох шаардлага гардаг ба энэ нь улсын болон ард түмний хамгийн чухал үндэстний үнэт зүйлийг тодорхойлогчийн хэмжээнд авч үзэх үнэлгээний өндөр шалгуур болдог.

Түүх, соёлын дурсгалт зүйлийн үнэ цэнийг тогтооход түүнийг эзэмшигч ард түмэн болон хувь хүн, судлаачдын хүсэл зорилго, үнэт зүйлсийн баримжааллаас илүү шинжлэх ухааны судалгаануудад тулгуурласан судлаач, хараат бус үнэлгээ тогтоодог мэргэжлийн хүмүүс хамгийн их үүрэг гүйцэтгэдэг. Мөн тухайн түүх, соёлын дурсгалт зүйлсийг хэрхэн судалсан, ямар хэмжээгээр эдийн засгийн эргэлтэд оруулсан болон соёл боловсрол, эдийн засаг, нийгмийн бүтээгдэхүүн болж чадсан зэрэг нь чухал нөлөөтэй байдаг.¹⁰⁷

Түүнчлэн түүх, соёлын дурсгалт зүйлийн бодит үнэлгээ зөв хийгдэж байгаа эсэхийг шалгах, хүрэх үр дүнг нягтлах, түүхийн дурсгалт зүйл хэр өргөн цар хүрээтэй бүтээгдэхүүн болсон, түүний хүртээмжийг тодорхойлох зорилгоор хийгддэг үнэлгээг ЮНЕСКО болон мэргэжлийн байгууллагууд хийдэг нь энэ төрлийн үнэлгээ хамгийн бодитой, хамгийн сайн судлагдсан байх бөгөөд төгсгөлийн бодит үнэлгээ байдаг учраас мэргэжлийн, хараат бус үнэлгээчид хийдэг байна.

Энэ үндсэн дээр үнэлгээ гэдэг бол эдийн засгийн хэрэглээний нэг ойлголт боловч соёлын биет өвийг хэрхэн үнэлэх тухай өөрийн гэсэн зарчим болон тухайн үндэстний түүх, соёлын дурсгалдаа ямар ач холбогдол өгч байгаа тухай ойлголт, түүнийг баримтлах зарчим, үнэлгээний арга барилын үр дүнг тогтоох, ямар аргаар хэрэглээ болгох зэрэг асуудлыг хөндөх учиртай.

Манай Улсын хувьд соёлын өвийн үнэлгээний талаар хууль тогтоомждоо дараах байдлаар тусгаж өгсөн /Хүснэгт №3-с харах/.

Хүснэгт №3

2014 оны СӨХтХ шинэчилсэн найруулга	2021 оны СӨХтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
9.1.Соёлын биет өвийн үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	9.1.Нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. <i>/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</i>

СӨХтХ-ийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалд “...соёлын өвийг үнэлэхдээ хөрөнгийн үнэлгээний тодорхой мэдлэггүй, соёлын өвийн ойлголт дутмаг этгээдүүд өртгийн болон жишиг үнийн аргаар үнэлж байгаа нь соёлын үнэ цэнэ, ач холбогдлыг

¹⁰⁶ Б.Баясах, «Соёлын өвийн хөдлөх дурсгалын үнэлгээний асуудал Үл хөдлөх хөрөнгө, газрын эдийн засгийн магистрын зэрэг горилсон судалгааны ажил: E310300» (УБ, МУИС-ийн Бизнесийн сургууль, 2014), 17, <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-ISBDdetailbook.pl?biblionumber=137773>.

¹⁰⁷ «Соёлын өвийн хөдлөх дурсгалын үнэлгээний асуудал Үл хөдлөх хөрөнгө, газрын эдийн засгийн магистрын зэрэг горилсон судалгааны ажил: E310300».



бүрэн тусгаж чадахгүй байна”¹⁰⁸ гэж хуулийн төсөл боловсруулах практик үндэслэл, шаардлагад тусгаж байсан.

Гэвч хууль тогтоогч анх соёлын биет өвд үнэлгээ хийх журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар заасан боловч СӨХТХ-д 2021 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн **нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ тогтоох** журмыг санхүү, төсвийн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална гэж нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээний асуудлыг зохицуулахаар тусгасан ч одоог хүртэл энэхүү журам батлагдан гараагүй байна.

Түүнчлэн 2014 онд СӨХТХ-ийн шинэчилсэн найруулга батлагдаад 10 жил, СӨХТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулаад 3 жил гаруй болж байх энэ хугацаанд нийтийн өмчийн соёлын биет өвд үнэлгээ хийх харилцааг зохицуулаагүй нь нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээний асуудлын хэрэгжилт огт хангагдаагүй гэж үзэж болохоор байна.

Дээрх асуудал хэрхэн хойшлогдсон шалтгааныг судалгааны багийн зүгээс тодруулахад “СӨХТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг нь 2022 онд батлагдсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7-д “түүхийн дурсгалт зүйл, үнэт эдлэл, эрдэнэс, ховор эд зүйлийн үнэлгээний журам, аргачлалыг Монголбанк болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална” гэсэн эрх зүйн зохицуулалттай. Нэр томьёоны ойлголт зөрүүтэй байгаа тул Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газар, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институтын төлөөлөлтэй 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдөр уулзалт хийж, хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулахаар тохиролцсон. Хууль хооронд нэр томьёоны зөрүү байгаа тул боловсруулах ажил удааширч байна” гэж тусгагдсан байна¹⁰⁹.

№	Ярилцлага
1.	*Манай газрын хувьд хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийдэг ба засгийн газрын шийдвэр, тогтоол, хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг сар бүр, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хагас жил тутам батлагдсан төлөвлөгөөний дагуу хянадаг. Голдуу дүрэм, журам боловсруулах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тушаалыг хянадаг ба СӨХТХ-д заасан журмуудаас батлагдаагүй журмууд гарч байгаа. Энэ оны хагас жилд бид СӨХТХ-ийн хэд хэдэн зүйл заалтын хэрэгжилтэд хяналт хийсэн ба энэхүү хяналтын тайланг та бүхэнд хүргүүлэе.

Харин өнөөдрийн байдлаар соёлын биет өвд үнэлгээ тогтоох асуудлыг Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/140 тушаалаар батлагдсан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”¹¹⁰-аар түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн дансны үнийг шинэчлэн тогтоож, санхүүгийн тайланд тусгахаар зохицуулсан нь соёлын биет өвд үнэлгээ тогтоох харилцааг зохицуулж байна.

Гэвч энэхүү журмын хувьд Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн дансны үнэ шинэчлэн тогтоох комиссыг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилж, комисст нягтлан бодогч, сан хөмрөгч, өмч хамгаалах байнгын зөвлөл, техникийн

¹⁰⁸ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийн үзэл баримтлал. УИХ-ын Тамгын газрын архив. (2014) №БЖ-44, Боть-1, 12

¹⁰⁹ Энэхүү тайланг соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын яамны ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Оюунтуяатай 2024 оны 10 сарын 15-ны өдөр ярилцлага хийсэн ярилцлага.

¹¹⁰ «Журам батлах тухай (Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам)», Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/140 тушаал



комиссын төлөөллийг оролцуулахаар¹¹¹ зохицуулсан нь соёлын биет өвийг үнэн зөв, бодитой үнэлж чадаж байгаа эсэхэд эргэлзээ үүсгэж байна.

Учир нь үнэлгээний асуудал гэдэг бол тухайн зүйлийн зэрэглэл, ховор, түгээмэл байдал, материал, бүтээсэн он цаг, ур хийц, арга ажиллагаа, жин, хэмжээ, иж бүрдэл, гэмтэл, түүх, соёл урлаг шинжлэх ухааны ач холбогдол зэргийг харгалзан үздэг маш нарийн, мэргэжлийн ур чадвар шаардагдах зүйл байдаг ч комисс нь шинэчилсэн дансны үнэ тогтоохдоо журмын хавсралтад заасан дансны үнийг өсгөх, бууруулах зарчим баримталж байгаа болно.

Мөн дэр дурдсан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ”-ийг анх тогтоохдоо мэргэжлийн зөвлөл тухайн дансны үнийг тодорхойлохоор заасан¹¹² ч СӨХТХ-ийн 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн шинэчилсэн найруулгаар энэхүү зохицуулалтыг хүчингүй болгосон нь өнөөдрийн хувьд соёлын өвийн үнэлгээг ямар субъект тогтоож буй нь тодорхойгүй байна.

Түүнчлэн соёлын өвийн эсрэг гэмт хэргийн тухайд тухайн өвийн үнэлгээг шүүх хэрхэн тогтоодог талаар шүүхийн шийдвэрийг судлан авч үзэхэд¹¹³ Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/140 тушаалаар батлагдсан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”¹¹⁴-ыг баримталж шийдсэн нь соёлын өвийн үнэлгээнд энэхүү журам өнөөдрийг хүртэл үйлчилж буйг илэрхийлж байна.

Дээрх асуудлын хүрээнд судалгааны багийн зүгээс Музей болон соёлын өвийн эрх бүхий байгууллагуудын төлөөллүүдтэй уулзахад соёлын өвийг хэрхэн үнэлэх зарчим тодорхойгүйгээс олон асуудал гардгийг ярилцлагадаа дурдсан болно.

№	Ярилцлага
1.	*Соёлын өвийн үнэлгээг хэрхэн тогтоох журам манайд байхгүй.
2.	*Соёлын өвийн үнэлгээний асуудал одоог хүртэл яригдаж байна. Дансанд бүртгэлтэй үнэлгээг өвийн үнэлгээ гэж үзэх үү? түний нөхөн төлбөр, даатгалын асуудал гээд үнэлгээнээс хамаарч олон зүйл гарч байгаа.
3.	*Үнэлгээний журам байхгүй. Бид бүхэн дансны үнэ тогтоох журмаар явдаг. Энэ нь бодит байдал дээр маш багаар үнэлэгддэг тул цаашлаад тухайн хөрөнгийн даатгалын асуудал яригддаг. Түүнчлэн хосгүй үнэт зүйл гэдгийг хэрхэн үнэлэх нь тодорхойгүй. Манайх хосгүй үнэт зүйлээ дансны үнээрээ үнэлж явдаг. Тэгэхээр энэхүү хосгүй үнэт зүйлийг гадагшаа үзэсгэлэнд гаргахад дансны үнэ дагах уу? хэрхэн үнэлэх үү? гэдэг асуудал яригддаг. Үүнийг дагаад даатгал яригддаг. Хосгүй үнэт зүйлийг хэрхэн үнэлэхийг маш зөв тогтоох нь зүйтэй байна.

¹¹¹ Дээрх журмын 2 дагаар зүйлд заасны дагуу

¹¹² Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг. 2021 оны 7 сарын 2-нд хүчингүй болсон.

¹¹³ [Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан](#), Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, Дугаар 2022/ШЦТ/845

¹¹⁴ «Журам батлах тухай (Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам)», Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/140 тушаал



Соёлын биет өвийн үнэлгээний ажлын онолын үндэслэл нь үнэлгээний зарчим юм. Үнэлгээний зарчим нь олон улсын хэмжээнд өмч хөрөнгөтэй харьцаж байсан эдийн засгийн түүхэн туршлагад үндэслэн гарч ирсэн байдаг.¹¹⁵

Соёлын өвийн үнэлгээний аргачлалын талаар гадаадын зарим орны туршлагыг судлан авч үзвэл Австрали, Швейцар зэрэг улсуудад тухайн соёлын дурсгалын юун чухам үнэ цэнтэй, хэнд чухал ач холбогдолтой гэдгийг тодорхойлж, түүний үнэ цэнийг шинжлэх ухааны, гоо зүй, түүхэн, нийгмийн болон оюун санааны гэсэн таван шалгуураар тогтоодог байна¹¹⁶.

Харин Австралид соёлын өвийн үнэлгээг тогтоохдоо Австралийн нягтлан бодох бүртгэлийн стандартын зөвлөлөөс тогтоосон хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолох стандартаар тогтоодог¹¹⁷ бол Япон улсад Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар соёлын өвийн үнэ цэнийг тодорхойлохдоо мэргэжилтнүүд нийгэм соёлын үнэ цэнэд түүхэн, соёлын бэлгэдлийн, нийгмийн шашны, гоо зүйн үнэ цэнээр тогтоодог бол эдийн засгийн үнэ цэнэ нь дэр дурдсан зүйлс дээр эдийн засгийн шинжилгээний дүнд хэмжигддэг байна¹¹⁸.

Дээрхээс үзвэл бусад улс орны хувьд соёлын өвийн үнэлгээг өвийн үнэ цэн, эдийн засгийн ач холбогдол зэргээр тодорхойлж тогтсон нэг стандарт аргачлалыг барьж хэвшжээ.

Харин манай улсын хувьд тогтсон стандарт аргачлал болон журам өнөөдрийг хүртэл батлагдаагүй нь цаашид энэ төрлийн харилцаа зохицуулалтгүй орхигдох нөхцөлийг бүрдүүлж байна.

Харин судлаач Б.Баясах Соёлын өвийн хөдлөх дурсгалын үнэлгээний асуудал сэдэвт судалгааны ажилдаа Соёлын өвийн үнэлгээний аргачлалын талаар нэлээд дэлгэрэнгүй судалсан байна. Тухайлбал,

Хөрөнгийн үнэлгээний зарчмууд:

- 1.Худалдан авагч, хөрөнгө оруулагчдын таашаалд үндэслэх зарчим;
- 2.Хөрөнгийн ашиглалттай холбоотой зарчим;
- 3.Зах зээлийн орчинтой холбоо бүхий зарчим;
- 4.Үр ашиг бүхий ашиглалтын зарчмуудаар тус тус тодорхойлогддог бол

Хөрөнгийн үнэлгээний арга:

- 1.Зах зээлийн жишиг үнийн арга;
- 2.Орлого капиталжуулалтын арга;
- 3.Өртгийн аргаар тодорхойлогдож байна.

¹¹⁵ «Соёлын өвийн хөдлөх дурсгалын үнэлгээний асуудал Үл хөдлөх хөрөнгө, газрын эдийн засгийн магистрын зэрэг горилсон судалгааны ажил: Е310300», 16.

¹¹⁶ Р.Хатанбаатар, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, “Соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчин, үнэлгээний аргачлалын талаарх гадаадын зарим орны туршлага (Харьцуулсан судалгаа)”, (УБ, 2019), 142

¹¹⁷ Мөн тэнд

¹¹⁸ Р.Хатанбаатар, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, “Соёлын өвийг хамгаалах эрх зүйн орчин, үнэлгээний аргачлалын талаарх гадаадын зарим орны туршлага (Харьцуулсан судалгаа)”, (УБ, 2019), 143



Түүнчлэн түүхийн дурсгалт өмч гэдэг нь түүхэн үйл явдал, цаг хугацаа, үндэсний өв сантай холбоотой, архитектурын хэв маяг болон бусад чанараараа түүх соёлын асар их ач холбогдолтой гэдэг нь нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл засгийн газраас албан ёсоор тогтоосон үл хөдлөх өмч болно. Түүхийн дурсгалт өмч дараах үндсэн шинжийг агуулна.¹¹⁹

- 1.Түүх, соёл архитектурын ач холбогдолтой байх;
- 2.Хуулиар хамгаалагдсан байх;
- 3.Ашиглалт, өөрчлөлт, устгалд нь хязгаарлалт тавигдсан байх;
- 4.Эрх зүйн зарим актаар нийт ард түмэнд хүртээмжтэй, нээлттэй байх зэрэг болно.

Түүхийн дурсгалт өмчийг үнэлэхдээ доорх асуудлуудыг түүхэн өмчийн мөн чанар болон үнэлгээний зорилгоос шалтгаалан авч үзэх шаардлагатай хэмээн үзсэн нь түүхийн дурсгал өмчийг үнэлэхдээ онолын болоод тухайн өмчийн шинж чанарыг маш нарийн судлахыг илэрхийлж байна.

1.Сэргээн босгох болон засварлалтын зардал ихээхэн хэмжээгээр гарч болох бөгөөд эргээд тухайн өмчийн үнэ цэнэд нөлөөлөх;

2.Түүхийн өмчийг хамгаалах хуулийн хүрээний арга хэмжээнүүд нь түүний ашиглалт, эрчимтэй ашиглалт, өөрчлөлт тавих.

Дээрхээс үзвэл нийтийн өмчийн соёлын биет өвийн үнэлгээ, түүнийг тогтоох асуудал маш нарийн бөгөөд олон аргачлалуудын хүрээнд, мэргэжлийн баг хамт олны санал санаачилгыг үндэслэн үнэлгээг тогтоох нь зүйтэй болохыг илэрхийлж байна.

Гэвч өнөөдрийн хувьд манай улсын хувьд нийтийн өмчийн соёлын биет өвийг үнэлэх журам батлагдаагүй, тухайн өмчийг үнэлэх мэргэжлийн зөвлөлийг хэрхэн ажиллуулах нь тодорхойгүй байгаа нь энэ төрлийн харилцаа цаашид зохицуулалтгүй үлдэх, соёлын өвийн үнэлгээ бодит хийгдэх боломжгүй болох эрсдэлийг бий болгож байна.

Зургаа.Соёлын өвийг эзэмших, ашиглах, өмчлөх

Үнэлэх хэсэг	31.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага өмчлөгчийн тогтоосон нөхцөлөөр тус тус эзэмшинэ. 35.1.Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 36.1.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. 36.2.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1.Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

¹¹⁹ Б.Баясах, «Соёлын өвийн хөдлөх дурсгалын үнэлгээний асуудал Үл хөдлөх хөрөнгө, газрын эдийн засгийн магистрын зэрэг горилсон судалгааны ажил: E310300» (УБ, МУИС-ийн Бизнесийн сургууль, 2014), 20, <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-ISBDdetailbook.pl?biblionumber=137773>.



Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 8-д соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхийг хамгаалсан байдаг.¹²⁰ Энэ хүрээнд Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Патентын тухай, Зохиогчийн эрхийн тухай, Музейн хууль гэх зэрэг олон хуулиар соёлын харилцааг зохицуулж байна. Үүнээс гадна бусад хуулиар мөн соёлын өв хамгаалагдаж байгаагаас соёлын өвийг өмчлөх, эзэмшихтэй холбоотой харилцааг Иргэний хуулиар зохицуулж байна.

СӨХТХ-д соёлын өвийг шинжлэх ухаан, урлаг, эрх зүйн үүднээс тодорхойлж, түүх соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олох, бүртгэх, зэрэглэл тогтоох, археологийн малтлага хийх, судлах, сурталчлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, өмчлөх, эзэмших, ашиглах, хилээр нэвтрүүлэхтэй холбоотой харилцааг шинээр зохицуулсан. Мөн төрийн болон хувь хүн, хуулийн этгээдийн өмчлөх, эзэмших соёлын өвийг ялгаж, төрийн өмчийн соёлын өвийг эзэмшиж байгаа төрийн байгууллага болон хувь хүн, хуулийн этгээд эзэмшилдээ байгаа соёлын өвийг захиран зарцуулах хэм хэмжээг шинээр тогтоосон байна. Тус хуулийн 6 дугаар бүлэгт соёлын өвийг бүртгэх, эзэмших, ашиглах, өмчлөх талаар зохицуулсан байна.

1. Соёлын өвийг эзэмших, өмчлөх

“Иргэний хууль”-д¹²¹ өмчлөлтэй холбоотой дараах заалтууд байна. Үүнд,

“105.1. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгийг арав буюу түүнээс дээш жилийн турш хууль ёсоор эзэмшиж, ашиглаж байсан эзэмшигч уг эд хөрөнгийг өмчлөх эрхийг тэргүүн ээлжид олж авах давуу эрхтэй байна.

520.4. Гэрийн эд хогшил нь ээлж дараалал, эд хөрөнгийн өвлөгдөх хэсгийн шинж байдлаас үл шалтгаалан өвлүүлэгчийг нас барах үед түүнтэй хамт амьдарч байсан хууль ёсны өвлөгчид шилжинэ” гэжээ.

Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлсэн дурсгалаа худалдан борлуулах эрх нээлттэй. Харин худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд Соёлын өвийн улсын бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэж шилжилт хөдөлгөөний тэмдэглэгээ хийлгэсэн байх ёстой.

Хэдийгээр соёлын өвийн бүртгэл улсын байгууллагаас хөтөлж буй ч иргэд, хуулийн этгээдийн дунд соёлын өвийг нуун далд байлгах сонирхол ихтэй байдаг. Энэ нь нэг талаас иргэд соёлын өвд бүртгүүлэхийн ач холбогдлыг сайн мэдэхгүй, мөн өв бүртгүүлснээр аюулгүй байдал нь алдагдах эрсдэлтэй гэж үздэгээс болж байна. Мөн хосгүй үнэт, ховор нандин эд зүйлийг ил далд хэлбэрээр худалдаж, ашиг олох явдал их байгаа нь соёлын өвийг бүртгэх, хамгаалах, хяналт тавих, хариуцлага тооцох ажиллагаа сул байгаагийн илрэл юм.

Соёлын үл хөдлөх өвийг кадастрын болон өмчлөх, эзэмших эрхийн бүртгэлтэй болгох шаардлага ихээр тавигдаж байна. Хэд хэдэн үл хөдлөх соёлын өв кадастрын зурагт орж, газрын бүртгэлд ороогүйгээс болж бусад газар эзэмшигч нартай газрын маргаанд орж, шүүхээр эрхээ хамгаалуулах нөхцөл үүсэж байсан байна. (Жишээ, Чойжин ламын сүм музей vs “Сити центр”)

¹²⁰ Монгол Улсын Үндсэн хууль.

¹²¹ «Иргэний хууль», accessed 20 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/mn/detail/299>.

Шүүхийн шийдвэр¹²².

Нэхэмжлэлийн шаардлага: Нэхэмжлэгч Чойжин ламын сүм музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Ангирмаа шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: Чойжин ламын сүм музей нь бүхэлдээ XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеийн Монголын уран барилга, уран баримал, уран зургийн дахин давтагдашгүй цогцолбор бүтээл болохыг хүлээн зөвшөөрч 1994 оны 4-р сарын 25-ны өдөр батлагдсан “Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийн 16-р зүйлийн 16.3-д зааснаар Монгол Улсын Засгийн Газрын 1998 оны 12-р сарын 23-ны өдрийн 235 тоот тогтоолоор “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл” мөн болохыг нь тогтоосон байна. Улмаар “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл” болох Чойжин ламын сүм музей хашааны газар болон хашааны эргэн тойрны 6 метр хүртэлх буюу 2 /хоёр/ га газарт ЗГ-ын 2001 оны 4-р сарын 25-ны өдрийн 96 дугаар тогтоолоор хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын бүс дэх түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулахгүй байхыг Нийслэлийн Засаг даргад даалгасан болно.

Чойжин ламын сүм музейн Хамгаалалтын бүсийн газрыг "Бусдын эзэмшил ашиглалтад олгохгүй байх болон барилга байгууламж барихыг хориглосон газрын жагсаалт"-д нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2010 оны 11-р сарын 17-ны өдрийн 180 дугаар тогтоолоор оруулсан бөгөөд НЗДаргын 2010 оны 11-р сарын 30-ны өдрийн 781 дугаар захирамжаар Газар эзэмших эрхийг баталгаажуулсан.

Чойжин ламын сүм музей хамгаалалтын бүсийн зүүн хойд талд 3 м газарт нэвтэрч 100 орчим м.кв талбай бүхий хэсэгт нийслэлийн Засаг даргын хууль бус шийдвэрийн улмаас барилга байгууламж барих ажлыг эхлүүлээд байна. Энэхүү барилга байгууламжийн ажлаа зогсоохыг “Сити центр” гэх газарт 2 удаа мэдэгдсэн боловч ямар нэг хариу өгөхгүй, барилгын ажлаа зогсоож газар чөлөөлж өгөхгүй байсан тул нийслэлийн Засаг даргад дээрх шийдвэр, захирамжуудыг хүчингүй болгуулахаар гомдол гаргасан боловч гомдлыг хангахгүйгээр 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 4/2215 тоот албан бичгээр “Шүүхэд хандан шийдвэрлүүлнэ үү” гэж хариу өгсөн болно.

Иймд Нийслэлийн Засаг даргын 2002 оны 35 тоот захирамж, 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 09 тоот захирамж, 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/152 дугаар захирамж нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 17.7, Соёлын тухай хуулийн 20-р зүйлийн 20.2, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 24-р зүйлийн 24.2, Газрын тухай хуулийн 31-р зүйлийн 31.3, 33-р зүйлийн 33.4 дэх хэсгүүдэд заасныг зөрчиж байх тул иргэн Б.Батзоригт холбогдох хэсгүүдийг хүчингүй болгож, "Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл"-ийн хадгалалт хамгаалалтын хэвийн нөхцөлийг хангаж өгнө үү гэв.

Анхан шатны шүүхийн шийдвэр: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 40 дүгээр шийдвэрээр: Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 4 дүгээр зүйлийн 4.1.3, 21 дүгээр зүйлийн 21.2.3, 31 дүгээр зүйлийн 31.3, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.2.2-т заасныг тус тус баримтлан

¹²² Улсын дээд шүүхийн тогтоол, Чойжин ламын сүм музейн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн тухай, Legaldata.mn н. 2016 он, accessed 29 Аравдугаар сар 2024.



Нийслэлийн Засаг даргад холбогдуулан гаргасан “Нийслэлийн Засаг даргын 2007 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 09 тоот захирамж, 2012 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/152 дугаар захирамжийн иргэн Б.Батзоригт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” шаардлага бүхий Чойжин ламын сүм музейн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож,

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4-т заасныг баримтлан нийслэлийн Засаг даргад холбогдуулан гаргасан “нийслэлийн Засаг даргын 2010 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 781 тоот захирамжийн Чойжин ламын сүм музейд холбогдох хэсгийн Б.Батзоригийн газартай давхцалтай хэсгийг хүчингүй болгуулах” гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч бие даасан шаардлагаасаа татгалзсаныг баталж шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлал: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 221/МА2016/0215 дугаар магадлалаар: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 40 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

Улсын дээд шүүхийн тогтоол: Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.

“Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль” /1994 оны/-ийн 16 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 235 дугаар тогтоолоор “Чойжин Ламын Сүм Музей”-г “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл” болохыг тогтоож, 2001 оны 96 дугаар тогтоолоор музейн хамгаалалтын бүсийг 2.0 га байхаар тогтоон, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг баталгаажуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2010 оны 781 дүгээр захирамжаар Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутагт нэхэмжлэгч “Чойжин Ламын Сүм Музей”-н 20000 м.кв газар эзэмших эрхийг баталгаажуулсан байна.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 40 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 221/МА2016/0215 дугаар магадлалыг тус тус хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхисугай.

Дээрх шүүхийн шийдвэрээс харахад “Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл” болох музейн эзэмшлийн газрын асуудал нөгөөг хүртэл маргаантай шийдвэрлэх, зохицуулах шаардлагатай асуудал байсаар байна. Цаашид энэ төрлийн газрын маргаантай асуудлыг ул суурьтай судалж, түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсээ хамгаалах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улсын Засгийн газраас түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамгаалалтын бүс тогтоож, тухайн бүсэд барилга байшин барих болон бусад хэлбэрээр хохирол учруулахгүй байх талаар тухайн шатны Засаг даргад үүрэг болгодог боловч Нийслэл Улаанбаатар хотын хувьд энэ тогтоол хэрэгжихгүй олон жишээ байна. Тухайлбал, Чойжин ламын сүм музей, Богд хааны ордон музей, Гандантэгчинлэн хийдийн хамгаалалтын бүсэд хууль зөрчин хуулийн этгээд, иргэнд газар олгосноос тухайн дурсгалын эргэн тойронд олон тооны барилга, байшин баригдаж, түүний хадгалалт, хамгаалалтын байдалд аюул учруулах, харагдах сүр барааг дарсаар байна. Энэ



тохиолдолд ямар хариуцлага хүлээх хууль эрх зүйн орчин дутмаг байгааг мөн анхаарах шаардлагатай байна.

2.Соёлын биет өвийг худалдах

Соёлын өвийг эдийн засгийн эргэлтэд оруулах, үзмэрийн хуулбар, загвараар бэлэг дурсгалын эд зүйл хийх, худалдах, үйлдвэрлэх, борлуулахдаа мерчандайзинг ашиглах, мерчадайзийн гэрээнд заавал тусгах шаардлагыг боловсруулах, үнэт эдлэлийн далд арилжааг ил болгох, нээлттэй дуудлага худалдаа явуулах эрх зүйн орчин бий болгох, Түүх соёлын ховор нандин үзмэр цуглуулагч иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа хосгүй үнэт зүйлийг олон нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, хувийн музей байгуулах эрхийг нээлттэй болгоно гэж хуулийн үзэл баримтлалд тусгасан байдаг.

2021 оны 02 дугаар сар, 2024 оны 8 дугаар сард Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 35.1 дэх хэсэгт зааснаар “Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журам”-ыг Соёлын өвийн газраас шинэчлэн боловсруулж байгаа тул энэ харилцааг сонирхогч, оролцогч зохих этгээд, иргэдээс журамд тусгах саналыг нээлттэй авч байна.¹²³ гэх боловч СӨХТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн журам өнөөг хүртэл батлагдаагүй байна.

Энэхүү журам батлагдаагүйгээс улбаалж Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох асуудлыг хэрхэх нь тодорхойгүй нөхцөл байдалтай байна.

Долоо.Соёлын өвийг хамгаалах болон хяналтын тогтолцоо

Үнэлэх хэсэг	37.1.Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, эрх бүхий этгээд хариуцна. 37.2.Соёлын өвийн хамгаалалтад соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавина. 37.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтооно. Өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. 38.1.2.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгохыг хориглоно.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

¹²³ gogo.mn, «Түүх, соёлын дурсгалт зүйлийг худалдах, солилцох журмын өөрчлөлтөд санал авч байна», gogo.mn, accessed 29 Аравдугаар сар 2024, <https://gogo.mn/r/99m11>; «Журмын төсөлд санал авч байна», accessed 29 Аравдугаар сар 2024, <https://moc.gov.mn/news/itBNqB9hbtyNw0UrCVx9hILNODbyBUQR>.



Соёлын өвийг хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын Долоодугаар бүлэгт хуульчилсан. Соёлын өвийг хамгаалах асуудлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, тус хуулиар үүрэг хүлээсэн байгууллага эрх бүхий этгээд хариуцахаар зохицуулжээ. Харин соёлын өвийг хамгаалах асуудалд тавих хяналтын тогтолцооны хувьд соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, соёлын өвийн хяналтын улсын байцаагч, гэрээт харуул, хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавихаар хуульчилсан байна.

Мөн соёлын өвийг хамгаалах, түүнд хяналт тавих асуудлын хүрээнд соёлын өвд хохирол учруулж болзошгүй тодорхой үйл ажиллагааг хориглох, зогсоох талаар болон тус шаардлагыг зөрчсөн этгээдийг илрүүлэхэд аливаа хэлбэрээр дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, улсын байцаагч, гэрээт харуулыг урамшуулах, соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамгаалах арга хэмжээ авах тухай тодорхой заажээ.

Соёлын өвийг хамгаалах болон хяналтын тогтолцооны хүрээнд өмнө нь хэсэгчлэн хийгдсэн зарим судалгаа болон салбарын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагад тулгуурлан хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг практикт хамгийн ихээр тулгамдаж буй асуудлын хүрээнд шийдлийг тодорхой болгох зорилгод нийцүүлэн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дээрх дөрвөн заалтыг “Үнэлэх хэсэг”-ийн объект болгож, сонгон авсан болно.

Чингэхдээ эхний хоёр заалтын хүрээнд хэрэгжилтийн үр дагаврын талаарх дүн шинжилгээг үр дүнтэй байлгах үүднээс соёлын өвийг хамгаалах, хяналт тавих асуудлаар үүрэг хүлээсэн субъектүүдийг цөмийг нь авч үзэх нь нэг талаар гуравдугаар хэсэгт танилцуулагдсан эрх бүх субъектүүдийн бүрэн эрхийн хүрээнд дурдагдсан асуудлуудтай давхцах сөрөг талтай. Нөгөөтээгүүр хуульд тодорхой бус зохицуулагдсан боловч мэргэжлийн хяналтын чиг үүргийг өмнөх уламжлалын дагуу хэрэгжүүлж, соёлын өвийг хамгаалах болон хянах хүрээнд хамгийн бодитой үр дүн гаргадаг соёлын өвийн хяналтын улсын байцаагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж буй баримт бичгийн хэрэгжилтийн үр дагаварт төвлөрөх нь өндөр ач холбогдолтой гэж үзэв.

Удаах заалтуудын хувьд Аймаг, нийслэлийн Засаг даргын хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтоох болон палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгохыг хориглох тухай асуудал өдгөө соёлын өвийг хамгаалах, энэ асуудалд хяналт тавих тогтолцооны хүрээнд тулгамдаж буй хамгийн чухал асуудал байх тул эдгээр зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийж, нөхцөл байдлыг сайжруулахад саад болж буй шалтгаан нөхцөлийг илрүүлж, тодорхойлох нь нэн тэргүүний анхаарах асуудал болоод байна.



**Соёлын хяналтыг хэрэгжүүлдэг улсын байцаагчийн эрх зүйн байдал
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотойгоор хэрхэн
өөрчлөгдсөн тухай болон хяналтын чиг үүргийн хэрэгжилтийн практик төлөв
байдлыг тогтоох нь**

№	Ярицлага
1.	*Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг – Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасан. Үүний үндсэн шалтгаан нь төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудын чиг үүргийн давхардлыг арилгах зорилготой байсан гэдэг. Гэвч бодит байдалд соёлын хяналтыг хэрэгжүүлдэг байцаагч нь өөр ямар нэгэн яам, агентлагт харьяалагддаггүй байсан бөгөөд бусад байгууллагад үүссэн чиг үүргийн давхардлын хүрээнд бүтцийн хувьд хамт татан буугдсан.
2.	* Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдахаас өмнөх нөхцөл байдлын хувьд соёлын хяналтыг хэрэгжүүлдэг байцаагч бүсчилсэн маягаар орон нутагт 5, нийслэлд 1 буюу нийт 6 байдаг байсан. Орон нутгийн байцаагчид маань Өмнөговь, Дорнод, Баян-Өлгий, Хөвсгөл, Өвөрхангай зэрэг 5 аймагт суурьшиж, соёлын хяналтыг хэрэгжүүлж байв. Одоо соёлын байцаагч нар маань Соёлын яаманд харьяалагдах болсон тул Соёлын сайдаас улсын байцаагчийн эрхээ авч, орон нутагт тухайн аймгийн Соёл урлагийн газарт харьяалагдаж байна. Ингэснээр Соёл урлагийн газрын дарга нь ахлах байцаагчийн эрх, үүргийн хэрэгжүүлэх болсон. Гэвч орон нутагт хүн хүч дутмаг, хүүний нөөцийн боломж бололцоо хомс байдаг тул цөөнгүй тооны өөр үндсэн ажилтай хүмүүсийг хавсран гүйцэтгэгчээр томилж, соёлын хяналтыг хавсран гүйцэтгэх байдлаар хэрэгжүүлж байна.
3.	*2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 27 дугаар бүлэгт Соёлын өвийн эсрэг үйлдэгдэх гэмт хэргүүдийг хуульчилсан байдаг. Энэ дагуу цагдаагийн газраас манайхтай хамтарч ажиллах алба байгуулж, харьяалал тус бүр дээр нэг цагдаа, нэг соёлын байцаагчтай 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан. Гэхдээ цагдаа нь зөвхөн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйд мөрдөн шалгах ажиллагаа явуулах тул зөрчлийн шинжтэй хэсэгт нь соёлын байцаагч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу прокурорын хяналт дор ажиллагаа явуулж, арга хэмжээ авдаг. Хэрэв тухайн шалгагдаж байгаа асуудал нь зөрчлийн шинжийг ялимгүй агуулсан шууд үр дагаврын хувьд залруулах боломжтой байвал албан шаардлага хүргүүлэх маягаар соёлын хяналтын байцаагч бие даан шийдвэрлээд явдаг.
4.	*Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан хориглох үйл ажиллагааны хүрээнд палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгохыг хориглодог. Энэ заалт уг нь манай салбарын тухайд хамгийн өндөр ач холбогдолтой юм. Учир нь бусад хориглох үйл ажиллагааны хүрээнд нэгэнт түүх, соёлын дурсгал байгаа гэдэг нь мэдэгдчихсэн байдаг бол энэ нь мэдэгдээгүй газар газар олгох, ашигт малтмалын хайгуул хийхээс урьдчилан сэргийлж байдгаараа онцлог юм.
5.	*Мөн тулгамдаж буй удаах асуудал нь түүх, соёлын дурсгалыг мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбоотой харилцаа юм. Энэ хүрээнд тухайлсан нарийн байршлыг тогтоож чадахгүй, олдоогүй гэх мэт тайлбартайгаар бүртгэх асуудал үүсдэг. Үүнээс гадна түүх, соёлын дурсгал бүхий газрын кадастрын зургийг үйлдүүлсэн байдаг боловч үүнийгээ бүртгэлийн санд бүртгүүлдэггүй тохиолдлууд цөөнгүй байдаг.



Соёлын салбарын хяналтын тогтолцоо, бүтэц, орон тоо

Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг төрийн захиргааны байгууллагын албан тушаалтнуудын чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 417 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг – Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон татан буулгасан. Үүний үр дагаварт соёлын хяналтыг хэрэгжүүлж байсан улсын байцаагч Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд харьяалагдах болсон. Ингэснээр нийслэл хот болон 21 аймагт соёлын хяналтыг хэрэгжүүлэх улсын байцаагчид нь тус яамны сайдаас эрхээ авч, Соёлын өвийг хамгаалах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу чиг үүргээ хэрэгжүүлж байна. Өдгөө улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 46 соёлын хяналтын улсын байцаагч ажиллаж байна¹²⁴.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотой соёлын хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон баримт бичигт гарсан өөрчлөлт, түүний хэрэгжилтийн үр дагавар

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд хяналт шалгалтын хэлбэрийг зохицуулаагүй байдаг. Харин тус хуулийн 9 дүгээр зүйлд Хяналт шалгалтын байгууллагын бүрэн эрхийг хуульчилсан бөгөөд 9.2.1-д хяналт шалгалт явуулахтай холбогдсон журам, заавар, маягт, аргачлал, техникийн ерөнхий шаардлага, хяналтын хуудсыг хууль тогтоомж болон энэ хуулийн 5.19-д заасан нийтлэг журамд нийцүүлэн батлах эрхийнхээ дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартыг баталсан байдаг. Тус стандартын 8 дугаар зүйлд хяналт шалгалтын хэлбэрийг дараах байдлаар зааж байжээ. Үүнд:

- Шалгалт;
- Урьдчилан сэргийлэх шалгалт;
- Тандалт судалгаа;
- Хяналт шинжилгээ;
- Зөвлөн туслах үйлчилгээ.

Эдгээр хэлбэрүүдийн хүрээнд тандан судалгаа болон зөвлөн туслах үйлчилгээ нь салбарын хууль тогтоомжийн зөрчил гарах эрсдэлийг хамгийн тохиромжтой байдлаар үнэлж, үүний үндсэн дээр зөвлөн туслах замаар хяналт шалгалтын үйл ажиллагааны үндсэн зорилгыг хангаж ирсэн байдаг. Үүнийг соёлын хяналтын улсын байцаагч болон салбарын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын явцад санал нэгтэй баталж байв.

Өдгөө Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдсантай холбоотойгоор уг стандарт хүчингүй болж, үүнийг дагаж мөрдөхгүй болсон. Харин Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгах Засгийн газрын 417 дугаар тогтоол гарсны дараа Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 479 дүгээр “Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай” тогтоолоор “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”, “хяналт шалгалтын баримт бичгийн загвар”-ыг тус тус баталсан юм.

Хяналт шалгалт хийх нийтлэг журамд өмнөх стандартаар тогтоосон хяналт шалгалтын хэлбэрийг зохицуулаагүй орхигдуулсан атлаа хяналт шалгалтын төрөл, арга гэх мэт хуулиар зохицуулсан асуудлыг давтах шинжтэй дурдсан байх тул дээрх хяналт шалгалтын хэлбэр ийнхүү хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн бүрдэлд

¹²⁴ https://moc.gov.mn/p/inspection_1_1



хамаарахгүй болсон. Үүний үр дүнд соёлын хяналтын улсын байцаагчид тандан судалгаа хийж, салбарын хууль тогтоомжийн зөрчил үүсэх эрсдэл бүхий нөхцөл байдалд байгаа иргэн, аж ахуйн нэгж, бусад этгээдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх замаар төрийн хяналт шалгалтын үндсэн зорилгыг биелүүлэх боломж бодитоор хумигдсан байна.

Соёлын хяналтын улсын байцаагчийн үйлдэх баримт бичгийн загварын бүрдэл нь өдгөө нийт 16 төрөл¹²⁵ байна. Үүнд:

- Хяналт шалгалтын удирдамж;
- Хяналт шалгалтын хугацаа бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан тухай тэмдэглэл, мэдэгдэх хуудас;
- Шалгалтын тэмдэглэл, хяналт шалгалтын танилцуулга;
- Хяналт шалгалтын танилцуулгыг удирдах албан тушаалтанд танилцуулсан хуудас;
- Үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох акт;
- Улсын байцаагчийн албан шаардлага, улсын байцаагчийн акт;
- Улсын байцаагчийн дүгнэлт;
- Салбарын улсын ерөнхий байцаагчийн шийдвэр;
- Улсын ахлах байцаагчийн шийдвэр;
- Салбарын улсын ерөнхий байцаагчийн албан даалгавар зэрэг болно.

Үүнд зөвлөмж өгөх баримт бичгийн загвар байхгүй байгаа нь соёлын хяналтын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож буй баримт бичгийн бүрдэлд орсон өөрчлөлт нь хяналт шалгалтын хэлбэрийг хүчингүй болгосонтой холбоотой болох нь харагдаж байна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтоох тухай хэм хэмжээний хэрэгжилт

Соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, харагдах сүр барааг хадгалах нь чухал байдаг бөгөөд энэ талаар Соёлын өвийг хамгаалах тухай хуульд тодорхой зохицуулалтууд тусгагдсан байна. Мөн 1964 онд Италийн Венец хотноо Түүхэн дурсгалт барилгын архитектор, мэргэжилтнүүдийн Олон улсын II конгрессоос баталсан “Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах олон улсын харти”-ийн Зургаадугаар зүйлд Хөшөө дурсгалыг хадгалж хамгаалах ажлыг явуулахдаа тэдгээрийн орчин тойрны байдлыг анхаарах хэрэгтэй. Хэрэв уламжлалт орчин нь хэвээр байгаа бол түүнийг хадгалж үлдээвэл зохино. Өнгө ба массын харьцааг өөрчлөхүйц шинэ барилга байгууламж, өөрчлөлт, шинэчлэлтийг уг орчинд байлгаж болохгүй” гэж заасан байдаг.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 37 дугаар зүйлийн 37.6 дахь хэсэгт заасан энэхүү зохицуулалтад дурдсан Засаг даргын суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтоох эрхийн хэрэгжилт нь хангагдах хууль зүйн боломжгүй юм. Учир нь өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар хуульчилсан бөгөөд уг шалгуур үзүүлэлт өдгөө батлагдаагүй байна.

¹²⁵ https://moc.gov.mn/p/inspection_3_5



Тохиолдол: Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн барилгын зүүн талд Худалдаа хөгжлийн банк 28 давхар барилга бариулахаар барилгын ажил эхлүүлсэн боловч барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дууссан, сунгуулж чадаагүй шалтгаанаар түр зогссон байдалтай байгаа аж. Энэ тохиолдолд тус 2 давхар музейн барилгын хажууд 28 давхар баригдах явцад музейн барилга болон түүнд хадгалагдаж байгаа соёлын өвд эрсдэл учрахаас эхлээд уг барилга баригдаж музейн барилгын харагдах орчны өнгө массын харьцаанд өөрчлөлт орж, сүр бараанд хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг тодорхойлох шаардлагатай юм.

Тус шалгуур үзүүлэлтийг батлахын тулд хоёр яамны хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, эхний байдлаар түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын эргэн тойронд өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулсан байна. Уг төслийг боловсруулахдаа архитектурын дурсгалыг хадгалж хамгаалах олон улсын туршлага, үндэсний хууль тогтоомж, норм нормативын нөхцөлийг харгалзан 20 шалгуур үзүүлэлтийн дагуу өндрийн хязгаар тогтоох нөхцөлийг тусгасан байгаа бөгөөд боломжит богино хугацаанд төсөл эцэслэн батлагдана гэсэн хүлээлттэй байна.

Палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгохыг хориглох зохицуулалтын хэрэгжилтийн үр дагавар

Ашигт малтмалын тухай хуульд 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр 40^{1.2}-т “Ашигт малтмалын хайгуул хийхдээ палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно” гэх заалт орсон. Гэвч ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтад дээрх мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авах талаар тухайлан заагаагүй. Түүнчлэн тусгай зөвшөөрөл хүсэх үед бөглөдөг маягтуудын загварт дээрх шаардлагыг тусгаагүй байгаа нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн 40^{1.2}-т дээрх зохицуулалт нь хайгуулын эсхүл ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө хэрэгжихэд чиглэсэн хуульчлагдсан зорилгодоо хүрэх боломжгүй байна.

Найм.Соёлын өвийг сэргээн засварлах

Үнэлэх хэсэг	46.1.Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулсан сэргээн засварлах зураг төслийн дагуу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага, иргэн гэрээгээр гүйцэтгэнэ. 46.3.Соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 46.9-д заасан дүгнэлтэд үндэслэн олгоно. 46.4.Хуульд өөрөөр заагаагүй бол соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага соёлын биет өвийг сэргээн засварлаж болно. 46.5.Соёлын биет өвийг зөвшөөрөлгүй сэргээн засварлахыг хориглоно.
----------------------------	---



Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?
------------------------------------	--

1.Соёлын биет өвийг сэргээн засварлах өнөөгийн нөхцөл байдал

Түүх, соёлын дурсгалт барилга нь нэмэх, хасах 30 хүртэлх градусын эрс тэс уур амьсгал, нар, салхи, цас, бороо, чийг, аянга цахилгааны мөнхийн нөлөөлөл мөн, хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоос, авто машины болон яндангийн утаа, хог хаягдал, түүнчлэн мал амьтны өтөг, сангаас зэргийн улмаас өгөрч гэмтэх, хагарах, хуурч унах, бутрах, үйрэх зэргээр анхны хэлбэр, төрхөө алдаж, хийц, загвар, чимэглэл, зураглалд гэм согог суудаг тул үе шаттайгаар сэргээн засварлаж байх шаардлагатай байдаг.¹²⁶

Энэ хүрээнд “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль (1994), Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2001), Соёлын өвийг хамгаалах тухай (2014) хуулийн “зорилго” буюу тухайн хуулиар хамгаалахаар зорьж байгаа харилцаа, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнгийн хэсэгт “сэргээн засварлах” талаар тухайлан тусгасан нь энэ үйл ажиллагаа ямар чухал болохыг харуулж байна.

Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах үйл ажиллагааг гэр, орон сууц, ажлын байраа засварлаж байгаагийн нэгэн адилаар дуртай цагтаа өөрийн үзэмж, сонголтоор хийж болохгүй мэргэжлийн нарийн мэдлэгийг үндэслэл болгохын зэрэгцээ төрийн зөвшөөрлийг үндэслэл болгодог. Соёлын өвийг сэргээн засварлахтай холбогдон үүсэх харилцааг СӨХТХ-д нийт 13 зүйлд 31 удаа зохицуулсан байх бөгөөд үүнээс дурсгалт барилгыг сэргээн засварлахад шууд хамааралтай нь “захиргааны байгууллагын бүрэн эрх”, “соёлын өвийн бүртгэл”, “соёлын биет өвийг эзэмшигч, өмчлөгчийн эрх, үүрэг”, “соёлын өвийг сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах”, соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага, түүний үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан зүйлүүд байна.¹²⁷

Түүх, соёлын дурсгалт барилгыг “хамгаалах, хэсэгчлэн сэргээн засварлах, бүтнээр нь сэргээн засварлах¹²⁸” гэсэн үндсэн гурван аргаар сэргээн засварлах бөгөөд ингэхдээ “анхны төрх, хийц бүтээцийг хадгалж үлдээх”, “аюулгүй, удаан хугацаанд хадгалах нөхцөлийг хангах” үндсэн зарчмыг баримталдаг байна.

№	Ярилцлага
1.	*Монгол Улсад дурсгалт барилгыг сэргээн засварлах эрх бүхий 10 гаруй байгууллага бүртгэлтэй байдаг боловч одоогийн байдлаар 1-2 компани л гүйцэтгэж байна. Үүний улмаас сэргээн засварлалтын холбогдох тендер зарлагдахад сэргээн засварлалтыг хийж гүйцэтгэх компанийн асуудал үүсдэг. Учир нь тендерийн 45 хоногийн хугацаа болж шалгаруулалт хийгдэхэд нэг ч компани оролцоогүй тохиолдлууд гарч байгаа. Энэ тохиолдолд төсөв хураагдах эрсдэл, музейн дээврээс бороо ороод хосгүй үнэт үзмэр норох аюултай энэ хүнд нөхцөлд музейн хамт олон бид маш хүнд байдалд ордог. Бид чинь яг л ажлын талбар буюу халуун тогоонд нь ажиллаж байгаа улсууд

¹²⁶ З.Сүхбаатар and Д.Отгонсүрэн, *Дурсгалт барилгын сэргээн засварлалт: тулгамдаж буй асуудлууд*, Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах үйл ажиллагааны эрх зүйн орчин (УБ, 2019), 20.

¹²⁷ 21.

¹²⁸ Ц.Цэрэнжанцан, Л.Ганбаатар, Д.Ганбаатар. Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах уламжлалт арга. (УБ, 2006), 10. Дам эшлэв.



	шүүдээ. Ингээд бид сэргээн засварлалтын 2 компанийг тендерт оролцоорой гэж гуйгаад сууж байна. Энэ нь нэг ёсондоо өрсөлдөгчгүйгээр ялах боломжтой гэсэн үг. Энэ 2 компанийн нэг нь шалгарч сэргээн засварлалт хийгддэг хэдий ч гүйцэтгэлийн чанар байнга асуудал болсоор ирсэн ба ялангуяа тухайн байгууллагын хүний нөөцийн ур чадвар, хүрэлцээ муу байдаг. Сэргээн засварлалт нь судалгаа шинжилгээ, төсөв санхүү, цаг хугацаа шаардагдсан их нарийн ажил.
2.	*Өнөөдөр сэргээн засварлалтын чанар хэн хяналт тавьж явах ёстой юм бэ гэдэг асуудал байсаар байна. Сэргээн засварлах газарт ажиллаж байсан 10 хүрэхгүй хүнээс өөр хүн алга байна. Одоо тэд бүгд тэтгэвэрт гарсан. Энэ хүмүүсийн үгийг л сонсож, зөвлөгөөг нь дагаж байна. Гэтэл энэ хүмүүсээ буюу Монгол Улсын зөвлөх архитектор гэдэг эрхэм хүндтэй эрдэмтэн судлаачийн судалгаа шинжилгээний үр дүн, зөвлөмжийг хүртэл үгүйсгээд буруутгаад явж байна шүү дээ зарим хүмүүс. Ийм тохиолдолд яах ёстой вэ?
3.	*Энд тэнд ийм музей ингэсэн байна. Тэнд ийм музейн уран барилгыг ингээд засчхаж гэсэн яриа, шүүмж олон байдаг. Гэтэл музейд тухайн сэргээн засварлалтын ажил хийгдэж байгаа л болохоос сэргээн засварлалтыг гүйцэтгэх, хүлээн авах, чанарт хяналт тавих нь хууль эрх зүйн хувьд музейн эрх үүргээс давсан асуудал.
4.	*Дурсгалт уран барилгын сэргээн засварлалтыг гал унтраах маягаар хийдэг зүйл биш юм. Сэргээн засварлалтаас өмнө хадгалалт хамгаалалтад нь анхаарах, судалгаа шинжилгээ хийдэг байх, хүний нөөцийг бэлдэх, сэргээн засварлалтын ажлыг чанартай гүйцэтгэх тал дээр анхаарах, гүйцэтгэгч компаниудыг бодлогоор нэмэгдүүлэх, мэргэжлийн зөвлөлийг ажиллуулах зэргээр гарц, шийдэл олж, бодлогод тусгах шаардлага байна.
5.	*Монгол Улсын хувьд дурсгалт уран барилгын чиглэлд сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалтыг хийсээр ирсэн. Гэхдээ олон улсын хадгалалт хамгаалалтын стандартыг хангаж ажиллах асуудалд дутмаг байна. Учир нь мэргэжлийн боловсон хүчин мэргэжилтэн алга, Судалгаа шинжилгээ хийх лаборатори болон тоног төхөөрөмжийн хувьд хязгаарлагдмал. Дээр дурдсан асуудлуудаас үүдэж сэргээн засварлалтад дутагдалтай зүйл байна. Тиймээс энэхүү дутагдлыг Соёлын яам болон мэргэжлийн байгууллагуудын эрдэмтэн судлаачидтай хамтран олон улсын жишигт нийцсэн хадгалалт хамгаалалтын арга зүйг Монголд нутагшуулах судалгааг эхлүүлэх шаардлагатай.
6.	*Түүх, соёлын барилга байгууламжийн сэргээн засварлалтын ажлыг хийхэд тухайн барилгын хийц, загвар, бүтэц, орц материал, ашиглалт талаас нь иж бүрэн судалдаг, судалгааныхаа үр дүнг ашиглаж сэргээн засварлалтын ажлын даалгаварт тусгуулах, зөвлөмж өгөх эрх бүхий мэргэжлийн судалгааны бүтэц байхгүй. Үүнээс шалтгаалж сэргээн засварлах объектын ажлын зураг, төсвийн тооцоолол оновчтой гардаггүй. Ингэснээр гүйцэтгэлийн явцад нэмэлт ажлууд (төсөвт тусгагдаагүй) их хэмжээгээр гарч түүнд шаардлагатай зардал, хамгийн гол нь тохирох материал бэлдцийг хаанаас хэрхэн олох вэ гэдгийг шийдвэрлэх нь нэн тулгамдсан асуудал болдог.

Дээрх мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд сэргээн засварлалтын холбогдох тендер зарлагдахад сэргээн засварлалтыг хийж гүйцэтгэхэд мэргэжлийн хуулийн этгээд хомс, шалгарсан хуулийн этгээд сэргээн засварлалт хийдэг ч гүйцэтгэлийн чанар, хүний нөөцийн ур чадвар муу, байнга асуудал үүсгэдэг, сэргээн засварлалтыг гүйцэтгэх, хүлээн авах, чанарт хяналт тавих асуудал сул байгаа талаар дурджээ.



СӨХТХ-д 46 дугаар зүйлд Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулсан сэргээн засварлах зураг төслийн дагуу соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага, иргэн гэрээгээр гүйцэтгэх. Соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлтэд үндэслэн олгохоор заасан.

Соёлын өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилго бүхий 13 гишүүнийн бүрэлдэхүүнтэй мэргэжлийн зөвлөл үйл ажиллагаагаа Соёлын сайдын 2021 оны 4 сарын 26-ний өдрийн тушаалаар баталсан “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ын дагуу явуулж байна. Тус зөвлөл нь соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байхаар зохицуулсан байна.

Тус Мэргэжлийн зөвлөл нь:

- Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг төлөвлөх, зохицуулах бодлогын хувилбар боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
- Соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;
- Соёлын биет өвийг сэргээн засварлах ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- Соёлын биет өвийг сэргээн засварласан ажлын тайланг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах;
- Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажлын даалгавар, зураг төслийг хянаж, зөвлөмж өгөх;
- Соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллагад эрх олгох асуудлыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;
- Соёлын биет өвийн сэргээн засварлах үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж өгөх чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Соёлын биет өв тэр дундаа барилга байгууламжийг сэргээн засварлах ажил нь Барилгын тухай хуулиар¹²⁹ зохицуулагдаж байна. Харин Соёлын өвийг хамгаалах тухай хуультай уялдаа сайн хангагдахгүй байгаагаас ердийн барилгын компани сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн бус хүмүүс ажиллах тохиолдол их гарч байна. Түүнчлэн, барилга байгууламжийн төрлийн соёлын өвийн сэргээн засварлалтад хяналт тавих, хариуцлага тооцох хууль зүйн үндэслэл хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай.

Мөн сэргээн засварлах ажилд эзэмшигч байгууллагын үүрэг, оролцоог хязгаарласан эрх зүйн зохицуулалт үйлчилж байгаа тул үүнийг эргэн харж, тухайн байгууллагын үр дүнтэй оролцоог бий болгосон зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн, соёлын биет өвийн сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д заасан журмын дагуу бага үнийн аргаар шалгаруулж байгаа нь гүйцэтгэсэн

¹²⁹ «Барилгын тухай хууль», сес "37.1.11.түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэх, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах; 40.1.4.барилгын ажлын талбайд гал, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны горимыг мөрдөж, байгаль орчин, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах; 46.1.6.байгаль орчин, түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах" гэж зохицуулсан байна., accessed 25 Аравдугаар сар 2024, <https://legalinfo.mn/mn/detail/11705>.



ажлын үр дүнд нөлөөлж болзошгүй тул сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

2.Соёлын биет өвийг сэргээн засварлах зарчим

Үнэлэх хэсэг	47.1.Соёлын биет өвийг сэргээн засварлахад дараах зарчмыг баримтална: 47.1.1.анхны төрх, хийц бүтээцийг хадгалж үлдээх; 47.1.2.аюулгүй, удаан хугацаанд хадгалах нөхцөлийг хангах. 47.2.Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 47.3.Соёлын биет өвийг сэргээн засварласан ажлын дэлгэрэнгүй тайланг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан, архивт шилжүүлнэ.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

Аливаа дурсгалт барилга нь өнөөг хүртэл хэрхэн яаж хадгалагдан үлдэх нь тухайн нутгийн газар зүйн болон байгаль цаг уурын онцлог, улс орны аж амьдралын хэв заншил, ёс суртахуун, шашин шүтлэг, түүхэн хөгжлийн онцлог зэргээс хамаардаг.¹³⁰ Сэргээн засварлагч-архитектор нь тухайн дурсгалт барилгын архитектур, түүний бүтээц хэсгүүдийн хазайлт, гулзайсан хэмжээ, одоогийн байдал, дурсгалын оршин байгаа байгалийн нөхцөл, хот дотор буюу хотын гадна орших эсэх, орчин үед сэргээн засварлах ажил яаж явагдаж байгаа зэрэг нөхцөлүүдээс шалтгаалан сэргээн засварлах аргыг сонгодог.

№	Ярицлага
1.	* Судалгааны ажил хангалтгүй хийгдэж сэргээн засварлах ажлын зураг хэт ерөнхий зохиогдсоноос шалтгаалж тухайн объектын хуучин хэв загвар, хэмжээнд өөрчлөлт орох эрсдэл бий болдог. Нэг удаагийн сэргээн засварлалтын явцад маш бага хэмжээний өөрчлөлт орсон байхад л энэ нь цаашид дахин давтагдахаар хэдэн арван жилийн дараа тэр объект түүхэн дурсгалынхаа мөн чанарыг алдахад хүрэх аюулыг дагуулдаг.
2.	Засварын ажлын материалын зардал хийсвэр төсөвлөгдөж, нэг объектын зардал өндөр гардаг учраас сэргээн засварлалтад хамрагдах объектын тоо, ажлын хэмжээ багасаж байна. Дээврийн ваар, хөх тоосго, тусгай орц найрлага бүхий будаг гэх мэт материалыг өндөр үнэтэй төсөвлөж, зардлыг баталж санхүүжүүлж байгаа боловч тухайн объектыг засварлахдаа гүйцэтгэгч байгууллага хуучин материалыг буцаагаад ихэнх хэсэгт нь ашиглаж байгаа нь тогтсон журам мэт болсон. Эндээс хэмнэгдсэн зардлыг тооцож, ядаж магадлалгүй ажлын зардалд нь шилжүүлэх эсвэл дараагийн объектод зарцуулах шаардлагатай байна.

“Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах

¹³⁰ З.Оюунбилэг (Ph.D), *Дурсгалт барилгын сэргээн засварлалт: тулгамдаж буй асуудлууд*, Дурсгалт барилгын сэргээн засварлалт (УБ, 2019), 8.



журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэж заасан боловч өдийг хүртэл батлагдаагүй байна.

Харин Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 183/111 тоот хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажи гүйцэтгэх журам” хүчин төгөлдөр үйлчилж байна.

2019 онд зохион байгуулагдсан “Дурсгалт барилгын сэргээн засварлалт: тулгамдаж буй асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурлаас дараах саналууд гарсан байна. Үүнд:

- Монгол орны эрс тэс уур амьсгалд зохицсон судалгааны арга зүй болон консервацийн шинжлэх ухаанд суурилсан, системтэй, цогц үйл ажиллагаагаар түүх, соёлын дурсгалт уран барилгын сэргээн засварлалтын ажлын судалгаа болон ажлыг төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;
- Сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий мэргэжлийн баг бүхий бүтцийг төрийн байгууллагын дэргэд бий болгох. Түүх, соёлын дурсгалт барилгад байрлаж үйл ажиллагаа явуулдаг музейн төсөвт дурсгалт барилгын хадгалалт, хамгаалалтын зардал, мэргэжлийн сэргээн засварлагчийн орон тоог тусгах;
- Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журмыг шинэчлэн, СӨХТХ-ийн дагуу “Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журам”-ыг боловсруулж, батлан мөрдүүлэх;
- Дурсгалт барилгын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтыг шинжлэх ухааны ерөнхий судалгаанд тулгуурлан гүйцэтгэх. Тухайлбал, соёлын өвийн хадгалалт хамгаалалтын үйл ажиллагааны гүйцэтгэл, сэргээн засварлах технологи, материалын талаарх судалгаа; соёлын өвийг бүтээсэн материалын чанар, бүтцийн талаарх шинжлэх ухааны судалгаа; шинжлэх ухааны судалгаанд үндэслэн технологийн түүхийг тодорхойлох; соёлын өвийн хадгалалт хамгаалалтын орчин нөхцөлийг судлах;
- Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах ажлын норм, үнэлгээг шинэчлэн боловсруулах. Дурсгалт барилгын сэргээн засварлах ажлын тендерийг барилгын ажил эхлэх улирлаас өмнө буюу 5 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө шалгаруулж, сэргээн засварлах ажлыг дулааны улиралд чанартай гүйцэтгүүлж байх;
- Дурсгалт барилгыг сэргээн засварлах эрх бүхий байгууллагуудыг чанаржуулах, шинээр бий болгох, хүний нөөцийг чадавхжуулах;
- Сэргээн засварлах ажлын судалгааны нэгэн хэсэг болох физик-химийн шинж чанар (нягтрал, сүвэрхэг байдал, гидрофизик шинж чанар буюу ус нэвчилт, хүйтэн даах чадвар)-ыг тодорхой чанарын үзүүлэлтийн дагуу хэмжин тогтоох шаардлагатай тул судалгааны байгууллагатай хамтран зохих хэм хэмжээг боловсруулж, батлуулах;
- Сэргээн засварлалтын ажилд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх талаар холбогдох яамд, боловсролын байгууллага, олон нийтийн болон хувийн байгууллагууд хамтран ажиллаж, нэгдсэн цогц бодлогын хүрээнд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх шаардлагатай гэсэн байна.

Дээрх ажил хэрэгч саналуудыг хууль тогтоомжид тусгах шаардлагатай байгааг анхаарах.



Ес.Соёлын өвийг сурталчлах харилцаа

Үнэлэх хэсэг	49.1.Соёлын өвийн талаарх мэдлэг олгох, түүнийг хамгаалах, сурталчлах арга хэмжээг гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалаар дамжуулан хэрэгжүүлнэ
Томъёолсон шалгуур үзүүлэлт	1. Хуулиар тогтоосон шалгуур тус бүрийн хэрэгжилтийн үр дагавар хангагдсан эсэх?

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлалд “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархаа мөн гэж заажээ.

Соёлын салбарыг дангаар нь, бусад салбараас салгаж авч үзэх нь өрөөсгөл юм. Учир нь, энэ салбар нь нийгмийн хөгжлийг дэмждэг, ажлын байрыг бий болгож, ядуурлыг буруулахад онцгой хувь нэмэр оруулдаг. Соёлын салбар нь бүх нийтийн боловсролын чанарыг дээшлүүлдэг бөгөөд энэ нь байгаль орчноо хамгаалах, нийгмийн шударга ёсны мэдрэмж, мэдлэгийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг онцгой салбар тул соёлын бодлогын хувьд нийгмийн өргөн зорилтод хүрэхэд дэмжих нь өндөр ач холбогдолтой байна.

Бүтээлч болон соёлын салбарыг дэмжих хүчтэй бодлого, өргөн хүрээний арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна. Үүнд, хэвлэл мэдээллийн оролцоо, соёлын олон төрлийн контентыг иргэдэд хүргэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар соёлын засаглалыг бэхжүүлэх, цахимжилтыг соёлын салбарт зөв ашиглах, иргэний нийгмийг дэмжих зэрэг юм.

Соёлын өв нь нийгмийн бүлгийн оюун санааны, материаллаг, оюуны болон сэтгэл хөдлөлийн онцлог шинж чанаруудын нэгтгэдэг бөгөөд үүнд, урлаг, уран зохиолоос гадна амьдралын хэв маяг, хамтын амьдралын арга зам, үнэт зүйлийн тогтолцоо, уламжлал, итгэл үнэмшил багтдаг (ЮНЕСКО-гийн 2009 Соёлын олон янз байдлын талаарх тунхаглал). Үүнээс харвал, нэг үндэстний түвшинд соёлын нийтлэг өв нь нийгмийн үнэт зүйл бөгөөд өнөөгийн болон хойч үеийн тусын тулд хүлээн зөвшөөрч хамгаалах ёстой.

Соёлын тухай хуулийн 8 дугаар зүйл буюу Төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх соёлын үйл ажиллагааны чиглэлд *“байгаль орчин, уламжлалт ахуйтайгаа харилцан шүтэлцсэн нүүдлийн соёл иргэншлийн онцлогийг хадгалсан орон зай, газар нутгийг тогтоох, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Нүүдлийн соёл иргэншлийн дурсгалт газар уламжлалт ахуйг хамгаалах тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх”*-ээр гэж заасан. Өөрөөр хэлбэл, нүүдлийн соёлыг хадгалж хамгаалахад соёлын салбараас дэмжлэг үзүүлнэ гэсэн байна.

Дурсгалт газрын хадгалалт хамгаалалт, судалгаа шинжилгээ, сурталчилгааны үйл ажиллагаа ЮНЕСКО-ийн зүгээс тавьдаг, шаардлагын түвшинд гүйцэтгэж чадахгүй байна.

Нүүдлийн соёл нь өөрөө дэлхий даяар амьдран сууж буй олон ард түмний бусдаас ялгагдах онцлог шинж болдог ч нүүдлийн өв соёлын талаар тухайлсан төрийн бодлого хомс байна. Нүүдэлчин ард түмний эрхийн асуудал олон улсын хүний эрхийн тухай бүгдэд тэгш эрх эдлүүлэх ерөнхий зохицуулалтын нөмөрт хамгаалагдаж байгаагаас бусдаар онцгойлон тусгагдсан зүйл заалт байхгүй байна.



Нүүдлийн өв соёлыг аж ахуйн хэлбэр болох талаас нь дэлхий нийтээр хүлээн зөвшөөрүүлж, сурталчлан таниулж, дэмжиж, хадгалж хамгаалахын тулд орчин үечүүлэхэд чиглэсэн төрийн бодлого хэрэгтэй байна.¹³¹

ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр “Монгол ардын уртын дуу лимбэдэх арга -битүү амьсгаа” төслийг 2019 оноос Соёлын яам хэрэгжүүлсэн. Шавь сургалтын үр дүнд 2022 оны 6 сард Монгол лимбэчдийн уралдааныг зохион байгуулсан байна. Нийт 40 гаруй оролцогчдоос шалгаруулалт явагджээ.

Соёлын бүтээлч сар, Хүрээ цам Даншиг наадам, Нүүдэлчин наадам, ардын урлагийн наадам, “Монгол цам” тусгай үзэсгэлэн, “Цам” контент, “Цам” боловсролын хөтөлбөр, “Язгуурын таван шүтээн” тусгай үзэсгэлэн, “Дэлхийн өв - Монгол Алтайн хадны зураг” үзэсгэлэн, Нүүдэл буюу On the move” олон улсын үзэсгэлэн, “Урлахуй, шүтэхүй, гэгээрэхүй” шүтээн зургийн тусгай үзэсгэлэн, “Welcome home” тусгай үзэсгэлэн, “Ноёд, тайж нар, хутагт хувилгаадын гэрийн үеийн бичмэл” архивын баримтын үзэсгэлэн, “Монгол Улсын баримтат өвийн дурсгал” гэр үзэсгэлэн, ЮНЕСКО-д бүртгэгдсэн соёлын биет бус өвийг сурталчлах үзэсгэлэн, арга хэмжээнүүд жил бүр зохион байгуулагдаж буй арга хэмжээ нь олон нийтэд хүрч, соёл, уламжлалын томоохон арга хэмжээнүүд болж чаджээ.

Арав.Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх асуудлаар

Үнэлэх хэсэг	60 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага 60.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 60.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд зааснаар зохицуулах тул энэ хүрээнд дараах дэд сэдвийн хүрээнд судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Эрүүгийн хууль болон Зөрчлийн хууль Соёлын биет өвийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага ба бусад улсын туршлага; Соёлын биет өвд учруулсан хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх; СӨХТХ-ийн хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүй, түүнд хүлээлгэх хариуцлага.

СӨХТХ-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага оногдуулах, нөгөө талаас энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, соёлын өвийг хамгаалахтай холбогдох харилцааг Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн Хорин тавдугаар бүлэгт заасан “Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг”, Зөрчлийн тухай хуулийн Есдүгээр бүлэг, 9.7 дугаар зүйлд “Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих” хэмээн тусгайлан зохицуулсан.

*Судлаачийн дүгнэлт¹³²*Сүүлийн жилүүдэд манай улсад түүх соёлын дурсгалт зүйлтэй холбоотой гэмт хэргүүд үйлдэгдэх нь ихэслээ. Тухайлбал, Ашиг хонжоо хайгчид түүхийн дурсгалт газруудыг ухаж,*

¹³¹ Нүүдлийн соёл 72 дахь тал.

¹³² Д.Мөнхтуяа. “Олон улсын эрүүгийн эрх зүйн зарим асуудал” УБ., (2000), 109 дэх тал. Дам эшлэв.



сүйтгэх, соёлын ховор нандин бүтээлүүдийг хулгайлах, дээрэмдэх, залилан мэхлэх, завиих замаар олж авах, улмаар хил давуулан худалдах боллоо. Түүх соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлтийн арга, үйлдэл улам бүр нарийсан зохион байгуулалтад орж, өдөр ирэх бүр өргөжин тэлэх хандлагатай байна. Олон улсын шинжтэй гэмт хэргүүдийн дотор урлагийн бүтээл, хуучны ховор эд юмс хулгайлж, дамлан худалдах явдал үйлдэгдсэн тоогоороо мансууруулах бодис наймаалахын дараа оржээ.

Улсын хилээр соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, бусад эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэх тохиолдлын тухайд Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ын 18.5 дугаар зүйл (Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх)-ийн 3 дахь хэсэгт хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчилсан.

Харин соёлын биет өвийг хулгайлсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т “түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлсан эд зүйлийг хулгайлсан” бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан.

Соёлын өвийг хамгаалах, хууль тогтоомж зөрчсөн этгээдийн үйлдлийг гэмт хэрэг, зөрчилд тооцох, хариуцлага оногдуулах асуудлыг ийнхүү тусгайлан зохицуулсан нь соёлын өвийг гэмт халдагаас хамгаалахад чухал ач холбогдолтой боловч дараах нөхцөл байдлыг зайлшгүй анхаарах шаардлагатай байна.

Энэхүү судалгааг хийж гүйцэтгэх явцад соёлын өвд халдсан хүн, хуулийн этгээдэд хариуцлага оногдуулах харилцааг зохицуулсан Эрүүгийн хуулийн зохицуулалт хийдэлтэй, тодорхой төрлийн гэмт хэргийг зөрчлөөс ялган зүйлчлэхэд бэрхшээлтэй, тодорхой үйлдэлд оногдуулах хариуцлагыг давхардуулан зохицуулсан, СӨХТХ-ийн хэрэгжилт хангалтгүй, холбогдох журмууд батлагдаагүйгээс шалтгаалан тодорхой хууль зөрчсөн үйлдэлд хэрхэн хариуцлага оногдуулах нь ойлгомжгүй тохиолдлууд байгаа ажээ.

1. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль

Соёлын өвийг эрүүгийн эрх зүйн хамгаалалтад тусгайлан оруулсан боловч эрүүгийн эрх зүйн зохицуулалт хийдэл, зөрчилдөөнтэй, Зөрчлийн тухай хуулийн зохицуулалтаас ялгагдахгүй байгаа нөхцөл байдал нь шүүхийн практикт энэ төрлийн гэмт хэргийг ангилан зүйлчлэхэд бэрхшээл үүсгэж буй талаар тэмдэглэжээ.¹³³

Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэгт заасан Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг болон Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлд заасан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зөрчлийг харьцуулж үзвэл дараах хуулийн давхардал, хийдэл байгааг харж болно. Үүнд:

¹³³Ц.Алтангэрэл, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт-2019(Хууль зүйн магистрын зэрэг горилсон судалгааны ажил) (УБ, 2019), 3



Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах

д/д	Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) Хорин тавдугаар бүлэг. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	Зөрчлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)
Нэг.	25.1 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах 1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	9.7 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 5.Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан , эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 5-д “...**анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан**...” гэх томъёолол нь соёлын биет өвийг эвдсэн, гэмтээсэн хэлбэрээр илрэх боломжтой.

Иймд аливаа этгээдийн соёлын дурсгалт зүйлийг эвсэн, гэмтээсэн эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан үйлдлийг эрх бүхий байгууллагаас гэмт хэрэг эсхүл зөрчлийн аль болохыг тодорхойлоход бэрхшээлтэй нөхцөл байдлыг бий болгосон гэж үзэхээр байна.

Хоёр.	25.1 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах 1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	9.7 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 11.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээсэн , олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа, орчинд хадгалсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
-------	---	--

Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 11-т “...түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олдворыг **хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээсэн**...” хэмээн үйлдлийн шинж чанарыг тодорхойлжээ.Энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 25.1 дүгээр зүйлийн 1-т заасан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах” гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэх шинжээр¹³⁴-ээр уг зөрчлөөс ялгагдах боломжтой байна.

¹³⁴ Ц.Алтангэрэл, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт-2019 (Хууль зүйн магистрын зэрэг горилсон судалгааны ажил) (УБ, 2019), 20



Гэвч Зөрчлийн тухай хуулийн уг зохицуулалтад олдворыг хадгалах үүрэг хүлээсэн этгээд түүнийг хадгалах, судлахдаа санаатай үйлдлээр гэмтээсэн тохиолдолд хэрхэх тухайлсан зохицуулалт хийгээгүй байна.

Иймд энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг тодорхой ялгахын тул “...тухайн ажил үүргийг гүйцэтгэх явцдаа болгоомжгүйгээр...” гэх субъектив талын шинжийг тусгайлан хуульчлах шаардлагатай гэж үзэж байна.

Гурав.	25.1 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах 1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	9.7 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 12.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно
---------------	--	--

Өмнөх хэсэгтэй ижил байдлаар биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа “болгоомжгүй”-гээр гэх субъектив талын шинжийг тусгайлан хуульчлах шаардлагатай.¹³⁵

Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх

Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)	Зөрчлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)
25.3 дугаар зүйл.Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх 1.Соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 12.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

“Үрэгдүүлэх” гэх ойлголтын тухайд аливаа эд зүйлийг ажлын чиг үүргийн хүрээнд олж авсан этгээд үрэгдүүлэх боломжтой тул эдгээр хууль давхардуулан томьёолсон байдал гэмт хэргийн шинжтэй үйлдлийг зөрчлөөс ялгахаргүй болгож хуульчилсан гэж дүгнэж болохоор байна.

¹³⁵ Ц.Алтангэрэл, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт-2019 (Хууль зүйн магистрын зэрэг горилсон судалгааны ажил) (УБ, 2019), 35



Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах

Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)	Зөрчлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)
25.5 дугаар зүйл. Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах 1. Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	9.7 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 3. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдсан, эсхүл гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, эсхүл зуучилсан бол уг дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгон хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

СӨХТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.1-т “Соёлын биет өвийг түрээслэх, худалдах, худалдан авах, түр солилцох журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” хэмээн түүх, соёлын үнэт зүйлийг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой харилцааг зохицуулсан боловч өнөөдрийг холбогдох журам гараагүй байна.

Ийнхүү уг харилцааг зохицуулсан холбогдох журам батлагдаагүй нөхцөл байдлын улмаас соёлын биет өвийг хууль ёсоор эзэмшигч, өмчлөгч эд зүйлээ хуульд заасан журмын дагуу эдийн засгийн эргэлтэд оруулах боломжгүй, арилжаалах үйл явц далд хэлбэрээр явагдаж, бүртгэх, хяналтын тогтолцоо хэрэгжиж чадахгүй болох юм.

Соёлын биет өвийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх

Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)	Зөрчлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)
18.5 дугаар зүйл. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх 3. Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд олгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	9.7 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1. Хуульд заасны дагуу: 1.4. түүх, соёлын дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

СӨХТХ-д зааснаар түүх, соёлын дурсгалт зүйл эзэмшигч, өмчлөгч тэдгээрийг хилээр нэвтрүүлэхдээ зайлшгүй зөвшөөрөл авахаар хуульчилсан тул зөвшөөрөл аваагүй аливаа үйлдлийг хууль зөрчсөн гэж үзнэ. Өөрөөр хэлбэл түүх, соёлын дурсгалт зүйлийг зөвшөөрөл авалгүй хилээр нэвтрүүлсэн бол Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлийн 3-т “...улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж...” гэх нөхцөлд хамаарна. Иймээс Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 1.4-т заасныг уг хуулиас хасах нь зүйтэй.



2.Соёлын биет өвийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлага ба бусад улсын туршлага

Судалгааны энэ хэсэгт соёлын өвийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн иргэн, хуулийн этгээдэд хариуцлага оногдуулах ялын хэмжээг Эрүүгийн хуульд заасан бусад ижил, төрлийн гэмт хэрэг болон бусад улсын жишигтэй харьцуулах замаар ялын бодлого оновчтой байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах

Эрүүгийн хуулийн 25.1 дүгээр зүйлд заасан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах” гэмт хэрэг нь халдлагын зүйлээр мөн хуулийн 17.8 дугаар зүйлд заасан “Эд хөрөнгө устгах, гэмтээх” гэмт хэргээс ялгагдана.

Тодруулбал, “Эд хөрөнгө устгах, гэмтээх” гэмт хэргийн объект нэг бүрийн шинжээр тодорхойлогдох хүний хөдөлмөр шингэсэн эд хөрөнгө, мөнгө, бусад эдлэл хэрэглэл байх бол “Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах гэмт хэргийн халдлагын зүйл нь “түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өв”¹³⁶ байх шинжээр үнэ цэнэ, ач холбогдол нь ялгагдана.

Иймээс ч бусад улс орны тухайд энэ төрлийн гэмт хэрэгт тэмцэх ялын бодлого чанга буюу оногдуулах хариуцлагын хэмжээ ижил төрлийн бусад гэмт хэргээс харьцангуй өндөр байдаг ажээ. *Тухайлбал*, ХБНГУ-ын Соёлын өмчийн конвенцыг хэрэгжүүлэх тухай хуулийн 5 дугаар бүлгийн 20 зүйлд Аливаа этгээд санаатай хулгай, дээрэм буюу хууль бусаар, эсвэл конвенцын дагуу хамгаалагдсан соёлын эд хөрөнгийг санаатайгаар халдаж устгасан, гэмтээсэн бол гэмт хэрэг гэж үзэх бөгөөд 3 жил хорих эсхүл 5000 еврогоор торгох шийтгэл ногдуулна¹³⁷ гэжээ. БНХАУ-д энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох, 1-6 сар хүртэл хугацаагаар баривчлан саатуулах, эд хөрөнгийг нь хураах, зарим хэрэгт цаазаар авах ял оногдуулдаг байна.¹³⁸

Манай улсын тухайд энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлага болон ижил төрлийн гэмт хэрэгт оногдуулж буй хариуцлагын хэмжээг харьцуулж үзвэл:

Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга)	
25.1 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах 1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол <i>дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</i>	17.8 дугаар зүйл.Эд хөрөнгө устгах, гэмтээх 1.Бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, гэмтээсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол <i>дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</i>

¹³⁶ Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-ийг үзнэ үү.

¹³⁷ Д.Жигваагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Соёлын биет өвд учруулсан хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтын талаарх зарим орнуудын туршлага (Судалгааны эмхэтгэл), 304

¹³⁸ Мөн тэнд, 308



	17.11 дүгээр зүйл.Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх 1.Нийтийн эзэмшлийн зам харилцаа, цахилгаан, дулаан, холбоо, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмжийг болгоомжгүйгээр устгасан, гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсний улмаас бага хэмжээнээс дээш хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
--	--

Түүх соёлын дурсгалт зүйлийг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан этгээдэд оногдуулах ялын хэмжээ нь Эрүүгийн хуулийн 17.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Эд хөрөнгө устгах, гэмтээх” гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээтэй ижил байгааг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн болгоомжгүйгээр буюу ажлын чиг үүргээ гүйцэтгэх явцдаа соёлын биет өвийг устгасан гэмтээсэн үйлдэл нь СӨХТХ-ийг зөрчсөн үйлдэл болж Зөрчлийн тухай хуулийн дагуу шийдэгдэхээр хуульчилсныг өмнөх хэсэг тэмдэглэсэн.¹³⁹

Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх

Эрүүгийн 25.3 дугаар зүйлийн 1-т зааснаар соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн этгээдийг “*хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял*”-аар шийтгэхээр хуульчилсан.

Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хөрөнгө завших” гэмт хэргийн тухайд “*Бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг завшсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ*” гэж заасан.

Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн халдлагын зүйл нь түүх, соёлын дурсгалт зүйл байж ажлын чиг үүргээр хариуцан ашиглаж буй этгээдэд оногдуулах хариуцлага бусад төрлийн гэмт хэрэг оногдуулах санкцаас ялгамжтай байх бусад улсын жишгийг баримтлах ёстой боловч бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгийг завших гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялын хэмжээтэй мөн адил байхаар хуульчилжээ.

Соёлын өвийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг тухайн эд зүйлийг ажлын чиг үүргийн олж авсан этгээд үйлдэх боломжтой буюу соёлын өвийн салбарт ажиллаж байгаа мэргэжилтэнд хамаарах тул энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

ОХУ-ын Эрүүгийн тусгай ангийн “Өмчийн эсрэг гэмт хэрэг” гэсэн 21 дүгээр бүлгийн 164-р зүйлийн 164.1-т “Түүх, шинжлэх ухааны болон урлаг соёлын хосгүй үнэт

¹³⁹ ... талаас үзнэ үү.



буюу үнэт эд зүйл, бичиг баримтыг ашиглан шамшигдуулсан болон түүний хэлбэрээс үл хамааран 500 мянга хүртэл рублиэр эсхүл ялтны 3 жил хүртэлх хугацааны цалин хөлс түүнтэй тэнцэх хэмжээний орлогоор торгох буюу торгохгүйгээр 6-10 жил хорих ял шийтгэнэ” хэмээн хуульчилжээ.¹⁴⁰

Хулгайлах

Соёлын биет өвийг хулгайлсан тохиолдолд хэрхэх талаар харилцааг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2-т “түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж” энэ гэмт хэргийг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ хэмээн хуульчилсан байна.

Уг асуудлаар судлаачид “түүх, соёлын дурсгалт зүйл, соёлын биет өвийг хулгайлсан үйлдлийг ЭХТА-ийн 17.1.2 дахь хэсэгт бус гурав дахь хэсэг онц хүндрүүлэх нөхцөл болгон хуульчлах... хүн байнга амьдрах орон байранд нэвтэрч үйлдсэн тохиолдолтой адил хэмжээнд үзэж ял шийтгэхээр байгаа нь тухайн халдлагын зүйлийн үнэ цэнэ ач холбогдлыг илтэд бууруулсан заалт гэж үзэхэд хилсдэхгүй”¹⁴¹ хэмээн санал, дүгнэлт тэмдэглэсэн байна.

3.Соёлын биет өвд учруулсан хохирлыг тооцох, нөхөн төлүүлэх

Эрүүгийн хуулийн Хорин тавдугаар бүлэгт хуульчилсан Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн тухайд хэдий хэмжээний хохирол учирсан эсэхээс үл шалтгаалан объектив талын шинжийг хангаснаар тухайн гэмт хэргийг үйлдсэнд тооцно. Учир нь уг гэмт хэргийн халдлагын зүйл нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өв байдаг шинжээр ялгагдана.

Соёлын өвд учирсан хохирлыг тооцсоны үндсэн дээр нөхөн төлбөр болон хүлээлгэх хариуцлагын хэмжээг шүүх тодорхойлох тул соёлын өвийн эдийн засгийн үнэлгээ буюу соёлын биет өвийн үнэлгээ хийх аргачлал, шинжээчийн мэдлэг, ур чадвар чухал ач холбогдолтой.¹⁴²

Гэвч энэ талаарх харилцааг зохицуулсан хууль тогтоомж, журам болон шүүхийн практикийг судалж үзвэл зайлшгүй засаж залруулах, харилцааг хуулиар оновчтой зохицуулах шаардлага байгаа болох нь харагдаж байна.

Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг үйлдлийг зүйлчлэх болон соёлын өвд учруулсан хохирлыг бодитоор тооцож, учирсан хохирлыг барагдуулах соёлын биет өвийн зэрэглэл болон үнэлгээний асуудлыг зайлшгүй шалгаж тогтоох шаардлагатай.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 25.1 дүгээр зүйлд заасан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах”, 25.2 дугаар зүйлд заасан “Түүх, соёлын дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах”, 25.6 дугаар зүйлд заасан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон

¹⁴⁰Ц.Наранцэцэг, Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт (Соёлын өвийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн жишээн дээр)-2016, (Хууль зүйн магистрын ажил) (УБ, 2016), 42

¹⁴¹ Ц.Алтангэрэл, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт-2019(Хууль зүйн магистрын эрэг горилсон судалгааны ажил) (УБ, 2019), 70

¹⁴² “Соёлын өвийн үнэлгээ” гэх бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү.



хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх” гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн нь соёлын өвийн үнэт зүйлийн болон хамгаалалтын зэрэглэлээс хамаарна.

Гэвч өмнөх судалгааны хэсэг дурдсанаар Монгол Улсад соёлын өвийн үнэлгээг хэрхэн хийх журам СӨХТХ-д заасан журмын дагуу өнөөдрийг хүртэл батлагдаагүй, соёлын биет өвийг эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн үнэлгээг хэрхэх талаар харилцааг орхигдуулсан, хууль тогтоомжууд хоорондоо зөрчилтэй байгааг талаар судалгааны үр дүнг тодорхой дурдсантай танилцана уу.¹⁴³

Шүүхийн практикт соёлын биет өвд үнэлгээ тогтоох харилцааг Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/140 тушаалаар батлагдсан “Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”¹⁴⁴-аар зохицуулж байгаа боловч түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн дансны үнэ шинэчлэн тогтоох комиссыг тухайн байгууллагын удирдлагын шийдвэрээр томилж, комисст нягтлан бодогч, сан хөмрөгч, өмч хамгаалах байнгын зөвлөл, техникийн комиссын төлөөллийг оролцуулахаар¹⁴⁵ зохицуулсан нь соёлын биет өвийг үнэн зөв, бодитой үнэлж чадаж байгаа эсэхэд эргэлзээ үүсгэж байгааг тэмдэглэсэн билээ.

4.СӨХТХ-ийн хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүй, түүнд хүлээлгэх хариуцлага

СӨХТХ-ийн зохицуулалтыг судалж үзэхэд хуулийн зорилтод тодорхойлсон соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, сэргээн уламжлуулах, өвлүүлэх, өмчлөх, эзэмших, ашиглах, сурталчлахтай холбогдсон харилцааг нийт Арван гурван бүлэг, 61 зүйл, 211 хэсэг, 288 заалттай¹⁴⁶ баталжээ.

Эдгээрээс соёлын өвийг хамгаалах, хадгалах, үнэлэх, сэргээн засварлах, сурталчлахтай холбоотойгоор аливаа этгээдэд үүрэг болгосон, хориглосон буюу соёлын өвийг хамгаалах чиглэсэн зохицуулалт нь 40 гаруй хэсэг, 50 орчим заалтаас бүрдэж байна.¹⁴⁷

Энэхүү судалгааны Хавсралт 2-д байх “Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүйн жагсаалт, хүлээлгэх хариуцлага” гэх судалгаанаас үзэхэд СӨХТХ-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулахаас гадна СӨХТХ-иар тодорхой төрлийн үйлдэлд хариуцлагын арга хэмжээ авахаар зохицуулсан болохыг харж болохоор байна.

Тухайлбал, СӨХТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.10-т зааснаар Соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага нь “...зөвшөөрөлд заасан хугацаанд сэргээн засварлах ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж, тайланг тухайн жилд багтаан соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй” гэж зохицуулсан бөгөөд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд соёлын асуудал

¹⁴³ Соёлын өвийн үнэлгээ” гэх бүлгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

¹⁴⁴ «Журам батлах тухай (Түүх, соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам)», Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/140 тушаал

¹⁴⁵ Дээрх журмын 2 дагаар зүйлд заасны дагуу

¹⁴⁶ Жич: СӨХТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болгосон зүйл, хэсэгт, заалтыг оролцуулсан тоо болно.

¹⁴⁷ СӨХТХ-иар хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүйн жагсаалтыг гаргаж, эдгээрийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг харуулсан хүснэгтийн энэхүү судалгааны Хавсралт ...-д оруулсан болно.



эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ гэжээ.¹⁴⁸

Түүнчлэн СӨХТХ-ийн зөрчсөн зарим үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон СӨХТХ-д тусгаагүй орхигдуулсан болохыг харж болно.

Тухайлбал, СӨХТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1-т “Соёлын өвийн бүртгэл мэдээллийн сангийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд ашиглуулж болно. Мэдээллийг ашиглуулахдаа өмчлөгч, эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хөндөж үл болно” хэмээн соёлын биет өвийг өмчлөгч, эзэмшигчийн эрх, ашгийг хамгаалахад чиглэсэн зохицуулалт оруулсан боловч мэдээлэл ашиглагч нь уг заалтыг зөрчиж олж авсан мэдээллийг эсрэг ашигласан тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэхийг хуульчлаагүй орхигдуулсан байна.

СӨХТХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.3-т “Соёлын биет өв алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлэх арга хэмжээ авна” хэмээн зохицуулсан боловч мөн адил хүлээлгэх хариуцлагыг хуульчлаагүй.

Иймээс энэ мэт тохиолдлуудад хариуцлага хүлээлгэх эсэх, хүлээлгэх бол хариуцлагын ямар арга хэмжээ авах зэргийг цаашид анхаарах нь зүйтэй болно.

Соёлын өвийг хамгаалахад чиглэсэн нэгэн чухал зохицуулалт нь СӨХТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8-д “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна” гэх боловч үүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд оруулаагүй байна.

№	Ярилцлага
1.	СӨХТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэгт нэг ийм заалт байдаг юм. Ялангуяа уул уурхайтай холбогдуулаад, жишээлбэл Манзуширын хийд рүү асфальтан зам тавьсан юм. Баахан булшин дээгүүр гарчихсан. Тэрийг хүмүүс мэдээд Ковидын үед зураг хөргийг нь над руу явуулсан. Төв аймаг руу бичиг явуулаад тэр үед мэргэжлийн хяналт дотор соёлын хяналт гэж байсан, Наранцэцэг ч билүү эгчтэй холбогдоод, тэр аймгийнх нь тухайн үедээ Боловсрол, соёлын газрын мэргэжилтнийг нь дагуулаад бөөндөө очлоо. Тэгээд энэ хууль яахгүй байна гэсэн нөгөөдүүл чинь замын компаниа дуудчихсан бөөн л 10, 20 хүн болоод л. Захиалагч юугаа хийлгэх ёстой гэсэн заалт байгаагүй байгаа байхгүй юу. 27.9. Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна гээд, тэгээд яриад байсан чинь Төв аймгийн ЗДТГ захиалагч нь болж таардаг юм. Жишээлбэл, зам тавьж байгаа, явж байхад та нар бараг энд тэнд хардаг л байх, энэ булшин дээгүүр энэ хиргисүүр дээгүүр зам гарчихсан тэгээд ингээд жаахан судлаад үзэнгүүт Зам тээврийн хөгжлийн яам байдаг ч юм уу, ерөөсөө улсын энэ байгууллагууд мөрддөггүй нэг ийм заалт байгаа түгээмэл байдаг.

Энэ тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулсны улмаас түүх, соёлын дурсгалт зүйлийн анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан энэ мэт тохиолдлууд олон гарч байгааг салбарын мэргэжилтнүүд хэлж байгааг анхаарч, уг харилцааг зохицуулах шаардлагатай байна.

¹⁴⁸ Соёлын өвийг хамгаалах тухай хууль, sec 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг.



Хавсралт 1: Бүгд найрамдах Солонгос Улсын Археологийн судалгаа, байгалийн болон биет бус соёлын өвийн судалгаа

1. Археологийн судалгаа, малтлага

1.1 Судалгааны зорилго

Археологийн судалгаа нь балар эртний үеэс орчин үе хүртэлх туурь, дурсгалыг малтах, шинжлэх замаар Солонгосын соёлын түүхэн урсгалыг илрүүлэхийг зорьдог. Үүгээр түүхийн баримтад дутуу байгаа баримтуудыг нөхөж, соёлын өвийн менежмент, боловсролын талаар нотлох баримтуудыг гаргадаг.

1.2 Судалгааны үндсэн чиглэл, үйл ажиллагаа

Түүхэн дурсгалт газруудын малтлага

-Гурван улсын үеийн эртний булш, балар эртний дурсгалт газрууд, Жусон гүрний үеийн амьдралын дурсгалуудыг малтсан.

-Малтсан олдвор, балгаснуудын шинж чанарыг тодорхойлох замаар соёлын шинж чанарыг эрин үе, бүс нутгаар нь шинжлэх. Жишээ нь: Шилла хааны булш, Бакжэгийн хаан Мюрёнгийн булш зэрэг томоохон балгас малтсан.

Дижитал археологийн судалгаа

-3D сканнер болон дрон гэрэл зургийн тусламжтайгаар түүхэн дурсгалт газруудыг дижиталаар баримтжуулах.

-Эртний булш, туурь дээр 3D сэргээн засварлах ажил хийж эх хадгалалтын судалгааг хийх.

Археологийн материалыг хадгалах, нөхөн сэргээх

-Зэврэлтээс урьдчилан сэргийлэх, малтсан олдворуудыг сэргээх зорилгоор хамгааллын боловсруулалтын технологийг хөгжүүлэх Жишээ нь: Хүрэл эдлэлийн исэлдэлтийн эсрэг эмчилгээ, керамик эдлэлийн ан цавыг нөхөн сэргээх.

1.3 Судалгааны (бодит) жишээ

Кёнжү Даереунвон малтлагын төсөл

-Шиллагийн үеийн эртний булшнуудыг малтаж урьд өмнө олдоогүй хааны дурсгалын судалгаа

-Тухайн үеийн амьдралын хэв маяг, оршуулгын соёлыг дурсгалт зүйлсээр дамжуулан сэргээх.

Ганвондо дахь эртний дурсгалт газруудын судалгаа

-Эрт балар эртний чулуун багаж, хэрэгслийг малтах замаар хүний амьдралын эхэн үеийг судлах.

1.4 Судалгааны үр дүн



-Түүхийн дурсгалт газруудыг сэргээн засварлах, малтлага хийх ажлын үр дүнг үндэсний түүхийн боловсрол, аялал жуулчлалын эх сурвалж болгон ашигладаг.

-Эрдэм шинжилгээний сэтгүүлд илтгэл тавьж, түүхийн дурсгалт газар, музейн үзэсгэлэнгүүдээр дамжуулан олон нийтэд хүргэдэг.

2.Байгалийн өв, соёлын биет бус өвийн судалгаа

2.1 Судалгааны зорилго

Байгалийн өв, биет бус соёлын өвийн судалгаа нь экологийн үнэт зүйл, уламжлалт соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилготой. Байгаль, хүн төрөлхтний эв найрамдалтай өвийг судалж, улмаар байгаль орчныг хамгаалах, соёлын өвөрмөц байдлыг хадгалдаг.

2.2 Байгалийн өвийн судалгаа

Байгалийн өвийн малтлага, судалгаа

-Геологийн өндөр үнэ цэнэтэй, байгалийн дурсгалт газруудын менежмент;

-Ховор амьтан, ургамлын амьдрах орчныг хамгаалах, экосистемд хяналт тавих.
Жишээ нь: Чөжүгийн галт уулын арал, лаавын хоолойн судалгаа

Байгаль орчныг хамгаалах технологийн хөгжил

-Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас байгалийн өвийг алдахаас сэргийлэх технологийн судалгаа. Жишээ нь: Baekdudaegan экологийн тэнхлэгийг нөхөн сэргээх, ургамлын төрөл зүйлийг нөхөн сэргээх төсөл

2.3 Соёлын биет бус өвийн судалгаа

Соёлын биет бус өвийн малтлага, баримтжуулалт

-Уламжлалт арга барил, урлаг, наадам гэх мэтийг системтэйгээр судалж, тэмдэглэж авдаг.

-Амны бичлэг, дүрс бичлэгээр уламжлалт соёлоо өвлүүлдэг. Жишээ нь: Мастер пансори дуучдын диктант бичиж, олон нийтийн боловсролын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх

Өв залгамжлагчдыг бэлтгэх, дэмжих

-Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг бэлтгэх, өвлүүлэн үлдээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Жишээ нь: Шавар урлагчид ур чадвараа өвлүүлэх, залгамжлагчдыг сургах.

2.4 Судалгааны (бодит) жишээ

Чөжү Хаенёогийн соёлын судалгаа

- Чөжүгийн эмэгтэй шумбагчдын амьдрал, ажил үйлсийг судалж, ЮНЕСКО-гийн биет бус соёлын өвд бүртгэсэн.
- Эмэгтэй шумбагчдын аман мэдээллийг бүртгэж мэдээлэл дамжуулах төлөвлөгөө гаргадаг.

Багт бүжгийг сэргээх төсөл

- Багт бүжгийн ялгааг бүс нутгаар нь судалж, анхны хэлбэрийг нь сэргээж, сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашигладаг.

2.5 Судалгааны үр дүн

-Соёлын биет бус өвийг системтэйгээр бүртгэж, хадгалж хамгаалах нь нутгийн соёлыг сэргээхэд хувь нэмэр оруулдаг.

-ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгүүлэх замаар олон улсын мэдлэгийг дээшлүүлдэг байна.

Соёлын өвийн үндэсний хүрээлэн нь Солонгос улсын өвийг хамгаалж, археологи, байгалийн өв, биет бус соёлын өвийн судалгааг хийж, хойч үедээ өвлүүлэн үлдээх үндэс суурийг тавьдаг. Түүнчлэн энэхүү судалгааны үр дүн нь соёлын бодлогыг бий болгоход хувь нэмэр оруулж, олон нийттэй харилцах замаар соёлын өвийн үнэ цэнийг сурталчилдаг.

3.Археологи, байгалийн өв, биет бус соёлын өвтэй холбоотой судалгаа, хамгааллын үйл ажиллагаа нь дотоодын болон олон улсын янз бүрийн хууль тогтоомжийн үндсэн дээр хэрэгждэг. Соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэн нь дараах хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

1. Археологитой холбоотой хууль, тогтоомжууд

1.1 Соёлын өвийг хамгаалах тухай хууль (문화재보호법¹⁴⁹) нь 2014 оны 08 дугаар сарын 29-ны өдөр батлагдсан бөгөөд нийт 12 бүлэг 104 зүйлтэй. Энэ хууль нь археологийн дурсгал болон эд өлгийн зүйлийг малтах, судлах, бүртгэх, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан суурь хууль юм.

Булш болон оршуулгын байгууламжыг хамгаалах(매장문화재 보호 및 조사에 관한 법률):¹⁵⁰ Түүхэн дурсгалт газруудыг малтахад зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд зөвшөөрөлгүй малтлага хийх нь хууль бус үйлдэл юм.

Төрийн өмчлөлийн зарчим: Малтсан олдворууд төрийн өмч бөгөөд судалгаа хийлгэх болон хамгаалахын тулд тусгай байгууллагад итгэмжлэл олгодог.

1.2 Дэлхийн өвийн конвенц (Юнескогийн конвенц)

Энэ бол археологийн дурсгалт газруудыг Юнескогийн Дэлхийн өвд бүртгүүлэхийн тулд Солонгосын засгийн газрын мөрддөг олон улсын протокол юм. Жишээ нь: Кёнжүгийн түүхэн дурсгалт газрууд, Гочан, Хвасун, Ганхва долмен зэрэг газрууд Дэлхийн өвийн конвенцийн дагуу хамгаалагдсан байдаг.

¹⁴⁹ <https://www.law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=154258#0000>

¹⁵⁰ <https://www.law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=150706#0000>



2. Байгалийн өвтэй холбоотой хууль тогтоомж

2.1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль (**자연환경보전법**)¹⁵¹ нь 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан нийт 7 бүлэг 66 зүйлтэй хууль юм.

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

- Тодорхой газар нутаг эсвэл экосистемийг экологийн болон ландшафтын хамгаалалтын бүс гэж тодорхойлж, хамгаална. Жишээ нь: Баянхонгор тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолт

3. Соёлын биет бус өвтэй холбоотой хууль тогтоомж

3.1 Соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах тухай хууль (**무형문화재 보전 및 진흥에 관한 법률**)¹⁵² нь Солонгосын биет бус соёлын өвийг системтэйгээр хадгалж хамгаалах, үнэт зүйлийг өвлөн уламжлан хөгжүүлэх зорилгоор батлагдсан хууль юм. Энэ хууль нь соёлын биет бус өвийг тодорхойлох, сурталчлах, үндэсний болон олон улсын хэмжээнд хамгаалах асуудлыг тусгайлан авч үздэг.

3.2 Соёлын биет бус өвийг хамгаалах тухай Юнескогийн конвенц Энэ бол олон улсын биет бус соёлын өвийг хамгаалах, дамжуулах конвенц юм. Солонгос улс пансори, ариранг, кимчи зэрэг соёлыг Юнескогийн биет бус соёлын өвд бүртгүүлснээр хамгаалдаг.

4. Холбогдох бусад хууль, захирамж

- Музей, галерейг сурталчлах тухай хууль (**박물관 및 미술관 진흥법**)¹⁵³ нь 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан. Нийт 9 бүлэг 35 зүйлтэй. Малтсан олдворыг зохион байгуулах, үзэсгэлэн гаргахтай холбоотой хууль юм.

- Соёлын өвийг сэргээн засварлах тухай хууль (**문화재수리 등에 관한 법률**)¹⁵⁴ нь 2015 оны 6 дугаар сарын 28-нд батлагдсан. Нийт 6 бүлэг 62 зүйлтэй. Соёлын өвийг сэргээн засварлах техникийн болон эрх зүйн стандартыг энэ хуулиар зохицуулсан.

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (**환경영향평가법**)¹⁵⁵ нь 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр нийт 9 бүлэг 76

¹⁵¹<https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EC%9E%90%EC%97%B0%ED%99%98%EA%B2%BD%EB%B3%B4%EC%A0%84%EB%B2%95>

¹⁵²[https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%AC%B4%ED%98%95%EB%AC%B8%ED%99%94%EC%9E%AC%EB%B3%B4%EC%A0%84%EB%B0%8F%EC%A7%84%ED%9D%A5%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/\(15173\)](https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%AC%B4%ED%98%95%EB%AC%B8%ED%99%94%EC%9E%AC%EB%B3%B4%EC%A0%84%EB%B0%8F%EC%A7%84%ED%9D%A5%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0/(15173))

¹⁵³<https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%B0%95%EB%AC%BC%EA%B4%80%EB%B0%8F%EB%AF%B8%EC%88%A0%EA%B4%80%EC%A7%84%ED%9D%A5%EB%B2%95>

¹⁵⁴<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsiSeq=169497#0000>

¹⁵⁵<https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%ED%99%98%EA%B2%BD%EC%98%81%ED%96%A5%ED%8F%89%EA%B0%80%EB%B2%95>



зүйлтэй. Хөгжлийн төслүүдийн байгалийн өвд үзүүлэх нөлөөллийн урьдчилсан үнэлгээг энэ хуулиар зохицуулдаг.

-Соёлын өвийг хадгалах, ашиглах тухай хууль (문화유산의 보존 및 활용에 관한 법률)¹⁵⁶ нь 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан. 12 бүлэг 104 зүйлтэй.

¹⁵⁶ <https://www.law.go.kr/LSW/lsInfoP.do?urlMode=lsInfoP&lsId=001607#0000>



Хавсралт 2: Соёлын өвийг хамгаалах тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүйн жагсаалт, харьцуулалт

Бүлэг	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зүйл, хэсэг, заалт	Хамаарах этгээд	Хүлээлгэх хариуцлага
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ	10 дугаар зүйл.Соёлын биет өвийн даатгал 10.1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг үзэсгэлэнд оролцуулах, сэргээн засварлах, судалгаа шинжилгээ хийлгэх зорилгоор Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд заавал даатгуулна. 10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаас бусад тохиолдолд соёлын биет өвийг даатгуулж болно.	Хилээр нэвтрүүлэх эрх бүхий этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 5.Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	20 дугаар зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо 20.2.Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санг соёлын төвд; аймгийн бүртгэл, мэдээллийн санг орон нутгийн музейд; нийслэлийн бүртгэл, мэдээллийн санг нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын асуудал хариуцсан нэгжид; улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг Соёлын өвийн үндэсний төвд тус тус бүрдүүлж, хадгална.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙН БҮРТГЭЛ	20 дугаар зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо 20.6.Дараах аж ахуйн нэгж, байгууллага бүртгэл, мэдээллийн санг заавал бүрдүүлнэ: 20.6.1.Монголбанк; 20.6.2.дурсгалт газрын хамгаалалтын захиргаа; 20.6.3.музей, галерей, номын сан, сүм хийд; 20.6.4.эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны лаборатори. 20.6.5.үндэсний төв архив.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



	20 дугаар зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо 20.8.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх бөгөөд түүнд агуулагдах мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байна.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	20 дугаар зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоо 20.10.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн байрлал, нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг тухайн санг бүрдүүлсэн байгууллага хариуцна.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	21 дүгээр зүйл.Соёлын өвийн бүртгэлийн бүрдэл 21.4.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн бүртгэлийг хуульд зааснаас бусад үндэслэлээр дамжуулах, ашиглуулах, хувилах, үрэгдүүлэх болон стандартын бус орчинд хадгалахыг хориглоно.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



	22 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх 22.2.Нийтийн өмчийн соёлын биет өвийн талаарх мэдээллийг бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгэнэ.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.2.соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	22 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх 22.6.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангаас мэдээлэл хасахыг хориглоно.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	23 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх хугацаа 23.1.Соёлын өвийг нээж, илрүүлсэн байгууллага, иргэн тухайн нутаг дэвсгэрийн бүртгэл, мэдээллийн санд 15 хоногийн дотор мэдэгдэж, анхан шатны бүртгэл хийлгэнэ. 23.2.Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан нь жилд дөрвөн удаа сум, дүүргийн, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд хоёр удаа аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд нэг удаа улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус тус тайлангаа хүргүүлнэ.	Иргэн, байгууллага	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.2.соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



	23 дугаар зүйл.Соёлын өвийг бүртгэх хугацаа. 23.2.Байгууллагын бүртгэл, мэдээллийн сан нь жилд дөрвөн удаа сум, дүүргийн, сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд хоёр удаа аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан нь жилд нэг удаа улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус тус тайлангаа хүргүүлнэ.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.1.соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлээгүй, эсхүл уг сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал, мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг хангаагүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	24 дүгээр зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах 24.1.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд ашиглуулж болно. Мэдээллийг ашиглуулахдаа өмчлөгч, эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хөндөж үл болно. <u>/Энэ хэсэгт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u>	Ашиглагч	-
	24 дүгээр зүйл.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглах 24.3.Соёлын биет ов алдагдсан тохиолдолд соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага холбогдох мэдээллийг хил, гааль, цагдаагийн байгууллагад нэн даруй хүргүүлэх арга хэмжээ авна. <u>/Энэ хэсэгт 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u>	Бүртгэл, мэдээллийн санг хариуцсан байгууллага	-
	25 дугаар зүйл.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын кадастр, өмчлөх, эзэмших эрхийн бүртгэл 25.1.Түүх, соёлын үл хөдлөх дурсгал, түүний оршин байгаа газрыг өмчлөгч, эзэмшигч нь эд хөрөнгийн эрхийн болон газрын кадастрын улсын бүртгэлд бүртгүүлнэ.	Өмчлөгч, эзэмшигч	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.2.соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ТАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙН СУДАЛГАА	27 дугаар зүйл.Соёлын өвийн судалгаа 27.8.Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 27 дугаар зүйл. Соёлын өвийн судалгаа 27.10.Урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулаагүй нь газар эзэмшүүлэх шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.
	27¹ дүгээр зүйл.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл <u>/Энэ зүйлийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> 27¹.2.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд зөвшөөрөлд заасан хугацаанд судалгааны ажлыг гүйцэтгэж, тайланг тухайн жилд багтаан соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй. <u>/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u>	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 27 дугаар зүйл. Соёлын өвийн судалгаа 27¹.4.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээд энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвшөөрлийг хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ. <u>/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u>
	28 дугаар зүйл.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхэд хориглох зүйл 28.1.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхэд дараах зүйлийг хориглоно: 28.1.1.геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан, булаг, бүрд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсгийг гэмтээх; 28.1.2.тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх; 28.1.3.судалгааны үр дүнд хохирол учруулж болзошгүй техник, тоног төхөөрөмж ашиглах; 28.1.4.малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээх.	Зөвшөөрөл эзэмшигч	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 10.Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийхдээ: 10.1.геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан, булаг, бүрд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсгийг гэмтээсэн; 10.2.тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэсэн; 10.3.судалгааны үр дүнд хохирол учруулж болзошгүй техник, тоног төхөөрөмж ашигласан; 10.4.малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



	30 дугаар зүйл.Олдвор 30.2.Олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний эх төрх, бүрэн бүтэн байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээхийг хориглоно. <u>/Энэ хэсэгт 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u> 30.3.Олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа, орчинд хадгалахыг хориглоно. 30.4.Олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 1.Хуульд заасны дагуу: 1.2.соёлын өвийг хуульд заасан хугацаанд бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй; ...нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 11.Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олдворыг хадгалах, хамгаалах, судлахдаа түүний анхны төрх байдал, хэлбэр, шинж чанарыг алдагдуулж гэмтээсэн, олдворыг стандартын шаардлага хангаагүй өрөө тасалгаа, орчинд хадгалсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
ЗУРГАДУГААР БҮЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙГ ЭЗЭМШИХ, АШИГЛАХ, ӨМЧЛӨХ	32 дугаар зүйл.Төрийн өмчийн соёлын биет өвийг эзэмшигчийн эрх, үүрэг 32.2.Соёлын биет өвийг эзэмшигч дараах үүрэг хүлээнэ: 32.2.1.соёлын өвийн бүртгэл хөтөлж, бүртгэл, мэдээллийн сан үүсгэх; 32.2.2.дээд шатны бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх; 32.2.3.бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн соёлын өвийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүртгэх; 32.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах; 32.2.5.соёлын биет өв алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тухайн шатны бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэх; 32.2.6.өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр соёлын биет өвийг сэргээн засварлах, бусдад ашиглуулахгүй байх.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 5.Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



	33 дугаар зүйл.Соёлын биет өвийг өмчлөгчийн эрх, үүрэг 33.2.Соёлын биет өвийг өмчлөгч иргэн, хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ: 33.2.1.соёлын өвийн гарал үүслийн байдлыг тодорхойлох; 33.2.2.харьяалах аймаг, нийслэлийн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх; <u>/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u> 33.2.3.худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд мэдэгдэх; 33.2.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр гаргахад зохих журмын дагуу зөвшөөрөл авах; 33.2.5.алдагдаж, үрэгдсэн тохиолдолд нэн даруй тухайн шатны Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан, Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх; 33.2.6.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавих; 33.2.7.түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд бэлэглэх, өвлүүлэх зэргээр түүний өмчлөлд шилжүүлэхгүй байх.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 5.Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
--	---	---	---



	35 дугаар зүйл.Соёлын биет өвийг худалдах, худалдан авах 35.4.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд худалдахыг хориглоно. 35.5.Палеонтологи, археологийн олдворыг худалдахыг хориглоно.	Иргэн, хуулийн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 3.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах анхны саналыг төрд тавихгүйгээр худалдсан, эсхүл гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлсэн, эсхүл зуучилсан бол уг дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгон хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ 25.5 дугаар зүйл.Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах 1.Соёлын биет өвийн худалдааг хууль бусаар явуулсан, зуучилсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
	36 дугаар зүйл.Соёлын биет өвийг ашиглах 36.1.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана. 36.2.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 12.Соёлын биет өвийг сурталчлах, судалгаа, шинжилгээ хийх, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээсэн, эсхүл үрэгдүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй



	ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.,	тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ 25.3 дугаар зүйл.Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх 1.Соёлын биет өвийг завшсан, үрэгдүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <u>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u> 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
--	--	---



ДОЛДУГААР БҮЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО	38 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа 38.1.Соёлын өвд хохирол учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хориглоно: 38.1.1.түүх, соёлын дурсгалт газар түүний орчны бүсэд дэд бүтцийн барилга байгууламж барих, уул уурхай, газар тариалан эрхлэх, үйлдвэрлэл явуулах; 38.1.2.палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэхгүйгээр хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, тариалангийн талбай олгох, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулж газар олгох; 38.1.3.хуульд зааснаас бусад тохиолдолд нийтийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг өмчлөгчийн шийдвэргүйгээр өөр байгууллага, орчинд шилжүүлэн хадгалах, зөөж тээвэрлэх, хөдөлгөх; 38.1.4.улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд зар сурталчилгааны самбар, бичиг хадах, анхны хэлбэр төрх, хийц, бүтээцийг өөрчлөх.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 38 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа 38.2.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.1-д заасан хуулийн этгээдийн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 6.6, 6.7-д заасан судалгааг урьдчилан гүйцэтгэсэн ажлын дүгнэлтээр соёлын өвд эрсдэл учирч болзошгүй байгаа нь тогтоогдсон бол аж ахуйн үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно. Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 5.Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	38.3.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 8.Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад илэрсэн соёлын биет өвийг хамгаалах, мэдээлэх арга хэмжээ аваагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



НАЙМДУГААР БҮЛЭГ. ДҮРСГАЛТ ГАЗРЫГ ХАМГААЛАХ	43 дугаар зүйл.Хамгаалалтын бүсийн дэглэм 43.1.Хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 43.1.1.онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд нисэх онгоц буулгах; 43.1.2.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах; 43.1.3.мод, элс, хайрга, чулуу авах зэргээр байгалийн төлөв байдлыг өөрчлөх; 43.1.4.хот суурин, цахилгаан станц байгуулах; 43.1.5.тэсэлгээ хийх; 43.1.6.шинээр барилга байгууламж барих.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 7.Соёлын өвийн, эсхүл түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	44 дүгээр зүйл.Орчны бүсийн дэглэм 44.1.Орчны бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 44.1.1.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах; 44.1.2.хот суурин, цахилгаан станц байгуулах; 44.1.3.тэсэлгээ хийх.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 7.Соёлын өвийн, эсхүл түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	45 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт газар 45.3.Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд энэ хуулийн 38.1-д зааснаас гадна доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 45.3.1.газар, түүний хэвлийг хөндөх; 45.3.2.мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй мод бут, төрөл бүрийн ургамал тарих; 45.3.3.энэ хуулийн 45.5-д зааснаас бусад зорилгоор гэр, сууц, барилга, байгууламж барих; <u>/Энэ заалтад 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u> 45.3.4.мал бэлчээх; 45.3.5.онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд өөрөө явагч хэрэгсэл нэвтрүүлэх, нисэх онгоц буулгах; 45.3.6.ашигт малтмал эрэх, хайх, ашиглах; 45.3.7.мод, элс, хайрга, чулуу авах.	Хуулиар үүрэг хүлээлгэсэн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 7.Соёлын өвийн, эсхүл түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ	46 дугаар зүйл.Соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага 46.5.Соёлын биет өвийг зөвшөөрөлгүй сэргээн засварлахыг хориглоно.	Иргэн, хуулийн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 4.Соёлын биет өвийг сэргээн засварлах хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	46 дугаар зүйл.Соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага 46.10.Мэргэжлийн байгууллага, иргэн зөвшөөрөлд заасан хугацаанд сэргээн засварлах ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэж, тайланг тухайн жилд багтаан соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.	Зөвшөөрөл эзэмшигч	Соёлын өвийг хамгаалах тухай хууль 38 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалахтай холбоотой хориглох үйл ажиллагаа 46.12.Мэргэжлийн байгууллага, иргэн энэ хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон бол соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвшөөрлийг хүчингүй болгож, нийгэд мэдээлнэ. <u>/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 4.Соёлын биет өвийг сэргээн засварлах хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
АРАВДУГААР БҮЛЭГ. СОЁЛЫН ӨВИЙГ СУРГАЛЧЛАХ	50 дугаар зүйл.Соёлын өвийн үзэсгэлэн 50.5.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргах, музей байгуулахыг хориглоно.	Иргэн, хуулийн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 14.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлээгүй палеонтологи, археологийн олдвор, дурсгалаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үзэсгэлэн гаргасан, эсхүл музей байгуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгож хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
	52 дугаар зүйл.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх 52.15.Зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэгтэй:	Зөвшөөрөл эзэмшигч	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 5.Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, ашиглах талаар хуулиар тогтоосон хориглолт, журам, стандартыг зөрчсөн, эсхүл анхны



<u>/Энэ хэсгийг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> 52.15.1.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн аюулгүй байдлыг найдвартай хангах арга хэмжээ авах; <u>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> <u>/Энэ заалтын дугаарт 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u> 52.15.2.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг зөвшөөрөлд заасан нөхцөлөөр ашиглах; <u>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> 52.15.3.зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байх; <u>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> 52.15.4.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг зориулалтын дагуу ашиглах; <u>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> 52.15.5.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг даатгуулсан байх; <u>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> 52.15.6.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр нэвтрүүлсний дараа үрэгдсэн, хулгайлагдсан, эвдэрч гэмтсэн тохиолдолд даруй соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх; <u>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> 52.15.7.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд улсын хилээр буцаан авч ирэх; <u>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u> 52.15.8.түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг улсын хилээр буцаан авч ирснээс хойш таван хоногт багтаан тайланг бэлтгэж, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.	төрх, нэгдмэл цогц байдлыг алдагдуулсан, эсхүл зөвшөөрөлгүй хөдөлгөж, зөөж тээвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/ 25.6 дугаар зүйл.Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх 1.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. <u>/Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u> 2.Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хуулиар тогтоосон журмын дагуу тогтоосон хугацаанд улсын хилээр оруулж ирээгүй, эсхүл түүх, соёлын дурсгалт зүйлийг завшсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
--	---



	<u>/Энэ заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./</u>		
	53 дугаар зүйл.Соёлын биет өвийг хувиан олшруулах <u>/Энэ зүйлийн гарчигт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u> 53.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг 1:1 болон бусад масштабаар хувиан олшруулах зөвшөөрлийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.	Иргэн, хуулийн этгээд	Зөрчлийн тухай хууль 9.7 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих 9.Нийтийн өмчийн соёлын биет өвийг зөвшөөрөлгүй хувиан олшруулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.